



“ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ - 2” ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



From
the People of Japan



Save the Children

“ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ - 2” ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

АГУУЛГА

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	9
ТАЛАРХАЛ	10
СУДАЛГААНЫ БАГ	11
ХУРААНГУЙ	12
ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	12
ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	12
ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮР ДҮН	13
БҮЛЭГ НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	18
1.1 ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ	18
1.2 ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДИЗАЙН	18
1.3 ТҮҮВРИЙН СТРАТЕГИ БА ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ	19
1.4 ТУРШИЛТ СУДАЛГАА	22
1.5 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ	22
1.6 ӨГӨГДЛИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТ	23
1.7 ҮНЭЛГЭЭНИЙ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ	23
1.8 ҮНЭЛГЭЭНИЙ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ	24

БҮЛЭГ ХОЁР. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН БАГА АНГИАС ДУНД АНГИД ДЭВШИН СУРАЛЦАХ БЭЛТГЭЛ	25
2.1 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ДЭМЖЛЭГ ..25	
2.1.1 ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН СУРАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ	25
2.1.2 ЗОРИЛТОТ СУРГУУЛИУДЫН БАГА, ДУНД АНГИЙН СУРАГЧДЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДЭД ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХ	29
2.2 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН БАГА АНГИАС ДУНД АНГИД ДЭВШИН СУРАЛЦАХ БЭЛТГЭЛ ХАНГАЖ БУЙ БАЙДАЛ	38
БҮЛЭГ ГУРАВ. ЗОРИЛТОТ СУРГУУЛИУДАД ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДИЙГ ХҮЛЭЭН АВАХ БЭЛЭН БАЙДАЛ, БАГШ НАРЫН ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	45
3.1 СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАГШ НАРЫН МЭДЭЭЛЭЛ.....	45
3.2 ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БАГШ НАРЫН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ЧАДВАРТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, АХИЦ	48
3.3 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДИЙГ БАГА АНГИАС ДУНД АНГИД ДЭВШИН СУРАЛЦАХАД СУРГУУЛЬ, БАГШИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХ.....	54
БҮЛЭГ ДӨРӨВ. ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ ДАХЬ ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХЫН ӨӨРЧЛӨЛТ, АХИЦ.....	60
4.1 ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ, ХАНДЛАГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ	60
4.2 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДИЙН СУРАЛЦАХ ҮЙЛ ЯВЦАД ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХ.....	67
БҮЛЭГ ТАВ. ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ	71
5.1 ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ БОДЛОГО, ЖУРАМ.....	71
5.2 ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО БҮРДСЭН БАЙДАЛ	73
5.3 ДЭМЖЛЭГИЙН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	77
ДҮГНЭЛТ.....	79
САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	83
ХАВСРАЛТ	86

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Тоон судалгааны түүвэрлэлт	20
Хүснэгт 2.	Чанарын судалгааны түүвэрлэлт	21
Хүснэгт 3.	Туршилт судалгааны түүвэрлэлт	22
Хүснэгт 4.	Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн мэдээлэл (Анги, насаар).....	26
Хүснэгт 5.	Судалгаанд оролцсон 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн мэдээлэл (Анги, насаар).....	26
Хүснэгт 6.	Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээгүй сурагчдын мэдээлэл	28
Хүснэгт 7.	Судалгаанд оролцсон 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээгүй сурагчдын мэдээлэл	28
Хүснэгт 8.	Судалгаанд оролцсон сурагчдын ангид тусгай хэрэгцээтэй хүүхэд суралцдаг эсэх	29
Хүснэгт 9.	Ангийнхаа тусгай хэрэгцээтэй хүүхдэд туслах хэлбэрүүд, ангиар.....	31
Хүснэгт 10.	Тусгай хэрэгцээтэй хүүхдэд хичээлээ хийх, сургуульдаа явахад тулгарч буй хүндрэл бэрхшээл (Ангийн сурагчдын үнэлгээгээр).....	32
Хүснэгт 11.	Тусгай хэрэгцээтэй хүүхдэд хичээл, сургуульдаа явахад нь тулгарч байгаа хүндрэл бэрхшээл.....	32
Хүснэгт 12.	Тусгай хэрэгцээтэй найзад нь хамгийн их хэрэгтэй байгаа дэмжлэг	33
Хүснэгт 13.	Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж дэмжих талаар ангийн багш болон гэр бүлийнхний нь захиж хэлдэг зүйлс.....	35
Хүснэгт 14.	Сургуулийн багш, ажилтнууд, ангийн сурагчдын тусгай хэрэгцээтэй хүүхдэд хандах хандлага.....	36
Хүснэгт 15.	Ангийн хүүхдүүд нь тусгай хэрэгцээтэй найзтайгаа сургууль, ангийн үйл ажиллагаанд хамт байдаг эсэх.....	37
Хүснэгт 16.	Бага ангиас дунд ангид дэвшин суралцах бэлтгэл хангаж байсан эсэх.....	38
Хүснэгт 17.	Бага, дунд ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдэд гэр бүлийнхэн, ангийн хүүхдүүдийн тусалдаг байдал	40
Хүснэгт 18.	Тусгай хэрэгцээтэй хүүхдэд гэр бүлийнхэн нь тусалж дэмжих байдал (Бага, дунд ангиар).....	41

Хүснэгт 19.	Тусгай хэрэгцээтэй найздаа ямар үед, хэрхэн тусалдаг вэ? /олон сонголттой/	42
Хүснэгт 20.	Судалгаанд оролцсон багш нарын ерөнхий мэдээлэл, бага, дунд анги, анги даагаагүй байдлаар	46
Хүснэгт 21.	Анги даасан багш нарын анги дахь тусгай хэрэгцээтэй хүүхдийн тоо	47
Хүснэгт 22.	Судалгаанд оролцсон багш нарын анги дахь тусгай хэрэгцээтэй хүүхдийн тусгай хэрэгцээний төрөл /олон хариулттай/	48
Хүснэгт 23.	Тэгш хамруулах боловсролын талаарх багш нарын ойлголт (анги удирдсан эсэхээр)	48
Хүснэгт 24.	Тэгш хамруулах боловсролын талаарх дунд ангийн багш нарын ойлголт (Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг эсэхээр).....	49
Хүснэгт 25.	Тусгай хэрэгцээтэй хүүхэд гэж хэнийг хэлэх вэ? (Суурь судалгаа II, эцсийн үнэлгээний үр дүнгээр).....	49
Хүснэгт 26.	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах боломжтой эсэх талаарх багш нарын санал бодол	50
Хүснэгт 27.	Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах өөрийн мэдлэг, ур чадвараа үнэлсэн байдал (Анги удирдсан эсэхээр).....	51
Хүснэгт 28.	Сүүлийн 3 жилд тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан эсэх (Анги удирдсан эсэхээр).....	52
Хүснэгт 29.	Тэгш хамруулах боловсролын чиглэлээр зохион байгуулагдсан сургалтын үнэлгээ (Анги удирдсан эсэхээр)	53
Хүснэгт 30.	Сургалтаас эзэмшсэн мэдлэг, арга зүйгээ сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа байдал	53
Хүснэгт 31.	Бага ангиас дунд ангид дэвшин суралцах тусгай хэрэгцээтэй хүүхдэд сургууль, багшийн зүгээс хангаж буй бэлтгэл /бага, дунд ангийн багшаар/	55
Хүснэгт 32.	Бага ангиас дунд ангид дэвшин суралцах тусгай хэрэгцээтэй хүүхдэд сургууль багшийн зүгээс сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа / төслийн хэрэгжилтийн хугацаагаар/	32
Хүснэгт 33.	Багш нарын тэгш хамруулах боловсролын чиглэлээр туршлага солилцох үйл ажиллагаанаас судалсан мэдлэг, арга зүй.....	58
Хүснэгт 34.	Судалгаанд оролцсон эцэг эх, асран хамгаалагчдын мэдээлэл, бага, дунд ангиар.....	60
Хүснэгт 35.	Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн эцэг эхчүүдийн хүүхдийн нас, суралцдаг анги.....	61
Хүснэгт 36.	Судалгаанд оролцсон 6-9 дүгээр ангийн эцэг эхчүүдийн хүүхдийн нас, суралцдаг анги.....	62
Хүснэгт 37.	Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн хүүхдийн тусгай хэрэгцээний төрөл.....	62
Хүснэгт 38.	Тэгш хамруулах боловсролын талаарх эцэг эхийн ойлголт, суурь судалгаа, эцсийн үнэлгээний үр дүнгээр.....	64
Хүснэгт 39.	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой эсэх.....	64
Хүснэгт 40.	Сургалтад хамрагдсанаар эцэг эхчүүдийн мэдлэг ойлголт, хандлагад гарсан өөрчлөлт	67

Хүснэгт 41.	Тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургууль, ангиас зохион байгуулсан үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн оролцсон байдал.....	68
Хүснэгт 42.	Эцэг эхийн зүгээс тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн сурч боловсроход бэлтгэл ханган дэмжлэг үзүүлэх байдал	68
Хүснэгт 43.	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сурч, хөгжихөд эцэг, эхчүүдийн дэмжлэг үзүүлэх чадварт гарсан өөрчлөлт, АУБ нарын дүгнэснээр.....	69
Хүснэгт 44.	Тусгай хэрэгцээт хүүхдийг тэгш хамруулан сургах сургалтын тогтолцоо бүрдсэн байдлын үнэлгээ	73
Хүснэгт 45.	Төсөл хэрэгжсэнээр зорилтот сургуулиудад тусгай хэрэгцээт хүүхдийг сургах үйл ажиллагаанд гарсан үр дүн.....	74
Хүснэгт 46.	Зорилтот сургуулиудын сургалтын орчны тохируулга хийгдсэн байдал, багш нарын үнэлгээгээр.....	75
Хүснэгт 47.	Хүүхэд хөгжлийн төвөөр үйлчлүүлдэг давтамж, бага, дунд ангийн тусгай хэрэгцээт хүүхдийн хариултаар	75
Хүснэгт 48.	Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааны чиглэл, үр дүн.....	76
Хүснэгт 49.	4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээт боловсрол шаардлагагүй сурагчдын түүвэр...86	
Хүснэгт 50.	6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээт боловсрол шаардлагагүй сурагчдын түүвэр..86	
Хүснэгт 51.	4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээт хүүхдийн түүвэр	86
Хүснэгт 52.	6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээт хүүхдийн түүвэр.....	87
Хүснэгт 53.	Багш нарын түүвэр	87
Зураг 1.	Үнэлгээний дизайн.....	18
Зураг 2.	Түүврийн стратеги.....	19
Зураг 3.	Өгөгдлийн чанарын хяналтын процесс	23
Зураг 4.	Төслийн үнэлгээнд хамрагдсан сурагчдын тоо, анги, тусгай хэрэгцээтэй эсэхээр ..25	
Зураг 5.	Тусгай хэрэгцээтэй хүүхдийн ангийн сурагчдын тоо	26
Зураг 6.	Судалгаанд оролцсон тусгай хэрэгцээтэй хүүхдийн тусгай хэрэгцээний төрөл.....	27
Зураг 7.	Судалгаанд оролцсон тусгай хэрэгцээгүй сурагчдын ангийн хүүхдүүдийн тоо.....	28
Зураг 8.	Ангийнхаа тусгай хэрэгцээтэй хүүхдэд туслах бусад хүүхдийн болон өөрийн дэмжлэг, давтамж, ангиар.....	29
Зураг 9.	Ангийнхаа тусгай хэрэгцээтэй найздаа үзүүлдэг тусламж, дэмжлэг /олон сонголттой/.....	30
Зураг 10.	Анги удирдсан багш бүх хүүхдүүдтэй адил тэгш хандаж харилцах байдал, сурагчдын үнэлгээгээр	33
Зураг 11.	Анги, сургууль дээр болсон зүйлийнхээ талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцдаг эсэх	34
Зураг 12.	Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж дэмжих талаар ангийн багш, гэр бүлийнхэн нь захиж тайлбарладаг эсэх	34
Зураг 13.	Тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан сурагчдын мэдлэг, ойлголтод нь өөрчлөлт гарсан эсэх.....	37

Зураг 14.	Бага ангиас дунд ангид дэвшин суралцах талаар ангийн багш нь тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй ярилцаж байсан эсэх.....	38
Зураг 15.	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг анги дэвшин сурахад нь бэлтгэн ангийн багшийн зүгээс өгсөн мэдээлэл	39
Зураг 16.	Бага ангиас дунд ангид дэвшин сурахад бэлтгэж буй байдал (4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн хариултаар).....	39
Зураг 17.	Бага ангиас дунд ангид дэвшин сурахад тулгарч буй саад бэрхшээл	40
Зураг 18.	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд бусад хүүхдүүдтэй хамт суралцаж байгаадаа сэтгэл хангалуун байгаа эсэх, эцэг эхийн үнэлгээгээр.....	41
Зураг 19.	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн ангийнхныхаа харилцааг үнэлсэн байдал	42
Зураг 20.	Сургууль дээр нь тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусламж хүсэх шаардлага гарвал хэнд ханддаг вэ?	43
Зураг 21.	Анги дээрээ болон сургууль дээр болсон зүйлийнхээ талаар гэрийнхэнтэйгээ ярилцдаг эсэх.....	43
Зураг 22.	Анги даасан багш нарын хариуцан ажилладаг анги	47
Зураг 23.	Анги удирдсан багш нарын анги дахь сурагчдын тоо	47
Зураг 24.	Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нарын тусгай хэрэгцээтэй хүүхдэд багшлах арга зүйгээ үнэлсэн байдал.....	52
Зураг 25.	Тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан байдал (Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг эсэхээр).....	52
Зураг 26.	Тусгай хэрэгцээтэй хүүхдэд бага ангиас дунд анги руу дэвшин суралцахад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх байдал /олон сонголттой/	55
Зураг 27.	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд анги руу дэвшин суралцахад багшийн зүгээс сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх байдал /олон сонголттой/	56
Зураг 28.	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах чиглэлээр бусад туршлага солилцсон эсэх	57
Зураг 29.	Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн хүүхдийн тусгай хэрэгцээний мэдээлэл	62
Зураг 30.	Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн бэрхшээлийн зэрэг.....	63
Зураг 31.	Тэгш хамруулах боловсролын талаарх эцэг эхчүүдийн ойлголт	63
Зураг 32.	Эцэг, эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн боловсролтой холбоотой мэдлэг ойлголт	65
Зураг 33.	Тэгш хамруулах боловсролын талаар сургалтаас эзэмшсэн мэдлэгээ хүүхдүүдтэйгээ хуваалцсан эсэх	65
Зураг 34.	Сургалтад хамрагдсан эцэг эхчүүдийн мэдлэг, ойлголтод нь өөрчлөлт гарсан эсэх.....	66
Зураг 35.	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн сурч, хөгжихөд эцэг, эхчүүд оролцоо, дэмжлэг өөрчлөгдсөн эсэх	69
Зураг 36.	Хүүхэд хөгжлийн төвд сургалтын үйл ажиллагаа явуулдаг эсэх, тусгай хэрэгцээт хүүхэдтэй бага, дунд анги удирдсан багшаар	75
Зураг 37.	Дэмжлэгийн багийн үйл ажиллагааны үнэлгээ, багш нар.....	77

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АУБ	Анги удирдсан багш
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БЗД	Баянзүрх дүүрэг
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
БШУГ	Боловсрол, Шинжлэх Ухааны Газар
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БХДЗ	Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл
ГСТ	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МСХ	Мэргэжлийн социологичдын холбоо
ОУБ	Олон улсын байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СӨУЗ	Сурагчдын өөрөө удирдах зөвлөл
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
УБ	Улаанбаатар хот
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ХХТ	Хүүхэд хөгжлийн төв
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХБХЭМБНХК	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс
ХИС	Японы Хүүхдийг Ивээх Сан
ХБХЭЭХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо
ЧД	Чингэлтэй дүүрэг
САТИ	Компьютерт суурилсан судалгаа авах арга
ТАРИ	Таблетад суурилсан судалгаа авах арга

ТАЛАРХАЛ

Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ-ын хийсэн “ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ - 2” төслийн эцсийн үнэлгээ нь уг төслийн хэрэгжилтийн үр дүнг төслийн оролцогч талуудаар үнэлүүлэх замаар, дүгнэлт зөвлөмжийг боловсруулах зорилготойгоор хийгдлээ.

Судалгааны мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргаар Олон улсын Социологийн холбооны “Ёс зүйн стандарт кодекс”, “Гүнзгийрүүлсэн болон өгөгдлийн шинжилгээг багтаасан зах зээлийн, нийгмийн болон олон нийтийн санаа бодлын судалгаа”-ны (ISO 20252:2019) олон улсын стандартыг баримтлан цуглуулж, зохих аргачлалын дагуу өгөгдөлд боловсруулалт хийж тайлан, үр дүнг боловсрууллаа.

Тайлан дахь дүгнэлт, үр дүн нь судалгаанд оролцсон үр шим хүртэгчид, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийн байр суурь, үнэлгээ болон судалгааны явцад цуглуулсан анхдагч болон хоёрдогч өгөгдөл, мэдээлэлд шууд үндэслэсэн болно.

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн болон техникийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн Хүүхдийг Ивээх Сангийн төслийн мэргэжилтнүүд, мэдээлэл цуглуулалтад туслалцаа үзүүлсэн Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 30, 79, 127 болон Амгалан цогцолбор сургууль, Чингэлтэй дүүргийн 37, 39, 49 болон 61-р сургууль, Сонгинохайрхан дүүргийн 9, 65, 67 болон 76-р сургууль, Ховд аймгийн Ховд сумын 3 болон 7 дугаар сургууль, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2 болон Уянга сумын 1-р сургуулийн удирдлагууд, сургалтын менежер, багш нар, сурагчид болон нийт эцэг эхчүүдэд болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс, Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлд судалгааны багийн зүгээс гүн талархал илэрхийлье.

СУДАЛГААНЫ БАГ

Н.Батзориг	Багийн ахлагч “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ-ийн Гүйцэтгэх захирал
Б.Мягмарсайхан	Төслийн зөвлөх “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ-ийн зөвлөх, ХИС-ийн багш
Л.Энхбаяр	Төслийн зөвлөх “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ-ийн зөвлөх, МУБИС-ийн багш
Б.Болор	Мэдээлэл боловсруулалт хариуцсан судлаач “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ-ийн Судлаач
М.Пүрэвсүрэн	Мэдээлэл цуглуулалтын багийн ахлагч “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ-ийн Мэдээлэл цуглуулалт хариуцсан менежер
Б.Сайнзаяа	Судлаач “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ-ийн Судлаач
Г.Гантулга	Судлаач “Мэргэжлийн социологичдын холбоо” ТББ-ийн Судлаач

ХУРААНГУЙ

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Японы Хүүхдийг Ивээх Сан (ХИС) Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (БШУЯ)-тай хамтран Япон улсын Гадаад Хэргийн Яамны санхүүжилтээр “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийг (2021-2024) хэрэгжүүлсэн байна. Төслийн зорилго нь зорилтот сургуулиудын тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн бага ангиас дунд ангид дэвшин суралцах бэлэн байдлыг хангах, суралцах орчин нөхцөлийг сайжруулах, бага болон дунд ангийн багш нарын тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, арга зүйг сайжруулах, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. Төсөлд Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг, Өвөрхангай, Ховд аймгийн нийт 16 сургуулийг 2 үе шаттайгаар хамруулсан. ХИС нь тэгш хамруулах боловсролын чиглэлээр оролцогч талуудтай хамтран төслийн зорилгын хүрээнд тусгай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, сургуулийн тогтолцоог бэхжүүлэх, тусгай хэрэгцээтэй хүүхдийг сурч, боловсроход дэмжих багш, эцэг эх, үе тэнгийнхний дэмжлэг үзүүлэх чадавхыг сайжруулах, тэгш хамруулах боловсролыг дэмжих бодлого, дүрэм журмын хэрэгжилтийг уялдуулан сайжруулах гэсэн дөрвөн зорилт тавин хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан байна.

ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Төслийн эцсийн үнэлгээ нь төслийн үр дүнг дөрвөн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлж, төслийн хэрэгжилтийн явцад тулгарсан ололт, бэрхшээлийг тодорхойлох, төслийн үр шим хүртэгч зорилтот бүлэгт бий болсон үр нөлөө, өөрчлөлтийг үнэлэх зорилготой байсан.

Төслийн үр дүнг үнэлэхдээ төсөлд хамрагдсан Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг, Өвөрхангай, Ховд аймгийн 16 сургуулийн удирдлагууд, бага, дунд ангийн анги удирдсан 174 багш, анги удирдаагүй 36 багш, 170 сурагч¹, 100 эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөл болон аймаг, дүүргийн боловсролын мэргэжилтнүүд, БШУЯ-ны тусгай хэрэгцээт боловсролын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг үнэлгээнд хамруулсан. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг асуумж, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлагын арга гэсэн тоон болон чанарын судалгааны аргуудыг ашиглан цуглуулсан. Төслийн үр дүнд бий болсон өөрчлөлтийг төслийн баримт бичигт дурдсан төслийн 4 зорилтын хүрээнд тавьсан шалгуур үзүүлэлтийн дагуу тоон болон чанарын судалгааны үр дүнг нэгтгэн үнэлсэн.

1 Судалгаанд зорилтот сургуулийн 170 сурагч оролцсон ба 156 нь тоон судалгаанд, 14 нь чанарын судалгаанд хамрагдсан. Тоонд судалгаанд хамрагдсан 156 сурагчийн 87 нь тусгай хэрэгцээгүй, 69 нь тусгай хэрэгцээтэй хүүхдүүд байна. 2023-2024 оны хичээлийн жилд суралцаж байгаа ангиар авч үзвэл 4-5 дугаар ангийн 73 сурагч, 6-9 дүгээр ангийн 83 сурагч судалгаанд хамрагдсан.

ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮР ДҮН

Төслийн эцсийн үнэлгээний үр дүнг төслийн суурь үзүүлэлт тус бүрээр дараах хүснэгтэд хураангуйлан харуулав.

ТӨСЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ		2021 он Суурь судалгаа	2022 он Суурь судалгаа	2024 он Эцсийн үнэлгээ	I жилийн зорилтот сургууль ²	II жилийн зорилтот сургууль
Шалгуур үзүүлэлт 1. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн бага ангиас дунд ангид дэвшин суралцах бэлтгэл сайн хангагдсан байна.						
Тусгай хэрэгцээтэй хүүхдийн бага ангиас дунд ангид дэвшин суралцахтай холбоотой бэлтгэл	Бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахтай холбоотой бэлтгэл хийж буй байдал	26.7%	59.3%	63.3%	53.8%	70.6%
	Багшийн зүгээс бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийг дунд ангид дэвшин суралцуулахтай холбоотой бэлтгэл хийж буй байдал	2.5%- 22.5%	5.5%- 16.4%	85.1%	88.4%	81.8%
	Эцэг эхийн зүгээс бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдээ дунд ангид дэвшин суралцахтай холбоотой бэлтгэл хийж буй байдал	8.8%- 36.3%	13.7%- 21.9%	80.5%	81.0%	80.0%
Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахтай холбоотой сургууль, багшийн үйл ажиллагаа	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад материаллаг орчин бүрдүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа	11.3%- 17.5%	5.5%- 16.4%	78.2, 79.5%	85.7, 83.3%	70.7, 75.7%
	ГСТ, хэрэглэгдэхүүн, гарын авлага боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа	13.8%- 22.5%	5.5%- 16.4%	89.8, 85.9%	97.3, 88.1%	82.3, 83.7%
	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж буй үйл ажиллагаа	15.1%- 18.8%	26.8%- 32.4%	49.4-79.2%	54.2-76.2%	36.9-82.2%
	Багш багшийн, багш нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн, багш эцэг эхийн хамтын үйл ажиллагаа	2.5%- 12.5%	5.5%- 15.1%	АУБ- 88.5% НА- 69.2% СЗ- 50.2%	АУБ- 90.5% НА- 62.0% СЗ- 47.6%	АУБ- 86.5% НА- 76.4% СЗ- 52.8%

Шалгуур үзүүлэлт 1. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн бага ангиас дунд ангид дэвшин суралцах бэлтгэл сайн хангагдсан байна.

- Бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн үнэлгээгээр 63.3 хувь нь бага ангиас дунд ангид дэвшин суралцахтай холбоотой сургууль, багш, эцэг эхээс дэмжлэг авч бэлтгэл хангаж байна.

² Төсөлд 2021 оноос хойш найман сургууль (төслийн эхний жил), 2022 оноос хойш (төслийн хоёр дахь жил) өөр найман сургууль сонгогдсон байна. Энэхүү тайланд төслийн эхний жилийн найман сургуулийг "I жилийн зорилтот сургууль" гэж нэрлэсэн бол төслийн хоёр дахь жилийн сургуулиудыг "II жилийн зорилтот сургууль" гэж нэрлэсэн. 2021 оны суурь судалгаанд зөвхөн I жилийн зорилтот сургуулиудыг судалсан бол 2022 оны суурь судалгаанд зөвхөн II жилийн зорилтот сургуулиудыг судалсан.

- Бага ангийн багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад сургууль, багшийн зүгээс хангах бэлтгэл ажлуудыг хэрхэн хангаж байгааг 7 үзүүлэлтээр үнэлсэн ба дундаж үнэлгээгээр 85.1 хувь нь “сайн” гэж дүгнэж байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн эцэг эхийн зүгээс бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүддээ дунд ангид дэвшин суралцуулахтай холбоотой бэлтгэл хийж буй байдал 80.5 хувьтай байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад сургуулийн материаллаг орчин хэрхэн бүрдсэнийг бага ангийн багш нарын үнэлгээгээр авч үзвэл сургалтын материал, тохирох хэрэглэгдэхүүн хангалттай гэж 79.5 хувь нь, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд ээлтэй сургуулийн дэд бүтэц хангалттай гэж 78.2 хувь нь үзэж байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийн сургалтад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө (ГСТ) хэрэгжүүлэх ажлыг 89.8 хувь нь сайн, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх үйл ажиллагаа 85.9 хувь нь сайн хэрэгждэг гэж бага ангийн багш нар үнэлж байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад сэтгэл зүйн дэмжлэгийг хэрхэн үзүүлж байгааг авч үзвэл эцэг эхэд нь зөвлөгөө өгөх (79.2), дунд ангийн багш нарт нь сурагчдын талаар захих (72.7), дасан зохицохуйтай холбоотой ажлуудыг зохион байгуулах (66.2), тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ярилцах (61.0), сэтгэл зүйн зөвлөгөө өгөх (49.4) чиглэлээр ажиллаж байна.
- Бага ангиас дунд анги руу дэвшин суралцахад бэлтгэн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд сургууль, багш, сургуулийн ажилтнуудын зүгээс хэн нь хамгийн их сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдгийг авч үзвэл судалгаанд оролцогч бага ангийн багш нарын 88.5 хувь нь ангийн багш, 69.2 хувь нь нийгмийн ажилтан, 50.2 хувь нь сэтгэл зүйч тусгай хэрэгцээтэй хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг гэж хариулжээ.

ТӨСЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ			2021 он Суурь судалгаа	2022 он Суурь судалгаа	2024 он Эцсийн үнэлгээ	I жилийн зорилтот сургууль	II жилийн зорилтот сургууль
Шалгуур үзүүлэлт 2. Суурь боловсролын түвшинд тусгай хэрэгцээтэй хүүхдийг хүлээж авах, дунд ангид суралцах орчинд дасан зохицох үйл явцыг нь дэмжих багшийн ойлголт, мэдлэг, ур чадвар, оролцоо, сургуулийн санал санаачилга сайжирсан байна.							
Дунд ангийн багш нарын тэгш хамруулах боловсролтой холбоотой ойлголт, мэдлэг, ур чадвар	Дунд ангийн багш нарын тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголт	Хариуцсан ангигүй багш нарын тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт	63.6%	81.8%	91.7%	94.7%	88.2%
		Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаггүй багш нарын тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт	64.3%	78.7%	100%	100%	100%
		Анги удирдсан багш нарын тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт	79.7%	85.7%	100%	100%	100%
		Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нар	81.1%	93.7%	94.5%	94.5%	94.5%
		Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр төлөөлүүлэн ойлгох хувь	40.9%	48.4%	15.4%	15.4%	15.4%

	Дунд ангийн багш нарын тэгш хамруулах боловсролын арга зүй, ур чадвар	Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах / багшлах арга зүйн ур чадвартаа өгсөн багшийн өөрийн үнэлгээ	59.0%	67.8%	70.7%	71.6%	69.8%
		Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлогт тохируулан заах ур чадвартаа өгсөн багшийн өөрийн үнэлгээ	60.0%	62.2%	71.7%	71.9%	71.6%
		Тусгай хэрэгцээтэй хүүхдийг үнэлэх, эрт илрүүлэх аргачлалыг ашигладаг	32.4%	65.4%	72.5%	73.5%	71.4%
		Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ГСТ-өөр үнэлэх аргачлалыг ашигладаг	30.2%	68.0%	71.6%	72.5%	70.7%
Дунд ангийн багш нарын тэгш хамруулах боловсролтой холбоотой үйл ажиллагааны оролцоо	Багш нарын тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан байдал	АУБ нарын сургалтад хамрагдалт	44.1%	70.2%	98.0%	98.0%	98.0%
		Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нар	47.2%	72.2%	100%	100%	100%
		Хариуцсан ангигүй багш нарын сургалтад хамрагдалт	31.8%	45.5%	97.2%	94.4%	100%
		Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаггүй багш нар	28.6%	68.5%	97.6%	97.6%	97.6%

Шалгуур үзүүлэлт 2. Суурь боловсролын түвшинд тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг хүлээж авах, дунд ангид суралцах орчинд дасан зохицох үйл явцыг нь дэмжих багшийн ойлголт, мэдлэг, ур чадвар, оролцоо, сургуулийн санал санаачилга сайжирсан байна.

- 6-9 дүгээр ангийн анги удирдсан багш нар 100 хувь, анги удирдаагүй багш нарын 91.7 хувь нь “Тэгш хамруулах боловсрол гэж тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ердийн сургуульд хамтдаа суралцахыг хэлнэ” гэсэн зөв оюун дүгнэлтийг хийсэн нь тэдний ойлголт сайн байгааг харуулж байна. Мөн тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаггүй дунд ангийн багш нар бүгд (100%), тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг дунд ангийн багш нарын 94.5 хувь нь “Тэгш хамруулах боловсрол гэж тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ердийн сургуульд хамтдаа суралцахыг хэлнэ” гэсэн зөв оюун дүгнэлтийг хийсэн байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр төлөөлүүлэн ойлгож буй хувь анги удирдсан болон анги удирдаагүй багш нарын хариултын дундаж 15.4 хувь болж бууран багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр хязгаарлахгүйгээр туслалцаа дэмжлэг шаардлагатай, суралцахуйн бэрхшээлтэй, бусдаас онцлог ялгаатай хүүхэд зэрэг тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголтын хүрээ өөрчлөгдсөн байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд багшлах арга зүйн ур чадвараа дунд ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нарын 71 хувь нь эергээр үнэлсэн байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлогт тохируулан заах ур чадвараа багшийн 72 хувь нь сайн гэж үнэлсэн байна.

- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг үнэлэх, эрт илрүүлэх аргачлалыг дунд ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нарын 72.5 хувь нь сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ГСТ-өөр үнэлэх аргачлалыг дунд ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нарын 71.6 хувь нь сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Анги удирдсан багш нарын 98.1 хувь нь тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нар 100 хувь тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан байна.
- Хариуцсан ангигүй багш нарын 97.2 хувь нь тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаггүй багш нарын 97.6 хувь нь тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан байна.

ТӨСЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ			2021 он Суурь судалгаа	2022 он Суурь судалгаа	2024 он Эцсийн үнэлгээ	I жилийн зорилтот сургууль	II жилийн зорилтот сургууль
Шалгуур үзүүлэлт 3. Эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсрол, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг гэрийн орчинд дэмжих талаарх ойлголтоо нэмэгдүүлсэн байна							
Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн хүүхдийнхээ сурч боловсрохтой холбоотой гэр бүлийн орчин дахь дэмжлэг	Материаллаг талын дэмжлэг үзүүлдэг байдал	Сурч хөгжихөд дэмжлэг болох ширээ сандлаар хангадаг	84.8%	92.7%	100%	100%	100%
		Шаардлагатай ном, сурах бичгийг авч өгдөг	100%	97.6%	100%	100%	100%
		Хүүхдээ эрүүл, таатай амьдрах орчин нөхцөлөөр хангадаг	100%	100%	100%	100%	100%
	Хүүхэд рүү чиглэсэн сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг байдал	Хүүхдээ даалгавар хийхэд нь тусалдаг	100%	57.6%	98.1%	97.2%	99.0%
		Чөлөөт цагаараа ярилцаж, цагийг хамт өнгөрөөдөг	69.7%	100%	100%	100%	100%

Шалгуур үзүүлэлт 3. Эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсрол, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг гэрийн орчинд дэмжих талаарх ойлголтоо нэмэгдүүлсэн байна.

- Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдийнхээ сурч хөгжихөд дэмжлэг болох ширээ сандлаар бүрэн ханган (100 хувь) дэмжлэг үзүүлдэг гэж хариулсан байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй эцэг эхчүүд хүүхдийнхээ шаардлагатай ном, сурах бичгийг авч өгч дэмжлэг үзүүлдэг гэж бүгд (100 хувь) хариулсан байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй эцэг эхчүүд бүгд (100 хувь) хүүхдээ эрүүл, таатай амьдрах орчин нөхцөлөөр хангадаг гэж хариулсан байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхчүүдийн 98.1 хувь нь хүүхдээ даалгавар хийхэд нь тусалдаг байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн бүгд (100 хувь) хүүхэдтэйгээ чөлөөт цагаараа ярилцаж, цагийг хамт өнгөрөөдөг гэж хариулсан байна. байна.

ТӨСЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ	2021 он Суурь судалгаа	2022 он Суурь судалгаа	2024 он Эцсийн үнэлгээ	
Шалгуур үзүүлэлт 4. Суурь боловсролын түвшинд тэгш хамруулах боловсролыг дэмжих бодлого, журмыг боловсронгуй болгох, тэгш хамруулах боловсролын тогтолцоог бүрдүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна.				
Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулахтай холбоотой боловсролын бодлого ба хэрэгжилт	Тусгай хэрэгцээтэй хүүхэд, тэднийг дэмжих тогтолцоог эрх зүйн хүрээнд баталгаажуулсан байдал:	Эрх зүйн баримт бичгүүдэд тусгай хэрэгцээтэй хүүхдээс зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал тусгагдсан байна. Бусад бүлгийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх тогтолцоо байхгүй байна.	Эрх зүйн баримт бичгүүдэд тусгай хэрэгцээтэй хүүхдээс зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал тусгагдсан байна. Бусад бүлгийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх тогтолцоо байхгүй байна.	Боловсролын салбарт хамаарах эрх зүйн баримт бичгүүдэд тусгай хэрэгцээтэй хүүхдийн асуудал тусгагдсан буюу эрх зүйн хүрээнд баталгаажсан байна.
	Тэгш хамруулах боловсролын талаар батлагдан гарсан эрх зүйн баримт бичгүүдийг сургууль, багшид танилцуулах, хэрэгжүүлэх арга замыг зөвлөмжилж байгаа байдал	Сургууль, багш нарын зүгээс эрх зүйн баримт бичгийг уншиж судлах, бодлого боловсруулагчдын зүгээс хэрэгжүүлэх арга замыг хэлэлцүүлэх үйл ажиллагаа дутагдалтай байна.	Сургууль, багш нарын зүгээс эрх зүйн баримт бичгийг уншиж судлах, бодлого боловсруулагчдын зүгээс хэрэгжүүлэх арга замыг хэлэлцүүлэх үйл ажиллагаа дутагдалтай байна.	Сургууль, багш нарын зүгээс эрх зүйн баримт бичгийг уншиж судлах, бодлого боловсруулагчдын зүгээс хэрэгжүүлэх арга замыг хэлэлцүүлэх үйл ажиллагаа хангалттай түвшинд хийгдсэн байна.
	Хууль, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг үнэлсэн байдал	Батлагдан гарсан дүрэм журам цөөнгүй байгаа ч хэрэгжилтийг үнэлсэн тайлан, судалгаа ховор байна.	Батлагдан гарсан дүрэм журам цөөнгүй байгаа ч хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх заалтыг 3 сайдын хамтарсан тушаалд заалт болгон оруулсан.	Тэгш хамруулах боловсролын чиглэлээр батлагдсан дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх эхлэл тавигдсан байна.
	Монгол улсад тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлсэн бодит туршлагаудыг баримтжуулсан байдал	Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлсэн туршлага, сургамжийг баримтжуулсан байдал цөөн байна.	Тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлсэн туршлага, сургамжийг баримтжуулсан тайлан, мэдээ өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн.	Тэгш хамруулах боловсролын чиглэлээр олон улсын байгууллага (ОУБ)-уудын Монгол улсад хэрэгжүүлж байгаа 7 төсөл, хөтөлбөр байна. Энэ хүрээнд БШУЯ-аас хэрэгжүүлсэн бодит туршлагаудыг нэгтгэж баримтжуулсан байна.

Шалгуур үзүүлэлт 4. Суурь боловсролын түвшинд тэгш хамруулах боловсролыг дэмжих бодлого, журмыг боловсронгуй болгох, тэгш хамруулах боловсролын тогтолцоог бүрдүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

- Боловсролын салбарт хамаарах эрх зүйн баримт бичгүүдэд тусгай хэрэгцээтэй хүүхдийн асуудал тусгагдсан буюу эрх зүйн хүрээнд баталгаажсан байна.
- Сургууль, багш нарын зүгээс эрх зүйн баримт бичгийг уншиж судлах, бодлого боловсруулагчдын зүгээс хэрэгжүүлэх арга замыг хэлэлцүүлэх үйл ажиллагаа хангалттай түвшинд хийгдсэн байна.
- Тэгш хамруулах боловсролын чиглэлээр батлагдсан дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх эхлэл тавигдсан байна.
- Тэгш хамруулах боловсролын чиглэлээр олон улсын байгууллага (ОУБ)-уудын Монгол улсад хэрэгжүүлж байгаа 7 төсөл, хөтөлбөр байна. Энэ хүрээнд БШУЯ-аас хэрэгжүүлсэн бодит туршлагаудыг нэгтгэж баримтжуулсан байна.

БҮЛЭГ НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1 ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Төслийн үнэлгээний үндсэн зорилго нь төслийн суурь судалгаанаас хойш гарсан ахиц өөрчлөлтийг хэмжих, гурван жилийн хугацаанд хэрэгжсэн төслийн үр дүнг үнэлэх, бий болсон туршлага, сургамж дээр үндэслэн санал зөвлөмжийг боловсруулахад оршино. Эцсийн үнэлгээний хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

- Төслийн зорилтот 16 сургуульд суралцаж буй 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй сурагчдыг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад сургууль дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаа эсэхийг үнэлэх,
- Төслийн зорилтот 16 сургуульд суралцаж буй дунд ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдэд бие бялдар, сэтгэл зүй, суралцахуйн үйл явцад нь дэмжлэг үзүүлж буй сургуулийн нөхцөл байдлыг үнэлэх,
- Сонгогдсон 16 сургуулийн дунд ангийн багш нарын тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг ойлголт, чадварыг үнэлэх,
- Бага, дунд ангийн тусгай хэрэгцээтэй болон тусгай хэрэгцээгүй хүүхэдтэй эцэг эхчүүдийн тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт мэдлэг, хүүхдийн хөгжилд үзүүлж буй дэмжлэг туслалцаа, оролцооны түвшнийг тодорхойлох,
- Тэгш хамруулах боловсрол болон тусгай хэрэгцээт хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад чиглэсэн бодлого, дүрэм журамд дүн шинжилгээ хийх.

1.2 ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДИЗАЙН

“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь -2” төслийн үр дүнтэй байдал болон төслийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэхдээ дараах үнэлгээний арга зүйг ашигласан.

Зураг 1. Үнэлгээний дизайн



А1 нь 2021 болон 2022 онд хоёр удаа хийгдсэн суурь судалгааны үр дүн юм. А2 нь зорилтот бүлгийг хамруулан 2023-2024 онд хийсэн төслийн эцсийн үнэлгээний үр дүн юм. Суурь судалгаанаас гарсан суурь үзүүлэлтийг төслийн эцсийн үнэлгээний үзүүлэлттэй харьцуулан төслийн үр дүн, үр нөлөөг Х-ээр хэмжсэн.

1.3 ТҮҮВРИЙН СТРАТЕГИ БА ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ

Түүврийн аргачлалын хувьд зорилтот болон квотын, алхамт түүврийн аргыг хослуулан хэрэглэсэн. Зорилтот түүврийн тухайд төсөл хэрэгжсэн аймаг, дүүргийн төслийн үр шимийг хүртсэн бүлгүүдээс сонгож мэдээлэл цуглуулсан.

Зураг 2. Түүврийн стратеги

ЗОРИЛТОТ ТҮҮВЭР	КВОТ	ЗОРИЛТОТ ТҮҮВЭР
<ul style="list-style-type: none"> УБ хотын 3 дүүрэг Ховд, Өвөрхангай аймгийн төсөлд хамрагдсан багш, эцэг эх, сурагч 	<ul style="list-style-type: none"> Төсөлд хамрагдагчдын харьцааг харгалзан квот тооцсон. 	<ul style="list-style-type: none"> Төслийн үр шимийг хүртэгчдийн бүртгэл мэдээлэл (тоо хэмжээ)-ийг харгалзан алхмын зайг тодорхойлсон.

Тоон судалгааны түүвэр: Асуулга судалгаанд Улаанбаатар хотын 3 дүүрэг, Өвөрхангай, Ховд аймгийн үр шим хүртэгчдээс түүврийн найдвартай байдал, үндэслэлийг харгалзан түүвэрлэх байдлаар асуулга судалгаа (face to face)-нд оролцуулсан. Төслийн 2022-2023 оны тайланд дурдсанаар нийт 20,198 ашиг шим хүртэгч бөгөөд үүнээс буцаалтгүй түүврийн аргаар 444 оролцогчоос мэдээлэл цуглуулахад алдааны хязгаар ± 4.6 хувийн хооронд хэлбэлзэх ба итгэх магадлал 95.0 хувьтай байсан.

Хүснэгт 1. Тоон судалгааны түгээрлэлт

№	Зорилтот бүлэг	N	ЧД				СХД				БЗД				Ховд			Өвөрхангай						
			#37	#49	#39	#61	N	#65	#67	#9	#76	N	#79	#127	#30	#Amg	N	#7	#3	N	#2	#Уу1	N	
1	4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээгүй хүүхэд ³	42	3	3	3	4	13	2	2	2	3	3	10	2	2	3	3	10	2	2	4	3	2	5
2	6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээгүй хүүхэд ⁴	43	2	2	2	3	9	2	2	3	3	10	3	2	2	3	3	11	3	4	7	4	2	6
3	4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэд	27	2	2	2	2	8	1	1	2	1	5	2	2	2	3	3	10	1	2	3	1	-	1
4	6-9 дүгээр ангийн ТХХ	39	1	1	2	2	6	4	4	4	4	16	2	2	2	3	3	10	2	3	5	1	1	2
5	4-5 дугаар ангийн хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч	50	3	3	4	4	14	2	2	3	2	9	3	3	4	4	14	5	4	9	2	2	4	
6	6-9 дугаар ангийн хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч	39	1	1	2	2	6	4	4	4	5	17	2	2	3	3	10	2	1	3	2	1	3	
7	4-5 дугаар анги удирдсан багш	74	4	4	4	5	17	6	6	6	6	24	5	5	5	6	21	3	4	7	3	2	5	
8	6-9 дүгээр анги удирдсан багш	96	5	6	6	6	23	6	6	6	7	25	7	7	8	8	30	5	5	10	5	3	8	
9	Анги удирдаагүй багш	34	2	2	2	2	8	2	2	2	2	8	2	2	2	2	8	2	3	5	3	2	5	
	Нийт	444	23	24	27	30	104	29	29	29	33	33	124	28	27	34	35	124	25	28	53	24	15	39

1, 2, 3-р жилийн сургууль

2, 3-р жилийн сургууль

3 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээгүй хүүхдийг сонгохдоо зорилтот сургуульд тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй нэг ангид хамт суралцдаг хүүхдийг сонгосон.

4 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээгүй хүүхдийг сонгохдоо зорилтот сургуульд тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй нэг ангид хамт суралцдаг хүүхдийг сонгосон.

$$n = \frac{X^2 * N * P (1-P)}{(ME^2 * (N - 1)) + (X^2 * P * 1 - P)}$$

n = түүврийн хэмжээ

X² = хи квадратын итгэх түвшний чөлөөний зэрэг 1 байна.

N = их олонлогийн хэмжээ

P = хүн амын хувийн жин

ME = алдааны хязгаар

Determine Sample Size

Confidence Level: 95% 99%

Confidence Interval:

Population:

Sample size needed:

Чанарын судалгааны түүвэрлэлт: Чанарын судалгааны түүврийн хэмжээг судалгаанд хэрэглэж буй арга тус бүрээс хамааран дараах байдлаар тооцсон. Фокус бүлгийн ярилцлагыг тоон судалгааны мэдээллийг бататгах, тоон судалгаанд оролцогчдын санаа бодлыг гүнзгийрүүлэн судлах зорилгоор хийсэн ба нийт 8 ярилцлага хийсэн. Ганцаарчилсан ярилцлагыг тэгш хамруулах боловсролын бодлого, эрх зүйн орчинд шинжилгээ хийх, төслийн оролцогч талууд төслийн үр дүнг хэрхэн үнэлж байгааг судлах зорилгоор хийсэн ба нийт 9 ярилцлага хийсэн.

Хүснэгт 2. Чанарын судалгааны түүвэрлэлт

№	Ярилцлагын төрөл	Төлөөлөл	Ярилцлагын тоо хэмжээ
1	Фокус бүлгийн ярилцлага	Эцэг эх, асран хамгаалагч (ТХХ-тэй) (ЧД)	1
2		Эцэг эх, асран хамгаалагч (ТХХ-гүй) (Өвөрхангай)	1
3		Бага ангийн хүүхдүүд (Ховд)	1
4		Дунд ангийн хүүхдүүд (БЗД)	1
5		Бага ангийн багш нар (БЗД)	1
6		Дунд ангийн багш нар (СХД)	1
7		Сургуулийн удирдлага, менежер, дэмжлэгийн багийн гишүүд (СХД, Ховд)	2
Нийт			8
1	Ганцаарчилсан ярилцлага	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын төлөөлөл (СХД)	1
2		Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн төлөөлөл (ЧД)	1
3		БШУЯ-ны төлөөлөл	1
4		БЕГ-ын төлөөлөл	1
5		МУБИС-ын багшийн төлөөлөл	1
6		Тусгай сургуулийн удирдлагын төлөөлөл (63-р сургууль)	1
7		Дүүргийн комиссын төлөөлөл (БЗД)	1
8		Аймгийн БШУГ-ын төлөөлөл (Өвөрхангай)	1
9		ТББ-ын төлөөлөл (ХБХЭЭХ ТББ)	1
Нийт			9

1.4 ТУРШИЛТ СУДАЛГАА

Судалгааны мэдээлэл цуглуулахад ашиглах хэрэглэгдэхүүнийг туршиж, шаардлагатай сайжруулалтыг олж тодорхойлох нь туршилт судалгааны үндсэн зорилго юм. Туршилт судалгааг УБ хотын Чингэлтэй дүүргийн 39 дүгээр сургуулийн сурагч, багш, эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулан 11 сарын 20-24-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Хүснэгт 3. Туршилт судалгааны түүвэрлэлт

№	Оролцогчид	УБ хот		
		СХД	ЧД	БЗД
1	4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээгүй хүүхэд	-	2	-
2	6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээгүй хүүхэд	-	2	-
3	4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээт хүүхэд	-	1	-
4	6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээт хүүхэд	-	1	-
5	4-5 дугаар ангийн хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч	-	1	-
6	6-9 дугаар ангийн хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч	-	1	-
7	4-5 дугаар анги удирдсан багш	-	2	-
8	6-9 дүгээр анги удирдсан багш	-	2	-
9	Анги удирдаагүй багш	-	1	-
Нийт		-	13	-

Туршилт судалгаанд үндсэн судалгаанд ашиглах бүх төрлийн хэрэглэгдэхүүнээ туршиж, сайжруулсан ба ойлгоход хүндрэлтэй асуултыг өөрчлөх, хариултын давтагдсан болон орхигдсон утгыг засварлах, судалгаанд оролцогчдод энгийн байлгах зэргээр засваруудыг хийж өөрчилсөн.

1.5 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ


Тоон судалгаа: Анкет сурвалжилгын аргаар цуглуулсан мэдээллийг нийгмийн мэдээлэлд статистик боловсруулалт хийх орчин үеийн багц программ “SPSS-23”-ыг хэрэглэн боловсруулсан. Нэг хэмжээт тархалтын аргаар индикатор, тоон үзүүлэлтүүдийн давталтын статистик ба график дүрслэлийн утгыг тодорхойлдог. Хоёр хэмжээс тархалт нь хоёр болон түүнээс дээш хэмжигдэхүүнүүдийн тест, хэмжээс, харилцан холбоо уялдааг матриц хэлбэрээр харуулдаг бөгөөд судалгааны ихэнх үр дүнг эдгээр аргачлалаар боловсруулж шинжилсэн. Шаардлагатай тохиолдолд хамаарах болон үл хамаарах хувьсагчдын хоорондын хамаарлын хүч Пирсоны корреляцийн коэффициент, Спирманы рангийн корреляцийн коэффициент, Кенделийн рангийн коэффициентуудаар олсон бөгөөд үр дүнг хувьсагчдын ач холбогдол (significance)-ын түвшнээр баталгаажуулж тайлан, үр дүнд ашигласан.

Чанарын судалгаа: Чанарын судалгаанд 8 фокус бүлгийн ярилцлага, 9 ганцаарчилсан ярилцлага хийсэн. Бүлгийн ярилцлага, ганцаарчилсан болон экспертийн ярилцлагын мэдээллийг логик матрицын аргыг ашиглаж шинжилсэн. Чанарын мэдээлэл боловсруулах аргыг ашигласнаар текстийн утгыг тоон хэлбэрээр илэрхийлэх, судалгаанд оролцогчдын илэрхийлж буй санаа, тэдгээрийн хоорондох уялдаа холбоо, зүй тогтлыг илрүүлэх байдлаар шинжилгээ хийсэн болно.

1.6 ӨГӨГДЛИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТ

Төслийн үнэлгээний мэдээлэл цуглуулах явцад талбарын болон алсын зайн нийлсэн 4 шатны хяналтыг хийж ажилласан болно.

Зураг 3. Өгөгдлийн чанарын хяналтын процесс



1. Сургалтын хяналт: Мэдээлэл цуглуулах судлаачдад тоон судалгааны асуулгын хуудасны логик болон хэрхэн оновчтой асуух талаар сургалт явуулж, улмаар шалгалт авч тэнцсэн судлаачдыг талбарт ажиллуулсан.
2. Мэдээлэл цуглуулалтын хяналт: Судлаач зорилтот оролцогчоос судалгааг авсан эсэх, асуулгын хуудасны дарааллын дагуу алдаагүй зөв мэдээлэл авсан эсэхийг дуу хураагуур, GPS ашиглан хянасан. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2005 онд бүтээгдсэн KoBoToolbox программ дээр явуулсан.
3. Мэдээлэл цуглуулалтын дараах хяналт: Тогтоосон түүврийн хэмжээг хангахуйц мэдээлэл цуглуулсны дараагаар нэгдсэн хяналтыг явуулж, логик алдаа, бөглөөгүй орхисон асуулт байгаа эсэхийг дахин хянан шалгасан.
4. Дүн шинжилгээний хяналт: Мэдээлэл цуглуулалтын багаас хянагдаж ирсэн өгөгдлийг боловсруулалт, дүн шинжилгээ хариуцсан судлаач үр дүн гаргахаас өмнө дахин хянаж, алдаатай эсэхийг шалгасан.

1.7 ҮНЭЛГЭЭНИЙ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Төсийн үнэлгээний өгөгдөл цуглуулах үе шатанд судлаачид дараах ёс зүйн кодыг мөрдөж ажилласан.

1. Хүний эрхийг дээдлэх зарчмыг судалгаанд баримтлах: Монгол Улсын хууль, Олон улсын гэрээ конвенцод тусгагдсан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой заалтууд болон бусад хууль тогтоомж, судалгааны ёс зүйн дүрэмд тусгасан хүний эрхийг дээдлэн хүндэтгэх зарчмыг судалгаа хийх явцдаа баримтлан ажилласан. Үүнд: нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, гэр бүлийн байдал, нийгмийн байдлаар ялгаварлахгүй байх, хувь хүний ялгаатай байдлыг хүндэтгэх гм.

2. Судалгаанд оролцогчдод хувийн үзэл бодлоо тулгахаас зайлсхийх: Ярилцах явцад хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг дээдлэхийн зэрэгцээ судалгааны асуулттай холбоотой үнэн зөв мэдээлэл, тайлбар өгөхөд анхаарсан.
3. Мэдээллийн нууцлалыг чанд хадгалах, хамгаалах: Статистикийн тухай хуулийн 22-р зүйлийн 3, Хувь хүний нууцын тухай хуулийн 2-р бүлгийн 5-р зүйлийн 4-т дурдсан “Хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглоно” хэмээх заалтын дагуу мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах үүргийг судлаач биечлэн хүлээж ажилласан.
4. Шаардлагатай мэдээллийг баталгаажуулах, баримтжуулах: Судлаач тухайн мэдээллийг баталгаажуулах ба баримтжуулалтын аливаа төрлийг ашиглахдаа судалгаанд оролцогчоос (сурагч, хүүхэд, эцэг эх, багш гм) зөвшөөрөл авсан. Мэдээллийг баталгаажуулах дараах аргуудыг ашигласан.
 - Цаасан дээр тэмдэглэл хөтлөх
 - Компьютер, таблетад бичиж тэмдэглэх
 - Шаардлагатай тохиолдолд фото зураг авах, аудио бичлэг хийсэн.
5. Судалгааны ёс зүйн зарчмыг мөрдөх: Судлаач тухайн судалгааг /Олон Улсын Социологийн холбооны ёс зүйн код/ ёс зүйн дүрэм, журмын дагуу асуумжийг нэр дурдахгүй авах, ерөнхий байдлаар нэгтгэх, хийж гүйцэтгэхэд анхаарсан. Энэхүү судалгаа нь ЕБС-ийн багш, сурагчид, эцэг эхчүүдийн санал бодлыг тодорхойлж, төслийн хүрсэн үр дүн, ач холбогдлыг үнэлэхэд ашиглагдах мэдээллийн эх сурвалж бий болгосон тул энэ талаар тайлбарлан таниулсан.
6. ХИС-аас баталсан “Ажилтнуудын ёс зүйн дүрэм” болон “Хүүхдийн оролцооны стандарт удирдамж: Ёс зүйтэй, үр дүнтэй хүүхдийн оролцоонд тавигдах үндсэн шаардлага”-тай бүх судлаачид танилцсан.

1.8 ҮНЭЛГЭЭНИЙ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” А/554 дүгээр тушаалаар байгаль, цаг агаарын хэт хүйтрэлт, томуу, томуу төст өвчний тохиолдлын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан ЕБС-ийн суралцагчдын танхимын хичээл, сургалтыг зайн, цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсэн нь судалгааны мэдээлэл цуглуулалтын шатанд зарим бүлгийн ярилцлагад сөргөөр нөлөөлсөн.
- Төсөлд хамрагдсан 16 сургуулийн удирдлага, менежер болон тусгай хэрэгцээт хүүхдүүдийн холбогдох мэдээллийг төслийн багаас ирүүлсэн. Гэсэн хэдий ч зарим тохиолдолд тусгай хэрэгцээт хүүхэд, багш, эцэг эхээс судалгаа авахад тухайн тусгай хэрэгцээт хүүхэд шилжих, сургуулиас гарах, хичээлдээ ирэхгүй байх, эцэг эх, асран хамгаалагчид сургууль дээр ирэхгүй байх, хүлээлгэх гэх мэт шалтгаануудаас хамааран судалгааны түүвэрт өөрчлөлт орсон. Ганцаарчилсан ярилцлагад тусгай сургуулийн төлөөлөл хүндэтгэх шалтгааны улмаас оролцох боломжгүй болохоо илэрхийлсэн.
- Бага болон дунд ангийн тусгай хэрэгцээт хүүхдүүдээс судалгааг авахад зарим хүүхдийн тусгай хэрэгцээний онцлогоос шалтгаалан асуултыг удаан ойлгох, хариулахгүй байх, шууд бусаар хариулах зэрэг хүндрэл гарч байсан учраас эцэг эх, анги удирдсан багшийн дэмжлэгтэй судалгааны мэдээллийг цуглуулсан.

БҮЛЭГ ХОЁР. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН БАГА АНГИАС ДУНД АНГИД ДЭВШИН СУРАЛЦАХ БЭЛТГЭЛ

Шалгуур үзүүлэлт 1. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн бага ангиас дунд ангид дэвшин суралцах бэлтгэл сайн хангагдсан байна.


Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан сурагчдын мэдээлэл, тусгай хэрэгцээтэй хүүхдэд хандах сургуулийн сурагчид, багш, ажилтнуудын хандлага, тусламж дэмжлэг үзүүлэх хэлбэр, тусгай хэрэгцээтэй хүүхдэд хичээлээ хийх, сургуульдаа явахад тулгарах хүндрэл бэрхшээл, хэрэгтэй байгаа тусламж дэмжлэг, тусгай хэрэгцээтэй хүүхдэд хэрхэн хандах талаарх багш, гэр бүлийнхний нь захиж хэлдэг зүйлс зэргийг тодорхойлон харуулах болно.

2.1 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ДЭМЖЛЭГ

2.1.1 ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН СУРАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

Төслийн үнэлгээнд зорилтот сургуулийн 156 хүүхэд хамрагдсан ба 87 нь тусгай хэрэгцээгүй, 69 нь тусгай хэрэгцээтэй хүүхдүүд байна. 2023-2024 оны хичээлийн жилд суралцаж байгаа ангиар нь авч үзвэл 4-5 дугаар ангийн 73 сурагч, 6-9 дүгээр ангийн 83 сурагч судалгаанд хамрагдсан байна.

Зураг 4. Төслийн үнэлгээнд хамрагдсан сурагчдын тоо, анги, тусгай хэрэгцээтэй эсэхээр



Судалгаанд зорилтот сургуулиудын 4-5 дугаар ангийн 9-13 настай 30 тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамруулсан ба 43 хувь нь төслийн 1-р шатанд сонгогдсон сургуулийнх бол, 57 хувь нь төслийн 2-р шатанд сонгогдсон сургуулийн хүүхдүүд байна⁵. Сурагчдын 40 хувь нь эмэгтэй, 60 хувь нь эрэгтэй сурагчид байна. Сургууль завсардаж байсан 2 сурагч байна.

⁵ Хавсралт хэсгийн хүснэгтийг харна уу.

Хүснэгт 4. Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн мэдээлэл (Анги, насаар)

№	Үзүүлэлт	Ангилал	Тоо	Хувь
1	2023-2024 оны хичээлийн жилд суралцаж байгаа анги	4-р анги	15	50.0
		5-р анги	15	50.0
2	Тусгай хэрэгцээтэй хүүхдийн нас	9 нас	13	43.3
		10 нас	13	43.3
		11 нас	3	10.0
		13 нас	1	3.3


Энэ судалгаанд 6-9 дүгээр ангийн 11-15 настай 39 тусгай хэрэгцээтэй хүүхэд оролцсоны 44 хувь нь төслийн 1-р шатанд сонгогдсон сургуулийн төлөөлөл байгаа бол 56 хувь нь төслийн 2-р шатанд сонгогдсон сургуулийн хүүхдүүд байна⁶. Сурагчдын 35.9 хувь нь эмэгтэй, 64.1 хувь нь эрэгтэй сурагчид байна. Сургууль завсардсан 9 сурагч байгаагийн 6 сурагч нь 1 жил, 3 сурагч нь 2-3 жил сургууль завсардсан байна. Сурагчдын насны үзүүлэлт болон 2023-2024 оны хичээлийн жилд суралцаж буй ангийг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 5. Судалгаанд оролцсон 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн мэдээлэл (Анги, насаар)

№	Үзүүлэлт	Ангилал	Тоо	Хувь
1	2023-2024 оны хичээлийн жилд суралцаж байгаа анги	6-р анги	7	17.9
		7-р анги	18	46.2
		8-р анги	9	23.1
		9-р анги	5	12.8
2	Тусгай хэрэгцээтэй хүүхдийн нас	11 нас	7	17.9
		12 нас	12	30.8
		13 нас	10	25.6
		14 нас	8	20.5
		15 нас	2	5.1

Судалгаанд оролцсон тусгай хэрэгцээтэй хүүхдийн ангийн сурагчдын тоог зураг 10-д харууллаа. 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 55 хувь нь 31-40 хүүхэдтэй ангид суралцаж байгаа бол 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 61.5 хувь нь мөн тооны сурагчтай ангид суралцаж байна.

Зураг 5. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн ангийн сурагчдын тоо



6 Хавсралт хэсгийн хүснэгтийг харна уу.

Судалгаанд оролцсон 69 тусгай хэрэгцээтэй хүүхдийн тусгай хэрэгцээний төрлүүдийг авч үзвэл хэл ярианы бэрхшээлтэй 14, хөдөлгөөний бэрхшээлтэй 10, аутизмын хүрээний эмгэгтэй 10, харааны бэрхшээлтэй 8, оюун ухааны бэрхшээлтэй 8, суралцахуйн бэрхшээлтэй 7, хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй 4 хүүхэд байна. Нийт тусгай хэрэгцээтэй хүүхдийн тусгай хэрэгцээний төрлийг бага, дунд ангиар зураг 1-д харууллаа.

Зураг 6. Судалгаанд оролцсон тусгай хэрэгцээтэй хүүхдийн тусгай хэрэгцээний төрөл



Сүүлийн 3 жилийн мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо хэр өөрчлөлттэй байна вэ?

Манайх 7 хоног бүр хуралддаг. Манай дүүрэг 43 хороотой, 4 бүст хувааж, бүсийнхээ хурлыг долоо хоног бүрийн Баасан гариг болгонд хийдэг. Сая 4 дүгээр улирлын байдлаар 270-280 хүүхэд орсон байсан. Гэхдээ энэ бол дундаж тоо, нэг болон хоёрдугаар улиралд өндөр байдаг юм. 1300 орчим хүүхэд нэг жилийн дотор орсон байсан. Сүүлийн 3 жилийн мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо өөрчлөлттэй байгаа. 2023 оны эхээр гаргасан тоог энэ оныхтой харьцуулахад 200 орчим хүүхдээр нэмэгдсэн байсан.

Дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл Мэнд, Боловсрол, Нийгмийн Хамгааллын Комиссын гишүүнтэй хийсэн ГЯ-аас

Төслийн үнэлгээнд 4-5 дугаар ангийн нийт 43 тусгай хэрэгцээт боловсрол шаардлагагүй сурагчид хамрагдсан ба тэдний 39.5 хувь нь 4-р ангид, 60.5 хувь нь 5-р ангид суралцаж байна. Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн сурагчдын 40 хувь нь төслийн 1-р шатанд сонгогдсон сургуулийнх бол, 60 хувь нь төслийн 2-р шатанд сонгогдсон сургуулийн хүүхдүүд байна⁷. Сурагчдын 51.2 хувь нь эмэгтэй, 48.8 хувь нь эрэгтэй сурагчид байна.

⁷ Хавсралт хэсгийн хүснэгтийг харна уу.

Хүснэгт 6. Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээгүй сурагчдын мэдээлэл

№	Үзүүлэлт	Ангилал	Тоо	Хувь
1	2023-2024 оны хичээлийн жилд суралцаж байгаа анги	4-р анги	17	39.5
		5-р анги	26	60.5
2	Нас	9 нас	15	34.9
		10 нас	25	58.1
		11 нас	3	7.0


Мөн 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээт боловсрол шаардлагагүй 44 сурагчийг түүврийн аргаар сонгон үнэлгээнд хамруулсан ба сурагчдын 45 хувь нь төслийн 1-р шатанд сонгогдсон сургуулийн төлөөлөл байгаа бол, 55 хувь нь төслийн 2-р шатанд сонгогдсон сургуулийн хүүхдүүд байна. Сурагчдын 59.1 хувь нь эмэгтэй, 40.9 хувь нь эрэгтэй сурагчид байна. Сурагчдын насны үзүүлэлт болон 2023-2024 оны хичээлийн жилд суралцаж буй ангийг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 7. Судалгаанд оролцсон 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээгүй сурагчдын мэдээлэл

№	Үзүүлэлт	Ангилал	Тоо	Хувь
1	2023-2024 оны хичээлийн жилд суралцаж байгаа анги	6-р анги	7	15.9
		7-р анги	12	27.3
		8-р анги	15	34.1
		9-р анги	10	22.7
2	Нас	11 нас	7	15.9
		12 нас	10	22.7
		13 нас	15	34.1
		14 нас	10	22.7
		15 нас	2	4.5

Судалгаанд оролцсон бага, дунд ангийн тусгай хэрэгцээгүй сурагчдын нэг ангид суралцаж байгаа хүүхдийн тоог зураг 4-д харууллаа. 4-5 дугаар ангийн сурагчдын 69.8 хувь нь 31-40 хүүхэдтэй ангид суралцаж байгаа бол 6-9 дүгээр ангийн сурагчдын 54.5 хувь нь 31-40 сурагчтай ангид, 31.8 хувь нь 30 хүртэл хүүхэдтэй ангид суралцаж байна.

Зураг 7. Судалгаанд оролцсон тусгай хэрэгцээгүй сурагчдын ангийн хүүхдүүдийн тоо



2.1.2 ЗОРИЛТОТ СУРГУУЛИУДЫН БАГА, ДУНД АНГИЙН СУРАГЧДЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДЭД ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХ

Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн сурагчдын 58.1 хувь нь, 6-9 дүгээр ангийн сурагчдын 68.2 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ангид хамт суралцаж байна. Ангид нь тусгай хэрэгцээтэй хүүхэд суралцдаг гэж хариулсан сурагчдын 33 сурагч нь нэг тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ангид, 20 сурагч нь хоёр тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ангид, 2 сурагч 3-4 тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ангид хамт суралцаж байна.

Хүснэгт 8. Судалгаанд оролцсон сурагчдын ангид тусгай хэрэгцээтэй хүүхэд суралцдаг эсэх

№	Он	Бага анги		Дунд анги		
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй	
1	Суурь судалгаа	2021 он	/33/ 60.0	40.0	/39/ 66,1	33,9
2	Суурь судалгаа	2022 он	/39/ 24.1	76.9	/40/ 25.0	75.0
3	Эцсийн үнэлгээ	2023 он	/43/ 58.1	41.9	/44/ 68.2	31.8

Судалгаанд оролцсон сурагчдаас “Танай ангийнхан тусгай хэрэгцээтэй найздаа хэр зэрэг тусалдаг вэ?” гэсэн асуултаар тэдний ангийнхаа тусгай хэрэгцээтэй найздаа хэр их тусалж байгааг тодруулсан үр дүнг авч үзвэл:


- 4-5 дугаар ангийн сурагчдын 66.7 хувь нь ангийн хүүхдүүд маань үргэлж тусалдаг, 25 хувь нь заримдаа тусалдаг
- 6-9 дүгээр ангийн сурагчдын 40 хувь нь ангийн хүүхдүүд маань үргэлж тусалдаг, 33.3 хувь нь заримдаа тусалдаг гэжээ.

Ангийнхаа тусгай хэрэгцээтэй найздаа тусалдаг гэсэн сурагчид өөрөө хэр их тусалж дэмжиж байгааг авч үзвэл:

- 4-5 дугаар ангийн сурагчдын 50 хувь үргэлж, 37.5 хувь нь заримдаа тусалдаг гэж өөрсдийн дэмжлэгийг үнэлжээ.
- 6-9 дүгээр ангийн сурагчдын 23.3 хувь нь үргэлж, 43.3 хувь нь заримдаа тусалдаг, 30 хувь нь хаяа тусалдаг гэж өөрийн дэмжлэгийг үнэлжээ.

Тусгай хэрэгцээтэй найздаа ангийнхан нь хэр их тусалж байгааг нь харьцуулбал бага ангийн хүүхдүүдийн 66.7 хувь нь тусгай хэрэгцээтэй найздаа “үргэлж тусалдаг” гэж хариулсан бол дунд ангийнхны 50 хувь нь ийнхүү хариулснаас үзэхэд бага ангийнхан дунд ангийнхнаас 16.7 хувиар илүү байна.

Зураг 8. Ангийнхаа тусгай хэрэгцээтэй хүүхдэд туслах бусад хүүхдийн болон өөрийн дэмжлэг, давтамж, ангиар



Тусгай хэрэгцээтэй найздаа 4-5 дугаар ангийн хүүхдүүд нь ямар үед нь тусалж байгааг авч үзвэл хичээлээ хийхэд нь (75%), тусламж хэрэгтэй үед нь (70.8%), сэтгэлээр унасан үед нь (66.7%), хэрэгцээтэй зүйлсээ хуваалцаж (62.5%) голлон тусалж байна. 6-9 дүгээр ангийн хүүхдүүд хичээлийг нь зааж өгөх, тусламж хэрэгтэй үед нь болон сэтгэлээр унасан үед нь дэмжих нь бусад тохиолдлуудаас илүү байна.

Зураг 9. Ангийнхаа тусгай хэрэгцээтэй найздаа үзүүлдэг тусламж, дэмжлэг /олон сонголттой/



Судалгаанд оролцсон тусгай хэрэгцээгүй сурагчдаас ангийнхаа тусгай хэрэгцээтэй хүүхдэд хэрхэн, (яаж) тусалж дэмждэгийг нээлттэй асуултаар тодруулсан ба дараах 4 хэсэгт бүлэглэн авч үзье. Үүнд:

1. Хичээлийг нь зааж өгч, даалгавар хийх, сурах үйлд нь туслах
2. Сургууль, анги танхимд орох гарах, зам гарахад туслах
3. Сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх
4. Хэрэгцээтэй зүйлсээ хуваалцах, үйлдэл хийхэд нь тусгай хэрэгцээт найздаа тусалдаг байна.

Хүснэгт 9. Ангийнхаа тусгай хэрэгцээтэй хүүхдэд туслах хэлбэрүүд, ангиар

4-5 дугаар ангийн сурагчид ангийнхаа тусгай хэрэгцээтэй хүүхдэд туслах хэлбэр	6-9 дүгээр ангийн сурагчид ангийнхаа тусгай хэрэгцээтэй хүүхдэд туслах хэлбэр
1. Хичээлийг зааж өгөх, даалгавар хийх, сурах үйлд нь туслах	
<ul style="list-style-type: none"> - Хичээлийг нь зааж өгдөг. - Гэрийн даалгавар хийхэд нь тусалдаг. - Ойлгохгүй хичээлийг нь зааж өгдөг. - Хичээл бичих, уншихад нь тусалдаг. - Тоо бодох, давтахад нь тусалдаг. - Үсэг бичих, цээж бичиг хийхэд нь тусалдаг. - Ном уншихад тусалдаг. - Сонсохгүй зүйлийг нь хэлж өгдөг. 	<ul style="list-style-type: none"> - Хичээлийг зааж өгдөг. - Хичээл нөхөхөд нь тусалдаг. - Даалгавар хийхэд нь тусалдаг. - Ойлгохгүй байгаа хичээлийг нь зааж өгдөг. - Мэдэхгүй зүйлийг зааж өгдөг. - Сонсголгүй хүүхдэд багшийн яриаг орчуулж өгдөг.
2. Сургууль, анги танхимд орох гарах, зам гарах, хамт явах	
<ul style="list-style-type: none"> - Шатаар гарах, буухад нь тулж, өргөж тусалдаг. - Сандал ширээ засахад нь тусалдаг. - Сургууль, ангид орж гарахад нь тусалдаг. - Биеийн тамирын хичээл рүү түрж оруулдаг. - Харааны бэрхшээлтэй найздаа зам гарахад нь хөтөлж явдаг. - Ээжид нь хүргэж өгдөг. 	<ul style="list-style-type: none"> - Шатаар гарах, буухад нь түшиж тусалдаг. - Сургуулиас орж гарахад тусалдаг. - Буудал хүргэж унаанд суулгадаг. - Хамт явдаг. - Завсарлахад дагуулж явдаг. - Усанд явахад нь тусална.
3. Сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх	
<ul style="list-style-type: none"> - Нааш ир гэж дуудахад нь тусалдаг. - Сэтгэлээр унасан үед нь дэмжиж, тусалдаг. - Гомдсон үед нь аргаддаг. - Хүүхдүүдэд сануулж тусалдаг. - Хүүхэд шоолбол багшид хэлдэг. - Хэцүү байгаа үед нь тусалдаг. 	<ul style="list-style-type: none"> - Гомдоосон үед юм авч өгдөг. - Сэтгэл санаагаар унасан үед тусалдаг. - Хамт тоглодог, сэтгэхүй хөгжүүлэх тоглоомоор тоглодог. - Бие тамир дээр цуг тоглодог. - Хүүхдүүд дээрэлхэж шоолбол өмөөрдөг.
4. Хэрэгцээтэй зүйлсээ хуваалцах, үйлдэл хийхэд нь туслах	
<ul style="list-style-type: none"> - Ариун цэврийн өрөө хүргэж өгөх, ороход нь тусалдаг. - Хэрэгтэй үед нь харандаа, бал, будгаа өгдөг. - Гутлыг нь үдэж өгдөг. - Аяга угааж өгч тусалдаг. - Хоол цайг нь аягалж өгдөг. 	<ul style="list-style-type: none"> - Хичээлийн хэрэгслээ хуваалцдаг. - Хэрэгцээтэй зүйлээ хуваалцдаг. - Бал, харандаагаа өгдөг. - Зургийг нь дарж өгдөг. - Харахгүй байгаа зүйлд нь тусалдаг - Сонсохгүй зүйлийг нь хэлж өгдөг.

... Манайд тэргэнцэртэй 2, 3 хүүхэд байдаг. Сурагчдын Өөрөө Удирдах Зөвлөлийн хүүхдүүд цайны газар луу явдаг зам доголтой байсныг нь засаж налуу болгосон. Сурагчид санаачилгыг өөрсдөө гаргаж оролцсон. СӨУЗ-ийн хүүхдүүд сургуулийн сурагчдад тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтууд орж байгаа. Хүүхдүүдээс ийм санаачилга гарч байгааг их зөв зүйл гэж харж байна.

Сургуулийн удирдлагын төлөөлөл, багш нартай хийсэн ФБЯ-аас. Улаанбаатар хот

Үнэлгээнд оролцсон зорилтот сургуулиудын сурагчдын ангийнхаа тусгай хэрэгцээтэй хүүхдийг хичээлээ хийх, сургуульдаа явахад тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг тодорхойлсон байдал 2021, 2022 онуудад хийгдсэн суурь судалгааны үр дүнгүүдтэй харьцуулан буурсан байна. Ялангуяа 4-5 дугаар ангийн сурагчдын хариултаас авч үзвэл тусгай хэрэгцээтэй хүүхдэд хандах хүүхдүүдийн

сөрөг хандлага, ялгаварлан гадуурхалт, багш нарын харилцаа зэргээс шалтгаалсан тусгай хэрэгцээтэй хүүхдийн сургууль, хичээлдээ явахад тулгарах хүндрэл бэрхшээл суурь судалгааны түвшнээс эрс буурсан байна. Бусад гэсэн нээлттэй хариултын хэсэгт тусгай хэрэгцээтэй сурагчийн онцлогоос шалтгаалсан хариултуудаас хамаарч тоо нэмэгдсэн байна.

Хүснэгт 10. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд хичээлээ хийх, сургуульдаа явахад тулгарч буй хүндрэл бэрхшээл (Ангийн сурагчдын үнэлгээгээр)

№	Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тулгардаг хүндрэл бэрхшээл	Суурь судалгаа I		Суурь судалгаа II	Эцсийн үнэлгээ	
		4-5 дугаар анги (32)	6-9 дүгээр анги (48)	4-9-р анги (79)	4-5 дугаар анги (32)	6-9 дүгээр анги (48)
1	Хүүхдүүд муухай ханддаг	50.0	31.3	42.1	15.6	20.8
2	Ялгаварлаж гадуурхдаг	16.7	31.3	21.1	6.3	16.7
3	Багш харьцаж чаддаггүй	8.3	6.3	21.1	3.1	10.4
4	Анги, танхим хэцүү байдаг (ширээ, сандал)	25.0	18.8	15.8	6.3	4.2
5	Бусад:	0.0	12.3	5.3	68.8	47.9

Дээрх асуултад хариулахдаа сурагчид “Бусад” гэсэн нээлттэй хариултын хэсэгт тусгай хэрэгцээтэй хүүхдэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлүүдийг тодорхой бичсэн ба бүлэглэн үзвэл хоёр гол бэрхшээлийг авч үзжээ. Үүнд: 1. Сургуульд ирж, очих зам муу, гэр хол, бие даан сургуульдаа явж чадахгүй байх нь тэргэнцэртэй болон харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгарч байгаа гол бэрхшээл болж байна. 2. Хичээлийн хоцрогдол. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд хичээлээ ойлгохгүй хоцрох, сонсохгүй байх, бичихэд нь гар өвдөх зэрэг бэрхшээлүүд тулгардаг байна.

Хүснэгт 11. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд хичээл, сургуульдаа явахад нь тулгарч байгаа хүндрэл бэрхшээл

Бэрхшээл	4-5 дугаар ангийн сурагчид	6-9 дүгээр ангийн сурагчид
Сургуульд явах зам муу, гэр хол, бие даан явахад хэцүү	<ul style="list-style-type: none"> Ганцаараа явахад хэцүү байдаг Алхаж чаддаггүй болохоор явахад нь хэцүү байдаг Гэрээсээ сургууль хүртэл тэргэнцэртэй ирэхэд хэцүү байдаг Харааны бэрхшээлтэй болохоор зам муу хардаг Гэр хол 	<ul style="list-style-type: none"> Ганцаараа сургуульдаа ирэх Ганцаараа хичээлдээ ирж чадахгүй, замаа мэддэггүй Өглөө харанхуйд ирэх Шатаар гарах хүндрэлтэй Гэр нь хол
Хичээлийн хоцрогдол их, хичээл хүлээн авах чадвар	<ul style="list-style-type: none"> Хичээлийн хоцрогдол их, ойлгохгүй байх Сонсголын улмаас хичээлээ сонсохгүй байх Юм сонсохгүй, цээж бичиг хийхэд нь хэцүү байдаг Хичээлээ бичихдээ хоцрох, гар нь өвдөх 	<ul style="list-style-type: none"> Багшийн хэлж байгаа үгийг нь ойлгож чаддаггүй Хичээлээ ойлгохгүй хоцордог Биеийн тамирын хичээл хэцүү байдаг Зарим үед багшийн ярьж байгаа зүйлсийг сонсдоггүй. Чимээ шуугианаас болоод сонсож чаддаггүй


Үнэлгээнд оролцсон бага, дунд ангийн сурагчдаас ангийнх нь тусгай хэрэгцээтэй найзад нь ямар дэмжлэг, туслалцаа хамгийн их хэрэгтэй байгаа талаар тодруулахад 1. Сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх 2. Ойр дотно харилцах, ярилцах, найзлах 3. Хичээл, сурлагад нь тусалж дэмжих 4. Эрүүл мэнд, эмчилгээнд нь анхаарах 5. Ялгаварлан гадуурхахгүй байх гэсэн үндсэн дэмжлэгүүд тусгай хэрэгцээтэй хүүхдэд хамгийн их хэрэгтэй байна гэж үзэж байна.

Хүснэгт 12. Тусгай хэрэгцээтэй найзад нь хамгийн их хэрэгтэй байгаа дэмжлэг

	4-5 дугаар ангийн сурагчид	6-9 дүгээр ангийн сурагчид
Сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх	<ul style="list-style-type: none"> - Сэтгэл санаагаар дэмжиж туслах - Гомдсон үед нь дэмжих - Зоригжуулах хэрэгтэй - Найзуудыг нь сэтгэлээсээ ханддаг байлгах - Сайн халамжлах - Эелдэг харилцах 	<ul style="list-style-type: none"> - Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх - Хүсэл тэмүүллийг нь дэмжих - Хүүхдүүд анхаарал тавих - Баярлуулах - Хүндлэх - “Чи чадна” гэх мэт урмын үг хэлэх
Ойр дотно харилцах, ярилцах, найзлах	<ul style="list-style-type: none"> - Өөрийгөө илэрхийлэхэд нь сургах, туслах - Ярилцах - Дотно байх - Өөрийг нь бүх хүүхэдтэй найзлахыг хүсдэг болгох - Туслах хүн хажууд нь байх 	<ul style="list-style-type: none"> - Нийтэч болгох - Зөвөөр ойлгох - Тусалж дэмжих - Ярилцаж өөрийг нь дэмждэг байх - Бусад хүүхдүүд эелдэг харьцах - Дотно найзлах, сайн найзууд болох
Хичээл, сурлагад нь тусалж дэмжих	<ul style="list-style-type: none"> - Хичээлээ хийхэд нь туслах - Ойлгохгүй байгаа зүйлийг нь сайн хэлж, зааж өгөх - Ном уншиж сургах - Хийх ёстой юмыг нь чиглүүлж өгөх - Тэмцээн, урлагийн үзлэгт ороход нь дэмжих /Тэр хүүхдэд хэрэгтэй хувцас нь олддоггүй/ 	<ul style="list-style-type: none"> - Сурлагад нь анхаарах - Багш нар эвийг нь олж харилцах, хичээлийг нь сайн ойлгуулах - Хичээлийг эхнээс нь зааж өгөх - Үгээ бичиж чадахгүй бол гарыг нь зүгшрүүлж бичиж өгөх - Хоцорсон хичээлд нь хүүхэд бүр тусалдаг байвал
Эрүүл мэнд, эмчилгээнд анхаарах	<ul style="list-style-type: none"> - Чихний хагалгаанд оруулах - Эмнэлгийн тусламж авах - Гар хөлийг нь зүгээр болгох - Сонголыг нь сайжруулах дасгал хийлгэх - Хэл ярианы асуудлыг нь эмчлүүлэх - Хэл яриаг нь хөгжүүлэх - Амны хайрцаг уншдаг болгох - Хөлд оруулах 	<ul style="list-style-type: none"> - Сонсох тал дээр туслах - Дохионы хэл сурах - Тэр найз маань зүгээр л энгийн хүүхэд. Гар нь л зүгээр болчихвол - Хэл яриаг нь хөгжүүлэх
Гадуурхахгүй байх	<ul style="list-style-type: none"> - Гадуурхахгүй байх - Цохихгүй байх - Зарим хүүхдүүд дээрэлхэхгүй байх 	<ul style="list-style-type: none"> - Гадуурхахгүй байх - Шоолсон, ялгаварлан гадуурхсан үед туслах - Зарим багш нар зөв харьцах


Судалгаанд оролцсон бага болон дунд ангийн сурагчдын хоёр хүүхэд тутмын нэг нь анги удирдсан багшаа бүх хүүхэдтэй адил тэгш хандаж “маш сайн” харилцаж чаддаг гэж дүгнэж байна. Мөн бага ангийн сурагчдын 46.5 хувь, дунд ангийн сурагчдын 47.7 хувь нь ангийн багшийгаа бүх хүүхэдтэй адил тэгш харилцаж “чаддаг” гэж үнэлжээ.

Зураг 10. Анги удирдсан багш бүх хүүхдүүдтэй адил тэгш хандаж харилцах байдал, сурагчдын үнэлгээгээр




Анги дээрээ болон сургууль дээрээ болсон зүйлийнхээ талаар гэрийнхэнтэйгээ ярилцдаг эсэхийг судалгаанд оролцсон тусгай хэрэгцээгүй хүүхдүүдээс тодруулахад 5-4 хүүхэд тутмын нэг л байнга гэр бүлийнхэнтэйгээ ярилцаж байгаа бол гурван хүүхэд тутмын нэг нь заримдаа ярилцдаг байна. Хаяа болон ярилцдаггүй гэж хариулсан хүүхдүүдийн эзлэх хувь 43-46 хувийг эзэлж байгаа нь гэр бүлийнхний зүгээс хүүхдүүдэд хандахдаа анги сургуулийн орчинд өрнөсөн зүйлсийн талаар нь хэвшмэл байдлаар хандах, анхаарал хандуулах нь бага байгааг харуулж байна.

Зураг 11. Анги, сургууль дээр болсон зүйлийнхээ талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцдаг эсэх



Үнэлгээнд оролцсон 4-5 дугаар ангийн сурагчдын 93 хувь нь ангийн багш болон гэр бүл, ойр дотнынхон нь тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж дэмжих талаар байнга зааж тайлбарладаг гэсэн байна. 6-9 дүгээр ангийн сурагчдын 81.4 хувь нь ангийн багш нь, 79.5 хувь нь гэр бүл ойр дотнынхон нь тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж, дэмжих талаар тайлбарлаж захидаг гэж хариулжээ.

Зураг 12. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж дэмжих талаар ангийн багш, гэр бүлийнхэн нь захиж тайлбарладаг эсэх



Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж дэмжих талаар ангийн багш болон гэр бүл, ойр дотнынхон нь юу гэж захидаг талаар сурагчдын хариултуудыг нэгтгэн дараах дөрвөн бүлэгт хуваан үзье. Үүнд: 1. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж дэмжих 2. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх 3. Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ойр дотно, зөв харилцах 4. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн тусгай хэрэгцээний онцлогийг ойлгох, туслах талаар захиж, тайлбарлаж байсан байна.

Хүснэгт 13. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж дэмжих талаар ангийн багш болон гэр бүлийнхний нь захиж хэлдэг зүйлс

Захиас	Ангийн багш нь захиж хэлдэг зүйлс	Гэр бүлийнхэн нь захиж хэлдэг зүйлс
Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж дэмжих	<ul style="list-style-type: none"> - Найздаа сайн туслаарай, та нар чадна шүү. - Тусалж, дэмжиж байгаарай - Хичээлд нь тусалж байгаарай - Зөв үлгэр дуурайлал үзүүлээрэй - Нэгэндээ нийтэч, тусалж дэмжиж байгаарай - Ойлгохгүй зүйлийг нь зааж өгөөрэй - Тоог нь зааж өгч байгаарай - Ганцааранг нь бие засуулж болохгүй 	<ul style="list-style-type: none"> - Тусгай хэрэгцээтэй найздаа тусалж дэмжиж байгаарай - Бүх хүүхдэд туслах ёстой шүү гэж захидаг - Ойлгохгүй байгаа хичээлийг нь зааж өгөөрэй - Даалгаврыг нь бичиж өгөөрэй - Тэр хүүхдэд чамаас илүү хэцүү байгаа болохоор тэр хүүхдийг ойлгож, тусалж дэмжих хэрэгтэй - Чамаас өөр хүн байхгүй учраас тусалж байгаарай
Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх	<ul style="list-style-type: none"> - Гадуурхаж болохгүй - Битгий дээрлэхээрэй - Битгий шоолоорой - Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бүү шоглоорой - Доромжилж болохгүй - Тэгш харилцах ёстой гэдэг - Та нартай адилгүй хүүхэд учраас ялгаварлан гадуурхаж болохгүй - Адил тэгш харилцаж байгаарай 	<ul style="list-style-type: none"> - Битгий гадуурхаарай - Битгий шоолоорой - Битгий дээрлэхээрэй, шоглож болохгүй - Үг хэлээр доромжилж болохгүй - Адилхан хүн, адилхан хүүхдүүд шүү гэдэг - Ялгаварлан гадуурхаж болохгүй шүү - Зарим хүүхдүүд тусгай хэрэгцээтэй хүүхдийг дээрлэхэж байвал таслан зогсоож, яаж туслахыг нь зааж өгч байгаарай
Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ойр дотно, зөв харилцах	<ul style="list-style-type: none"> - Ойлгож байгаарай - Эелдэг зөв харьцаж байгаарай - Эерэг дотно харилцаарай - Уурлуулж болохгүй - Найзыхаа битгий гомдоогоорой - Дээрлэхэж, загнаж болохгүй - Хамт тоглож байгаарай, хамт байгаарай 	<ul style="list-style-type: none"> - Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй эелдэг харьцаж байгаарай - Эвтэй найртай харьцаж, битгий муудалцаарай, зөрчилдөж болохгүй шүү, - Уучлал гуйж байгаарай - Хүлээн зөвшөөрөх - Найзтайгаа сайн найзлаарай
Тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлогийг ойлгохыг тусгайлан захих	<ul style="list-style-type: none"> - Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхэдтэй таарвал тусалж байгаарай - Хараа муутай хүүхэд таарвал шатаар буухад нь туслаарай - Тэргэнцэртэй хүнд их тусалж байгаарай - Зам гарахад тусалж байгаарай - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусалж дэмжиж байгаарай 	<ul style="list-style-type: none"> - Харааны бэрхшээлтэй хүүхэд байвал тусалж дэмжиж байгаарай - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг автобусанд суулгаж өгөөрэй гэдэг - Шатаар гарч чадахгүй бол гаргаж өгөөрэй - Тэргэнцэртэй хүүхэдтэй тааралдвал түрж өгөх үү гэж асуугаад за гэвэл туслаарай гэдэг

- Манай ээж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй сайн харилцаарай гэж хэлдэг. Аав ч гэсэн зөндөө хэлдэг. Манай ээж, аав хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй зөөлөн харилцаж, тусалж дэмжиж байгаарай гэдэг.
- Манай аав, ээж ажилтай байдаг ч надад өдөр болгон сануулдаг. Тэр хүүхэдтэй ингэж харьцаарай гэдэг. Хааяадаа муухай харилцвал тэр хүүхэд чамд муу саначихвал эвгүй шүү дээ гээд дандаа сануулдаг.
- Манай эмээ ер нь их захидаг. Тийм хүүхдийг битгий ялгаварлаж харьцаарай, тэр хүүхэд дотоод сэтгэлдээ зүв зүгээр хүүхэд, хүнийг гаднаас нь битгий дүгнэж байгаарай гэдэг.
- Чи хүмүүсийг битгий гаднаас нь дүгнэ, хүмүүстэй ярилцаад үз, сайхан ааштай гоё хүмүүс байгаа гэдэг.

6-9 дүгээр ангийн сурагчидтай хийсэн ФБЯ-аас. Улаанбаатар хот

Тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаар ангийн багш, гэр бүл ойр дотнынхны зүгээс захиж хэлдэг зүйлсээс харвал тусгай хэрэгцээтэй хүүхдэд ангийн найз, үе тэнгийнхний харилцаа хандлага ямар чухал болохыг ойлгуулах, дотно найрсаг харилцааг дадуулах, тусгай хэрэгцээний онцлог, ялгаатай байдлыг нь ойлгож хүлээн зөвшөөрөх, тусалж дэмжих, гадуурхал ялгаварлалаас ангид адил тэгш хандах зэрэгт чиглэсэн байнгын эерэг нөлөөллийг сурагчдад тэдний багш, гэр бүлийнхэн нь үзүүлж байгаа нь харагдаж байна.

Тусгай хэрэгцээтэй хүүхдэд хандах сургуулийн хүүхдүүд болон сургуулийн багш, ажилтнуудын хандлагыг сурагчид хэрхэн дүгнэж байгааг авч үзвэл бага ангийн сурагчдын 97.7 хувь нь ангийн багш, 83.7 хувь нь гэр бүлийнхэн, 81.4 хувь нь бусад багш нар, 79.1 хувь нь сургуулийн ажилтнууд, 79.1 хувь нь ангийн хүүхдүүд маань тусгай хэрэгцээтэй хүүхдэд сайн ханддаг гэж үнэлжээ. Дунд ангийн сурагчдын 88.6 хувь нь ангийн багш, 77.3 хувь нь сургуулийн ажилтнууд, 75 хувь нь бусад багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдэд сайн ханддаг гэж үнэлж байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд бусад ангийн хүүхдүүд болон ахлах ангийн гурван хүүхэд тутмын нэг нь тааруу ханддаг байна.

Хүснэгт 14. Сургуулийн багш, ажилтнууд, ангийн сурагчдын тусгай хэрэгцээтэй хүүхдэд хандах хандлага

№	Талууд	Сайн		Тааруу		Мэдэхгүй	
		4-5 дугаар анги	6-9 дүгээр анги	4-5 дугаар анги	6-9 дүгээр анги	4-5 дугаар анги	6-9 дүгээр анги
1	Ангийн багш	97.7	88.6	2.3	2.3	0.0	9.1
2	Танай гэр бүл /эцэг эх, асран хамгаалагч/	83.7	68.2	9.3	13.6	7.0	18.2
3	Бусад багш нар	81.4	75.0	4.7	9.1	14.0	15.9
4	Сургуулийн ажилтнууд	79.1	77.3	14.0	11.4	7.0	11.4
5	Танай ангийн хүүхдүүд	79.1	63.6	18.6	29.5	2.3	6.8
6	Бусад эцэг эхчүүд	51.2	40.9	4.7	18.2	44.2	40.9
7	Ахлах ангийн хүүхдүүд	34.9	43.2	23.3	15.9	41.9	40.9
8	Бусад ангийн хүүхдүүд	30.2	22.7	32.6	38.6	37.2	38.6

...Манай ангийн Г өмнө нь хүүхэдтэй харилцдаггүй, их дотогшоо, ил ярьдаггүй байсан. Ангидаа ирээд суучаад гараад явчихдаг байсан. Одоо бол их нийтэч болоод ангийнхандаа харьцаж эхлээд улам нээлттэй болж эхэлж байгаа. Манай ангийнхан саажилттай гэдэг үтгээр ялгаварлахгүйгээр харьцаж байгаа.

6-9 дүгээр ангийн сурагчидтай хийсэн ФБЯ-аас. Улаанбаатар хот

Судалгаанд оролцсон сурагчдаас ангийнхан нь тусгай хэрэгцээтэй найзтайгаа сургууль, ангийн үйл ажиллагаанд хамт байдаг эсэхийг асуухад 4-5 дугаар ангийн сурагчид баяр тэмдэглэх (72.1), чөлөөт цагаа өнгөрөөх (69.8), хичээлээ давтах (67.4), ангийн хуралд оролцох (65.1), ангиараа уулзах (60.5) зэрэгт хамгийн их хамт байдаг байна. 6-9 дүгээр ангийн сурагчдын хувьд урлагийн үзлэгт бэлдэн орох (79.5), ангиараа уулзах (77.3), баяр тэмдэглэх (75.0), ангийн хуралд орох (68.2) зэрэг голчлон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд тусгай хэрэгцээтэй найзтайгаа хамгийн их хамт байдаг байна.

Хүснэгт 15. Ангийн хүүхдүүд нь тусгай хэрэгцээтэй найзтайгаа сургууль, ангийн үйл ажиллагаанд хамт байдаг эсэх

№	Үйл ажиллагаа	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
		4-5 дугаар анги /43/	4-5 дугаар анги /43/	6-9 дүгээр анги /44/	6-9 дүгээр анги /44/
1	Баяр тэмдэглэх	72.1	27.9	75.0	25.0
2	Чөлөөт цагаа өнгөрөөх	69.8	30.2	59.1	40.9
3	Хичээлээ давтах	67.4	32.6	59.1	40.9
4	Ангийн хуралд оролцох	65.1	34.9	68.2	31.8
5	Ангиараа уулзах	60.5	39.5	77.3	22.7
6	Үзвэр үйлчилгээ үзэх	55.8	44.2	56.8	43.2
7	Урлагийн үзлэгт бэлдэх, орох	53.5	46.5	79.5	20.5
8	Сургалт, аян, өдөрлөгт орох	53.5	46.5	59.1	40.9
9	Спортын тэмцээн, уралдаан	39.5	60.5	45.5	54.5
10	Дугуйлан, клубт явах	34.9	65.1	31.8	68.2
11	Бусад	20.9	79.1	15.9	84.1

Зорилтот сургуулиудын дунд ангийн сурагчдад зохион байгуулсан тэгш хамруулах боловсролын талаарх сургалтад 6-9 дүгээр ангийн сурагчдын 50 хувь хамрагдсан бол 45.5 хувь нь хамрагдаагүй, 4.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Сургалтад хамрагдсан сурагчдаас тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсанаар тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх мэдлэг, ойлголтод нь өөрчлөлт гарсан эсэхийг тодруулахад дунд ангийн сурагчдын 31.8 хувь нь мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, 63.6 хувь нь мэдлэг, ойлголт өмнөхөөсөө нэмэгдэж тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлогийн талаар ойлголт, мэдлэг нь сайжирсан байна.

Зураг 13. Тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан сурагчдын мэдлэг, ойлголтод нь өөрчлөлт гарсан эсэх



Тусгай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээрх сургалтад хамрагдсанаар мэдлэг, ойлголт нь өмнөхөөсөө мэдэгдэхүйц болон өмнөхөөсөө нэмэгдсэн гэж хариулсан хүүхдүүдэд ямар гол өөрчлөлтүүд гарсныг авч үзвэл:

1. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн тухай ойлголт, мэдлэгтэй болж тэдний сурч хөгжих онцлогийн талаар мэдэж авсан.
2. Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй харилцах харилцаан дээр тэдэнтэй хэрхэн харилцах арга барилаа мэддэггүй байсан бол мэдэж авч, өмнө нь харьцдаггүй байсан бол харилцах, ярилцах болж, дотно, найрсаг хандах, ойлгож, хүлээн зөвшөөрөх, илүү сайн хандах, бусдад хүүхдүүдээс ялгаатай биш, адил боломж байгаа тул өөртөө итгэлтэй байхад нь дэмжих болсон.

3. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх чиглэлээр тэдэнд хэрхэн тусалж, дэмжих тухай мэдэж авч байнга тусалж дэмжих болсон.
4. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх, хамгаалах, шийдвэр гаргахдаа өөрийнхөө оронд тавьж боддог болсон.

2.2 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН БАГА АНГИАС ДУНД АНГИД ДЭВШИН СУРАЛЦАХ БЭЛТГЭЛ ХАНГАЖ БҮЙ БАЙДАЛ

Энэ хичээлийн жилд 4-5 дугаар ангид суралцаж буй тусгай хэрэгцээтэй хүүхдийн 63.3 хувь нь бага ангиас дунд ангид ороход бэлтгэн анги удирдсан багш нь ангийнхантай нь ярилцаж байсан гэж хариулжээ. Мөн 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 79.5 хувь нь анги дэвшин суралцах талаар анги удирдсан багш нь тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ярилцаж байсан байна.

Зураг 14. Бага ангиас дунд ангид дэвшин суралцах талаар ангийн багш нь тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй ярилцаж байсан эсэх




“Суурь судалгаа I”-д хамрагдсан бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн 60 хувь нь, “Суурь судалгаа II”-д хамрагдсан тусгай хэрэгцээтэй хүүхдийн 59.3 хувь нь бага ангиас дунд ангид дэвшин суралцах бэлтгэл хангаж байсан бол эцсийн үнэлгээгээр тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн 63.3 хувь нь бага ангиас дунд ангид дэвшин суралцахтай холбоотой сургууль, багш, эцэг эхээс дэмжлэг үзүүлж бэлтгэл хангаж байгаа гэж хариулсан байна.

Хүснэгт 16. Бага ангиас дунд ангид дэвшин суралцах бэлтгэл хангаж байсан эсэх

№	Он	Бага анги		Дунд анги		
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй	
1	Суурь судалгаа I	2021 он	/33/ 60.0	40.0	/39/ 66,1	33,9
2	Суурь судалгаа II	2022 он	/39/ 59.3	40.7	/40/ 33.3	66.7
3	Эцсийн үнэлгээ	2023 он	/30/ 63.3	36.7	/39/ 79.5	20.5


Судалгаанд оролцсон бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг анги дэвшин сурахад нь бэлтгэн ангийн багш нь ямар чиглэлээр мэдээлэл өгч байгааг авч үзвэл 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 23.4 хувь нь дунд ангийн багш нарын талаарх мэдээлэл, 20.3 хувь нь холбогдох бусад мэдээлэл, 17.2 хувь нь хэнээс тусламж хүсэх тухай мэдээллийг өгч тайлбарласан гэж үзсэн байна. 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн хувьд ангийн багш нь олон төрлийн хичээл ордог талаар (27.3), дунд ангийн багш нарын талаар (19.3), анхаарах зүйлсийн талаар (19.3), бусадтай эелдэг харилцаатай байх талаар (15.9) мэдээлэл өгч тайлбарласан байна.

Зураг 15. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг анги дэвшин сурахад нь бэлтгэн ангийн багшийн зүгээс өгсөн мэдээлэл




Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүд бага ангиас дунд ангид дэвшин суралцахад бэлтгэн 31.1 хувь нь ном уншиж, 29.5 хувь нь хичээлээ сайн хийж, 13.1 хувь нь сэтгэл зүйгээ бэлдэж, 11.5 хувь нь нэмэлт давтлага авч байна.

Зураг 16. Бага ангиас дунд ангид дэвшин сурахад бэлтгэж буй байдал (4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн хариултаар)



4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн хувьд бага ангиас дунд ангид дэвшин сурахад тулгарах саад бэрхшээлийн талаар үзэхдээ 20.4 хувь нь хичээлээ гүйцэхгүй байх, 16.7 хувь нь олон багш орох тул харилцахад төвөгтэй байх, 15 хувь нь 5-р ангид дэвших шалгалтдаа тэнцэхгүй байх вий гэсэн айдас, 13 хувь нь олон төрлийн хичээл үзэх нь бэрхшээлтэй байх гэж хариулсан байна. Бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн хувьд хүүхэд нь дунд ангид дэвшин сурахад олон багш орох (26.5), хичээлээ гүйцэхгүй байх (20.6), олон хичээл үзэх (19.6), олон цагаар хичээл орох (17.6) зэрэг нь бэрхшээл болох байх гэж үзэж байна.

Зураг 17. Бага ангиас дунд ангид дэвшин сурахад тулгарч буй саад бэрхшээл



Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүд бүгд (100 хувь) аав ээж, ах эгч, гэр бүлийнхнийгээ “байнга” тусалж дэмждэг, 53.3 хувь нь ангийн хүүхдүүд нь “байнга” тусалдаг гэж гэр бүл, ангийнхныхаа тусламж, дэмжлэгийг үнэлсэн байна. 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн 38.5 хувь нь гэр бүлийнхэн, 28.2 хувь нь ангийн хүүхдүүд нь “байнга” тусалж дэмждэг гэж хариулсан нь гурван хүүхэд тутмын нэг нь гэр бүл, ангийнхныхаа тусламж, дэмжлэгийг байнга авч байгааг харуулж байна. Бага ангийнхныг бодвол дунд ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд гэр бүл болон ангийнхныхаа тусалж дэмжлэгийг “заримдаа” болон “хаяа” авдаг гэсэн хариулт буурч байгаа нь анги ахих тутам тэдний бие даан сурах, асуудлыг шийдвэрлэх чадвар нэмэгдэж, гэр бүлийнхний анхаарал, оролцоо буурч байгааг харуулж байна.

Хүснэгт 17. Бага, дунд ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдэд гэр бүлийнхэн, ангийн хүүхдүүдийн тусалдаг байдал

№	Тусламж дэмжлэг	Гэр бүлийнхэн		Ангийн хүүхдүүд	
		4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэд	6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэд	4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэд	6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэд
1	Байнга	100	38.5	53.3	28.2
2	Заримдаа	0.0	33.3	30	38.5
3	Хаяа	0.0	20.5	10	17.9
4	Тусалдаггүй	0.0	7.7	6.7	15.4

Тусгай хэрэгцээтэй хүүхдэд гэр бүлийнхэн нь хэрхэн тусалж, дэмжиж байгааг авч үзвэл бага ангийнхны хувьд даалгавар хийх (23.1), сургуульд хүргэж өгч, авахад (24.1) гэр бүлийнхний тусламж, оролцоо дунд ангийнхантай харьцуулахад их байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хувийн ариун цэвэрт анхаарах, хувцсыг нь угаан өгөх, сургуульд хэрэгцээтэй зүйлсийг бэлдэж өгөх зэргээр туслахад бага, дунд ангийнхны хувьд хол зөрүүгүй гэр бүлийнхэн нь адилхан тусламж дэмжлэг үзүүлж байна.

Хүснэгт 18. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд гэр бүлийнхэн нь тусалж дэмжих байдал (Бага, дунд ангиар)

№	Гэр бүлийнхний тусламж дэмжлэг	4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэд	6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэд
1	Даалгавар хийхэд тусалдаг	23.1	16.1
2	Сургуульд хүргэж өгч авдаг	24.1	12.9
3	Сургуулийн үйл ажиллагаанд хамт оролцдог	9.3	11.6
4	Ямар нэг хүндрэл бэрхшээл тулгарахад зөвлөгөө өгдөг	8.3	14.2
5	Хувийн ариун цэвэрт анхаардаг	10.2	12.3
6	Хувцас угааж өгдөг	13.9	17.4
7	Сургуульд суралцахад хэрэгцээтэй зүйлсийг бэлтгэдэг	10.2	14.8
8	Бусад	0.9	0.6

Чанарын судалгааны үр дүнгээс үзвэл тусгай хэрэгцээтэй хүүхдүүд болон тэдний эцэг эх, гэр бүлийнхэн хүүхдийнхээ анги, ангийн багш, сургуулийн ажилтнуудын харилцаа хандлага, дэмжлэгт сэтгэл хангалуун байна.

... Танай хүүхэд ангийнхаа хүүхдүүдтэй хамт суралцахдаа сэтгэл хангалуун байдаг уу?


Охины ангийнхны хувьд бол охин маань нээлттэй учраас найз нөхөдтэйгөө нийтэч. Ангийнхаа багштай ч гэсэн чөлөөтэй, яг л том хүнтэй харьцаж байгаа юм шиг харьцдаг. Тэр нь ийм, энэ нь ийм гээд байх юм байхгүй.

Манай хүүхэд ангийнхандаа сайн. Өөрөө ч хичээлдээ ирж сурах дуртай. Ангийн багш, найзууд нь ч гэсэн найзаа гээд бүх юманд нь тусалж дэмждэг.

Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхтэй хийсэн ФБЯ-аас. Улаанбаатар хот


Судалгаанд оролцсон тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхчүүдийн үнэлснээр тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ангийнхантайгаа хамт суралцаж байгаадаа 44.2 хувь нь маш их сэтгэл хангалуун, 48.1 хувь нь сэтгэл хангалуун гэсэн бол дунд ангийн хүүхдүүдийн 21.6 хувь нь маш их сэтгэл хангалуун, 56.8 хувь нь сэтгэл хангалуун байдаг байна.

Зураг 18. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд бусад хүүхдүүдтэй хамт суралцаж байгаадаа сэтгэл хангалуун байгаа эсэх, эцэг эхийн үнэлгээгээр



Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 36.7 хувь нь ангийнхан бүгд ойр дотно харилцдаг, 50 хувь нь ангийнхаа заримтай л харилцдаг, 13.3 хувь нь нээх харилцаад байдаггүй гэж хариулжээ. Харин судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээгүй сурагчид ангийнхаа тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй харилцахдаа 40 хувь нь ангиараа бүгд ойр дотно харилцдаг гэсэн бол 56 хувь нь зарим нь л харилцдаг гэж хариулсан байна.

Зураг 19. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн ангийнхныхаа харилцааг үнэлсэн байдал




6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн хувьд ангийн хүүхдүүдээ 1. Хичээлийг нь зааж өгдөг (78.8), 2. Сэтгэлээр унасан үед тусалдаг (66.7), 3. Тусламж хэрэгтэй үед нь тусалдаг (60.6), 4. Гэрийн даалгавар хийхэд нь тусалдаг (60.6), 5. Сургуулийн үйл ажиллагаанд оролцоход нь тусалдаг (60.6) гэсэн хариултыг өгсөн ба ангийнхан нь тусламж дэмжлэгийг бүх хэлбэрээр жигд үзүүлж байна.

Хүснэгт 19. Тусгай хэрэгцээтэй найздаа ямар үед, хэрхэн тусалдаг вэ? /олон сонголттой/

№	Тусгай хэрэгцээтэй найздаа ангийнхан нь туслах хэлбэр	4-5 дугаар анги	6-9 дүгээр анги
1	Хичээлийг нь зааж өгдөг	76.7	78.8
2	Сэтгэлээр унасан үед тусалдаг	46.7	66.7
3	Тусламж хэрэгтэй үед нь тусалдаг	43.3	60.6
4	Гэрийн даалгаврыг хийхэд тусалдаг	43.3	60.6
5	Сургуулийн үйл ажиллагаанд оролцоход нь тусалдаг	30.0	60.6
6	Хэрэгцээтэй зүйлсээ хуваалцдаг	30.0	54.5
7	Анги, сургуульд орж гарахад нь тусалдаг	33.3	33.3
8	Бусад: 4-5 дугаар анги: Хувцсыг нь өмсүүлэх, унаанд суулгаж өгөх, ойлгохгүй юмыг нь ойлгуулж хэлж өгөх, чимээгүй байх 6-9 дүгээр анги: Харахгүй зүйлд нь тусалж, зураг дарж өгөх	10.0	15.2

Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд сургуулийн орчинд тусламж хүсэх шаардлага гарвал хамгийн түрүүнд ангийн багшдаа ханддаг гэж бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 25.6 хувь, дунд ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 27.8 хувь нь хариулсан байна. Мөн тусгай хэрэгцээтэй хүүхдийн хувьд сургуулийн орчинд тусламж хүсэхдээ сургалтын менежер, сургуулийн ажилтнууд /номын санч, эмч, жижүүр/, нийгмийн ажилтан зэрэг хүмүүст хандахаасаа илүү гэр бүл, найз, ангийн хүүхдүүдээ түрүүлж хандах хандлагатай байна.

Зураг 20. Сургууль дээр нь тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусламж хүсэх шаардлага гарвал хэнд ханддаг вэ?




Ангийн багш бүх хүүхдүүдээс илүү авч үздэг. Хичээлийн хоцрогдолтой, бид нараас дүү болохоор багш аль болох бүх юман дээр нь тусалж дэмждэг. Сургуулиас ямар нэгэн тусламж дэмжлэг үзүүлбэл багш байнга хамруулдаг. Тэр найз маань аль болох бүх хүүхдүүдээс дэмжлэг авдаг, багш нар ч гэсэн дэмжлэг үзүүлээрэй гээд бид хамтраад байнга тусалдаг. Тэгээд аль болох хичээлийг нь зааж өдөг.

6-9 дүгээр ангийн сурагчидтай хийсэн ФБЯ-аас. Улаанбаатар хот

Анги дээрээ болон сургууль дээрээ болсон зүйлийнхээ талаар гэр бүлийнхэндээ хэлж, хэр зэрэг ярилцдаг талаар авч үзвэл 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 20 хувь нь байнга, 36.7 хувь нь заримдаа ярилцаж нээлттэй байдаг бол 20 хувь нь хаяа л ярилдаг гэжээ. Дунд ангийнхны хувьд 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 23.1 хувь нь байнга, 45.2 хувь нь заримдаа, 18 хувь нь хааяа гэр бүлийнхэнтэйгээ ярилцдаг байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн гэрийнхэнтэйгээ хичээл, сургуулийнхаа талаар ярилцдаггүй гэж бага ангийнхны 23.3 хувь нь, дунд анагийнхны 13 хувь нь хариулж байгаа нь сургууль, ангид болсон зүйлийн талаар мэдээлэл солилцох, нээлттэй байх, өөрийгөө илэрхийлж сургахад анхаарах шаардлагатайг харуулж байна.

Зураг 21. Анги дээрээ болон сургууль дээр болсон зүйлийнхээ талаар гэрийнхэнтэйгээ ярилцдаг эсэх



Бүлгийн дүгнэлт

Төслийн шалгуур үзүүлэлт 1-т заасан “Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн бага ангиас дунд ангид дэвшин суралцах бэлтгэл сайн хангагдсан байна” гэдэг зорилт хангагдсан байна. Бага ангийн гурван хүүхэд тутмын нэг нь, дунд ангийн хоёр хүүхэд тутмын нэг нь ангийнхаа тусгай хэрэгцээтэй найздаа үргэлж тусалж дэмждэг бол үлдсэн хэсэг нь хэрэгцээтэй үед нь тусалж байна. Тусгай хэрэгцээтэй найздаа хичээлээ хийх, тусламж хэрэгтэй үед нь туслах, сэтгэлээр унасан үед нь туслах, хэрэгцээтэй зүйлсээ хуваалцах байдлаар туслах хэлбэрүүд давамгайлж байна. Ангийнхаа тусгай хэрэгцээтэй найзад нь тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг тусгай хэрэгцээгүй сурагчид тодорхойлохдоо сургуульд ирж очих зам муу, гэр хол, бие даан явахад нь хүндрэл их, хичээл хүлээн авах чадвар, хичээлийн хоцрогдол их байгаа нь тэдэнд нэн тэргүүний бэрхшээл болж байна гэж үзэж байна. Мөн тусгай хэрэгцээтэй найзад нь сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх, ойр дотно харилцах, хичээл, сурлагад нь туслах, эрүүл мэнд, эмчилгээнд нь анхаарах, ялгаварлан гадуурхахгүй байх нь хамгийн их хэрэгтэй дэмжлэг болно гэж үзэж байна. Сургуулийн сурагчид анги удирдсан багш нараа бүх хүүхэдтэй тэгш хандаж чаддаг гэж өндрөөр үнэлж байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж дэмжих талаар ангийн багш, гэр бүл, ойр дотнынхны зүгээс сурагчдад байнга захин, тэдэнтэй дотно найрсаг харилцах, тусгай хэрэгцээний онцлог, ялгаатай байдлыг нь ойлгон хүлээн зөвшөөрөх, тусалж дэмжих, ялгаварлан гадуурхалгүй адил тэгш хандах талаар байнгын эерэг нөлөөллийг үзүүлж байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд сургуулийн бага, дунд ангийн хүүхдүүд, ангийн сурагчид, багш, ажилтнуудын дийлэнх олонх нь сайнаар хандан харилцааны дэмжлэгт орчин өөрчлөгдсөн байна. Зорилтот сургуулийн сурагчдын дунд тэгш хамруулах боловсрол болон тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн дүгнэснээр бага ангиас дунд анги руу дэвшин суралцахад бага ангийн багш нар 63 хувь нь, дунд ангийн багш нарын 80 хувь нь хүүхдүүдэд мэдээлэл өгч, анхаарах зүйлсийг хэлж өгч, шаардлагатай чадварыг эзэмшүүлэхэд анхааран анги дэвшин суралцахад бэлтгэл хангадаг гэж үзэж байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд сургуулийн орчинд тусламж хүсэхдээ хамгийн түрүүнд ангийн багшдаа ханддаг байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхчүүдийн үнэлснээр бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн дийлэнх олонх нь (92.3 хувь) ангийнхантайгаа хамт суралцаж байгаадаа сэтгэл хангалуун байгаа бол дунд ангийн хүүхдүүдийн олонх нь (78.5) сэтгэл хангалуун байна.

БҮЛЭГ ГУРАВ. ЗОРИЛТОТ СУРГУУЛИУДАД ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДИЙГ ХҮЛЭЭН АВАХ БЭЛЭН БАЙДАЛ, БАГШ НАРЫН ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шалгуур үзүүлэлт 2. Суурь боловсролын түвшинд тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг хүлээж авах, дунд ангид суралцах орчинд дасан зохицох үйл явцыг нь дэмжих багшийн ойлголт, мэдлэг, ур чадвар, оролцоо, сургуулийн санал санаачилга сайжирсан байна.

Энэ бүлэгт үнэлгээнд хамрагдсан багш нарын мэдээлэл, тэгш хамруулах боловсролын талаар багш нарын ойлголт, мэдлэг, тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах мэдлэг, ур чадварын түвшин, тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдалт, тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад сургууль, багшийн зүгээс бэлтгэл хангаж буй байдал, тусгай хэрэгцээтэй хүүхдэд үзүүлэх сэтгэл зүйн дэмжлэг, багш нарын туршлага солилцох үйл ажиллагааны талаар тодруулан авч үзнэ.

3.1 СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАГШ НАРЫН МЭДЭЭЛЭЛ


Судалгаанд зорилтот 16 сургуулийн 210 багш хамрагдсанаас 4-5 дугаар анги даасан 78 багш, 6-9 ангийн анги даасан 96 багш, анги даагаагүй 36 багш оролцлоо. Нийт багш нарын 48 хувь нь төслийн эхний жилд сонгогдсон сургуулийнх бол 52 хувь нь төслийн хоёр дахь жилд сонгогдсон сургуулийн багш нар байна. Боловсролын зэргийн хувьд 4-5 дугаар ангийн багш нарын 61.5 хувь нь, дунд ангийн багш нарын 64.6 хувь нь, анги даагаагүй багш нарын 63.9 хувь нь бакалаврын зэрэгтэй байгаа ба гурван багш тутмын нэг нь магистрын зэрэгтэй байна. Багш нарын 70 орчим хувь нь 5-аас дээш жил ажилласан туршлагатай байна.

Хүснэгт 20. Судалгаанд оролцсон багш нарын ерөнхий мэдээлэл, бага, дунд анги, анги даагаагүй байдлаар

№	Үзүүлэлт	Ангилал	4-5 дугаар анги /78/	6-9 дүгээр анги /96/	Анги даагаагүй /36/			
1	Ажилладаг сургууль /төсөл хэрэгжсэн жилээр/	1-р жил	36	100	46	100	19	100
		79-р сургууль, БЗД	4	11.0	7	15.0	2	10.5
		127-р сургууль, БЗД	6	17.0	7	15.0	2	10.5
		37-р сургууль, ЧД	4	11.0	5	11.0	2	10.5
		49-р сургууль, ЧД	4	11.0	6	13.0	2	10.5
		65-р сургууль, СХД	6	17.0	6	13.0	2	10.5
		67-р сургууль, СХД	6	17.0	6	13.0	2	10.5
		2-р сургууль, Өвөрхангай	3	8.0	4	9.0	5	26.5
		7-р сургууль, Ховд	3	8.0	5	11.0	2	10.5
		2-р жил	42	100.0	50	100.0	17	100.0
		Амгалан цогцолбор сургууль, БЗД	6	14.0	9	18.0	2	11.7
		30-р сургууль, БЗД	6	14.0	8	16.0	2	11.7
		61-р сургууль, ЧД	5	12.0	6	12.0	2	11.7
		39-р сургууль, ЧД	4	10.0	6	12.0	2	11.7
		76-р сургууль, СХД	7	17.0	7	14.0	2	11.7
		9-р сургууль, СХД	6	14.0	6	12.0	2	11.7
		1-р сургууль, Өвөрхангай	2	5.0	3	6.0	2	11.7
		3-р сургууль, Ховд	6	14.0	5	10.0	3	18.1
2	Хүйс	Эрэгтэй	75	96.2	89	92.7	31	86.1
		Эмэгтэй	3	3.8	7	7.3	5	13.9
3	Нас	21-29	23	29.5	24	25.0	11	30.6
		30-39	26	33.3	45	46.9	13	36.1
		40-49	15	21.8	23	24.0	10	27.8
		50-59	12	15.4	4	4.2	2	5.6
4	Боловсролын зэрэг	Дипломын	4	5.1	0	0	1	2.8
		Бакалавр	48	61.5	62	64.6	23	63.9
		Магистр	26	33.3	34	35.4	12	33.3
5	Мэргэжлийн зэрэг	Зэрэггүй	21	26.9	30	31.3	14	38.9
		Заах арга зүйч	36	46.2	45	46.9	11	30.6
		Тэргүүлэх зэрэг	20	25.6	21	21.9	11	30.6
		Зөвлөх	1	1.3	0	0.0	0	0.0
6	Багшилсан жил	1-5 жил	21	26.9	30	31.3	11	30.6
		6-10 жил	17	21.8	24	25.0	7	19.4
		11-15 жил	14	17.9	17	17.7	6	16.7
		16-20 жил	9	11.5	11	11.5	8	22.2
		21-дээш жил	17	21.8	14	14.6	4	11.1


Судалгаанд анги даан ажилладаг 174 багш оролцсоны 78 нь 4-5 дугаар анги, 96 нь дунд анги удирдан ажиллаж байна. Бага боловсролын 4 дүгээр анги удирдсан 36 багш байгаа бол 5 дугаар анги удирдсан 42 багш байна. Дунд ангийн анги даасан багш нарын хувьд 6-р анги даасан 23 багш, 7-р анги даасан 19 багш, 8-р анги даасан 29 багш, 9-р анги даасан багш 25 тус тус судалгаанд оролцсон.

Зураг 22. Анги даасан багш нарын хариуцан ажилладаг анги



4-5 дугаар ангийн анги удирдсан багш нарын 66.7 хувь нь 31-40 сурагчтай бол 6-9 дүгээр ангийн анги удирдсан багш нарын 63.5 хувь нь 31-40 сурагчтай ангид ажиллаж байна.

Зураг 23. Анги удирдсан багш нарын анги дахь сурагчдын тоо



Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийг багш нарын 65.4 хувь нь, 6-9 дүгээр ангийн багш нарын 57.3 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй анги даан ажиллаж байна. Бага ангийн багш нарын 34.6 хувь нь даасан анги нь тусгай хэрэгцээтэй хүүхэдгүй байгаа бол дунд ангийн багш нарын 42.7 хувь нь даасан анги нь тусгай хэрэгцээтэй хүүхэдгүй байна.

Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй анги даасан багш нарын ангид хэдэн тусгай хэрэгцээтэй хүүхэд сурч байгааг авч үзвэл 4-5 дугаар анги даасан багш нарын 66.7 хувь 1 тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй, 27.5 хувь нь 2 тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ангитай байна. 6-9 дүгээр анги даасан багш нарын 74.5 хувь нь 1 тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй, 21.8 хувь нь 2 тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй анги даан ажиллаж байна. 30-р сургуулийн бага ангид 5 тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй нэг анги байна.

Хүснэгт 21. Анги даасан багш нарын анги дахь тусгай хэрэгцээтэй хүүхдийн тоо

№	Анги дахь тусгай хэрэгцээтэй хүүхдийн тоо	4-5 дугаар анги		6-9 дүгээр анги	
		Тоо	Хувь (%)	Тоо	Хувь (%)
1	1 тусгай хэрэгцээтэй хүүхэд	34	66.7	41	74.5
2	2 тусгай хэрэгцээтэй хүүхэд	14	27.5	12	21.8
3	3 тусгай хэрэгцээтэй хүүхэд	2	4.0	1	1.8
4	4 тусгай хэрэгцээтэй хүүхэд	0	0.0	1	1.8
5	5 тусгай хэрэгцээтэй хүүхэд	1	2.0	0	0.0
	Нийт	51	100	55	100

Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй анги даан ажилладаг багш нарын ангид сурч байгаа тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн тусгай хэрэгцээний төрлийг авч үзвэл оюуны бэрхшээл, хавсарсан хөгжлийн бэрхшээл, суралцахуйн бэрхшээл, харааны бэрхшээл, хэл ярианы бэрхшээл, аутизмын хүрээний эмгэг гэсэн хэлбэрүүд зонхилж байна. Мөн 4-5 дугаар ангиудад хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд их байна.

Хүснэгт 22. Судалгаанд оролцсон багш нарын анги дахь тусгай хэрэгцээтэй хүүхдийн тусгай хэрэгцээний төрөл /олон хариулттай/

№	Тусгай хэрэгцээний төрөл	4-5 дугаар анги		6-9 дүгээр анги	
		Анги	Хувь	Анги	Хувь
1	Оюун ухааны бэрхшээлтэй	9	15.0	16	27.0
2	Хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй	8	13.3	8	13.6
3	Харааны бэрхшээлтэй	8	13.3	6	10.2
4	Хэл ярианы бэрхшээлтэй	7	11.7	4	6.8
5	Аутизмын хүрээний эмгэгтэй	6	10.0	6	10.2
6	Суралцахуйн бэрхшээлтэй (бичих, унших, тоо бодох)	5	8.3	7	11.9
7	Бусад хэлбэр	5	8.3	6	10.2
8	Хөдөлгөөний бэрхшээлтэй	10	16.7	2	3.4
9	Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтэй	2	3.3	1	1.7
10	Сонсголын бэрхшээлтэй	0	0.0	3	5.0
	Нийт	60	100	59	100

3.2 ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ БАГШ НАРЫН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ЧАДВАРТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, АХИЦ

Анги удирдсан багш нарын 96 хувь нь, анги удирдаагүй багш нарын 91.7 хувь нь “Тэгш хамруулах боловсрол гэж тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ердийн сургуульд хамтдаа суралцахыг хэлнэ” гэсэн зөв оюун дүгнэлтийг хийсэн нь тэдний мэдлэг ойлголт сайн байгааг харуулж байна. Суурь судалгаа I, II-ын үр дүнтэй харьцуулбал тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг ойлголттой багш нарын эзлэх хувь нэмэгдсэн байна.

Хүснэгт 23. Тэгш хамруулах боловсролын талаарх багш нарын ойлголт (анги удирдсан эсэхээр)

№	Хариулт	Суурь судалгаа I		Суурь судалгаа II		Эцсийн үнэлгээ	
		Анги удирдсан багш /139/	Анги удирдаагүй багш /22/	Анги удирдсан багш /168/	Анги удирдаагүй багш /33/	Анги удирдсан багш /174/	Анги удирдаагүй багш /36/
1	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээг тусгай сургуулиас авахыг хэлнэ	1.7	13.6	4.8	9.1	1.0	0.0
2	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуулийн тусгайлсан ангид сургахыг хэлнэ	18.6	22.7	9.5	9.1	3.0	8.3
3	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ердийн сургуульд хамтдаа суралцахыг хэлнэ	79.7	63.6	85.7	81.8	96.0	91.7
	Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаггүй дунд ангийн багш нар бүгд (100%) зөв оюун дүгнэлтийг хийсэн бол тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг дунд ангийн багш нарын 94.5 хувь нь тэгш хамруулах боловсролын талаар зөв дүгнэлтийг хийсэн нь тэгш хамруулах боловсролын чиглэлээрх мэдлэг ойлголттой багш нар нэмэгдсэнийг харуулж байна.

Хүснэгт 24. Тэгш хамруулах боловсролын талаарх дүнд ангийн багш нарын ойлголт (Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг эсэхээр)

№	Хариулт	Суурь судалгаа I		Суурь судалгаа II		Эцсийн үнэлгээ	
		Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш	Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаггүй багш	Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш	Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаггүй багш	Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш /41/	Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаггүй багш /55/
1	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээг тусгай сургуулиас авахыг хэлнэ	3.8	7.1	1.3	7.9	0.0	1.8
2	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуулийн тусгайлсан ангид сургахыг хэлнэ	15.1	25.6	7.9	13.5	0.0	5.5
3	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ердийн сургуульд хамтдаа суралцахыг хэлнэ	81.1	64.3	93.7	78.7	100.0	94.5
	Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

2022 онд хийгдсэн төслийн “Суурь судалгаа II”-ны үр дүнгээс үзвэл багш нарын 48.4 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр төлөөлүүлэн ойлгож байсан бол эцсийн үнэлгээгээр багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр хязгаарлахгүйгээр туслалцаа дэмжлэг шаардлагатай, суралцахуйн бэрхшээлтэй, бусдаас ялгаатай хүүхэд зэргээр ойлгох болж тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголтын хүрээ өөрчлөгдсөн байна. Мөн судалгаанд оролцсон багш нар анги удирдан ажилладаг эсэхээс үл хамааран тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголт ойролцоо, мэдлэг ойлголтын зөрүү бага байна.

Хүснэгт 25. Тусгай хэрэгцээтэй хүүхэд гэж хэнийг хэлэх вэ? (Суурь судалгаа II, эцсийн үнэлгээний үр дүнгээр)

№		Суурь судалгаа II		Эцсийн үнэлгээ	
		Анги удирдсан багш	Анги удирдаагүй багш	Анги удирдсан багш	Анги удирдаагүй багш
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	42.3	54.5	15.6	15.3
2	Туслалцаа дэмжлэг шаардлагатай хүүхэд	22.6	9.1	29.9	23.5
3	Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд	12.5	15.2	23.7	25.9
4	Бусдаас ялгаатай хүүхэд	11.9	6.1	13.4	15.3
5	Оюуны хомсдолтой хүүхэд	4.8	6.1	8	11.8
6	Ар гэрийн анхаарал сул, дэмжлэг хэрэгтэй хүүхэд	2.4	0.0	7.6	5.9
7	Мэдэхгүй	1.8	9.1	0.0	0.0
8	Бусад	1.8	0.0	1.8	2.4
	Нийт	100	100	100	100

Судалгаанд хамрагдсан багш нараас тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой эсэхийг тусгай хэрэгцээний төрлүүдээр тодруулан асуухад тусгай хэрэгцээний 9 төрлөөс 7 төрлийн тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой гэж багш нарын 70 дээш хувь нь хариулсан байна. Ялангуяа дунд ангийн анги удирдсан багш нарын 78-аас дээш хувь нь тусгай хэрэгцээний дурдсан бүх төрөл дээр тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой гэж хариулсан байна. Энэ үр дүнгээс багш нарын дунд тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, ялгаатай байдлын талаарх мэдлэг ойлголт сайжирч, сургах арга зүйн чадварт нь ахиц гарсан байна гэж үзэж байна.

Хүснэгт 26. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах боломжтой эсэх талаарх багш нарын санал бодол

№	Тусгай хэрэгцээний төрөл	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах боломжтой			Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах боломжгүй		
		4-5 дугаар ангийн багш	6-9 дүгээр ангийн багш	Анги удирдаагүй багш	4-5 дугаар ангийн багш	6-9 дүгээр ангийн багш	Анги удирдаагүй багш
1	Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтэй	91.1	95.9	100	8.9	4.2	0
2	Суралцахуйн бэрхшээлтэй (бичих, унших, тоо бодох)	94.9	97.9	100	5.1	2.1	0
3	Хэл ярианы бэрхшээл	91.0	96.9	86.1	9.0	3.1	13.9
4	Хөдөлгөөний бэрхшээл	92.3	96.9	91.7	7.7	3.1	8.3
5	Аутизмын хүрээний эмгэг	78.2	89.6	80.5	21.8	10.4	19.5
6	Сонсголын бэрхшээл	74.3	85.4	72.2	25.7	14.6	27.8
7	Оюун ухааны бэрхшээл	73.0	81.2	80.5	27	18.8	19.5
8	Хавсарсан бэрхшээл	67.9	79.2	69.5	32.1	19.8	30.5
9	Харааны бэрхшээл	68.0	78.2	61.1	32	21.9	38.9

Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд хамруулах, хөгжлийн бэрхшээлийн тодорхой хэлбэрүүдийг сургах боломжтой гэж багш нар үзэж байгаа ч сургуульд бэлтгэх, нийгэмшүүлэх чиглэлээр тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-д тэгш хамруулахад анхаарах, шаардлагатай байгааг багш нартай хийсэн бүлгийн ярилцлагуудад илэрхийлж байна.

... Цэцэрлэгт байхад нь шилжилтийн хөтөлбөр хэрэгжүүлээд 1-р ангийн багшид нь хүлээлгэж өгдөг бол бас зүгээр. СӨБ-д тэгш хамруулах хөтөлбөр хэрэгжүүлмээр байна. Тэрийгээ залгамж холбоотойгоор, бага ангийн багшид нь манай хүүхэд ийм онцлогтой гээд шилжүүлэн сургавал зүгээр. Олонх тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ерөөсөө цэцэрлэгт яваагүй орж ирээд байгаа. Тэгэхгүй бол дандаа нийгэмшээгүй хүүхдүүд орж ирдэг нь бага ангийн багш нарт нэлээн хүнд байгаа. Наанадаж л багш нар бие засуулах гээд хөтлөөд л явж байдаг. Тосохыг нь тосоод, нус нулимсыг нь арчаад, өмдийг нь солиод, угаагаад л. Тэгэхээр тусгай хэрэгцээтэй хүүхдийг баг, хорооны нийгмийн ажилтнууд СӨБ-д хамруулах чиглэлээр анхаармаар байна.

Багш нартай хийсэн ФБЯ-аас. Улаанбаатар хот

Судалгаанд оролцсон багш нар тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах өөрсдийн мэдлэг, үр чадвараа хэрхэн үнэлж байгааг авч үзвэл анги удирдсан багш нар тэгш хамруулах боловсрол болон тусгай хэрэгцээтэй хүүхдийн тухай ойлголтоо 100 хувь нь сайн, 71.4 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхдэд багшлах арга зүй, тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх болон багшлах

ур чадвараа сайн гэж тус тус дүгнэсэн байна. Мөн багш нарын 74.6 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхдийг илрүүлэх мэдлэг сайн, 74.8 хувь нь ГСТ-г хэрэгжүүлэх чадвар сайн гэж үнэлсэн ба тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх мэдлэг ойлголт, ажиллах үр чадвараа муу болон мэдэхгүй гэж дүгнэсэн багш нарын эзлэх хувь тун бага байна.

Хүснэгт 27. Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах өөрийн мэдлэг, үр чадвараа үнэлсэн байдал (Анги удирдсан эсэхээр)

Үзүүлэлт	Багш 6-9 анги		Анги удирдаагүй багш	
	Дундаж оноо	Хувиар	Дундаж оноо	Хувиар
Тэгш хамруулах боловсролын тухай, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн талаарх ойлголт	5.00	100.0%	5.00	100.0%
Тусгай хэрэгцээтэй хүүхдэд багшлах арга зүй	3.57	71.4%	3.5	70.0%
Тусгай хэрэгцээтэй хүүхдийг илрүүлэх	3.73	74.6%	3.44	68.8%
Тусгай хэрэгцээтэй хүүхдийн ахиц хөгжлийг үнэлэх	3.64	72.8%	3.61	72.2%
ГСТ-г боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох	3.74	74.8%	3.42	68.4%

Дээрх 5 үзүүлэлтийг тус бүрд нь 1-5 оноогоор үнэлүүлсэн.

Судалгаанд оролцсон багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдийг илрүүлэх, оношлох тал дээр зарим эцэг эхчүүдийн хандлага бэрхшээлтэй байдгийг дурдаж байсан юм. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд мэргэжлийн эмч нарын тодорхой оноштой байдаг бол хөнгөн хэлбэрийн, оюуны, суралцахуйн болон зан үйлийн зарим бэрхшээлүүдийг эцэг эхчүүд оношлуулахаас татгалзах, үл хүлээн зөвшөөрөх, цаг алдах, хүүхдэдээ хайхрамжгүй хандах, хөөцөлдөхгүй байх, хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулдаггүй зэрэг шалтгаанууд элбэг байгааг багш нар дурдаж байна.

- Бид хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж байгаа ч сайн мэддэггүй байсан. Модуль сургалтад ноднингоос хойш хамрагдсанаас хойш л мэдээлэлтэй болсон.
- Хөгжлийн бэрхшээл хүнд, хөнгөн байна. Хүнд хэлбэрийг нь бид хараад энэ ийм хүүхэд байна гээд мэдчихнэ. Хөнгөн зэргийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд хүлээн зөвшөөрөхөд хэцүү байна. Оюуны талаасаа бол бүр хэцүү, оношлуулахыг ч эцэг эхчүүд хүсэхгүй байна. Энэ нь эмзэг сэдэв нь болчихдог. Хүүхдийг нь бэрхшээлтэй гэж хэлэхэд эцэг эхчүүд маш дургүй. Хүлээж ч авахгүй, оношлуулдаггүй.
- Сахилгагүй хүүхдүүдийн ээж аав нар манай хүүхэд бол сэргэлэн л гэдэг.
- Эрүүл мэнд талаасаа л хүнд байвал хөгжлийн бэрхшээл гэж үздэг. Оюун ухаан талаасаа, сахилгагүй хүүхдүүдийг бол “зүгээр засарчихна” л гэдэг. Эсвэл шилжилтийн нас нь нөлөөлж байна гэнэ. Хөдөлгөөнтэй, сууж сураагүй хүүхдүүд маш хэцүү. Сууж сураагүй учраас багшийн зааж байгаа зүйлийг хүлээж авах чадваргүй хүүхдүүд их байна. Тэрийг хэн оношлох вэ? Ямар эмчид хандах вэ? Нарийн мэргэжлийн эмч нар нь оношлох шаардлагатай байна.

Багш нартай хийсэн ФБЯ-аас. Улаанбаатар хот

Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг дунд ангийн багш нар тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээтэй хүүхдийн тухай өөрсдийн ойлголт болон тусгай хэрэгцээтэй хүүхдэд багшлах арга зүйн мэдлэгээ тус тус 100 хувь сайн гэж үнэлж байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх чадварын хувьд 72.8 хувь нь сайн, тусгай хэрэгцээтэй хүүхдийн сургалтад ГСТ-ийг боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох мэдлэг, үр чадвараа 74.8 хувь нь сайн, тусгай хэрэгцээтэй хүүхдийг илрүүлэх үр чадвараа 74.6 хувь нь сайн гэж тус тус үнэлсэн байна.

Зураг 24. Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нарын тусгай хэрэгцээтэй хүүхдэд багшлах арга зүйгээ үнэлсэн байдал



Зорилтот сургуулийн багш нарыг тэгш хамруулах боловсролын чиглэлээрх сургалтад бүрэн хамруулсан байна. Тухайлбал анги удирдсан багш нарын 98.1 хувь нь, анги удирдаагүй багш нарын 97.2 хувь нь нь төслийн сургалтад хамрагдсан нь суурь судалгаа I, II үр дүнтэй харьцуулахад сургалтад хамрагдалт сайжирсныг харуулж байна.

Хүснэгт 28. Сүүлийн 3 жилд тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан эсэх (Анги удирдсан эсэхээр)

№	Сургалтад хамрагдсан эсэх	Суурь судалгаа I		Суурь судалгаа II		Эцсийн үнэлгээ	
		Анги удирдсан багш /139/	Анги удирдаагүй багш /22/	Анги удирдсан багш /168/	Анги удирдаагүй багш /33/	Анги удирдсан багш /174/	Анги удирдаагүй багш /36/
1	Тийм	41.1	31.8	70.2	45.5	98.1	97.2
2	Үгүй	55.9	68.2	29.8	54.5	1.9	2.8
	Нийт	100	100	100	100	100	100

Судалгаанд оролцсон тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нар бүгд (100%) сургалтад хамрагдсан бол тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаггүй багш нарын 96.7 хувь нь тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан байна.

Зураг 25. Тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан байдал (Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг эсэхээр)



Төслийн хүрээнд тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан багш нар сургалтын зорилго тодорхой, багшийн арга барил үр дүнтэй, сургалтын зохион байгуулалт сайн,

сургалтын материал хүрэлцээтэй, сургалтын агуулга практик хэрэгцээнд нийцсэн гэдэгтэй 90-ээс дээш хувьтай санал бүрэн нийлнэ гэж үр дүнг дүгнэсэн байна.

Хүснэгт 29. Тэгш хамруулах боловсролын чиглэлээр зохион байгуулагдсан сургалтын үнэлгээ (Анги удирдсан эсэхээр)

№	Сургалтын үнэлгээний шалгуур	Санал бүрэн нийлнэ		Санал нийлэхгүй	
		Анги удирдсан багш /168/	Анги удирдаагүй багш /33/	Анги удирдсан багш /168/	Анги удирдаагүй багш /33/
1	Сургалтын зорилго ойлгомжтой, тодорхой байсан	99.0	91.7	1.0	8.3
2	Сургагч багшийн арга зүй идэвхтэй, оролцоонд суурилсан, үр дүнтэй байсан	98.0	97.2	2.0	2.8
3	Сургалтын үеэр асуулт асуух, хариулт авах, хэлэлцүүлэг хийх, ярилцах боломжтой	97.9	97.3	2.1	2.7
4	Сургалтын материал хүрэлцээтэй байсан	96.8	94.5	3.2	5.5
5	Сургалтын материал нь мэдээлэл сайтай, ашиглагдахуйц байсан	95.8	94.4	4.2	5.6
6	Сургалтын агуулга практик ач холбогдолтой, хэрэгцээнд нийцсэн байсан	93.8	91.6	6.2	8.4

Зорилтот сургуулийн багш нар сургалтад хамрагдалт өндөр байгаа ба төслийн сургалтуудаас сурч эзэмшсэн мэдлэг, чадвараа тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах сургалтын үйл ажиллагаанд хэрхэн ашиглаж, ямар үр дүнг гарч байгааг авч үзвэл 1. ГСТ-г боловсруулах, хэрэгжүүлэх арга зүй 2. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах сургалтын арга зүй сайжирсан 3. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголт, хандлага өөрчлөгдсөн 4. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхтэй ажиллах үр чадвар нэмэгдсэн байна.

Хүснэгт 30. Сургалтаас эзэмшсэн мэдлэг, арга зүйгээ сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа байдал

Мэдлэг чадвар	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдлэг, үр чадвар, арга зүй
ГСТ боловсруулах, хэрэгжүүлэх арга зүй	<ul style="list-style-type: none"> - ГСТ боловсруулах, хэрэгжүүлэх арга зүйг эзэмшсэн - Хөтөлбөрийн тохируулга хийж сурсан - Шилжилтийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх
Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах сургалтын арга зүй	<ul style="list-style-type: none"> - Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, үр чадвар нэмэгдсэн - Тусгай хэрэгцээтэй хүүхдийг оношлох мэдлэг, чадвар сайжирсан - Хичээлийн бэлтгэл, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэл ажил сайжирсан - Хичээлээ хүүхдийн түвшин бүрд тохируулан төлөвлөн зааж байгаа - Сургалтын гарын авлагатай болсон - Түвшин тогтоох арга зүйд суралцсан - Сорилыг сурагчдаас авдаг болсон - Ялгавартай даалгаврын санг хичээл бүрдээ ашигладаг болсон - Сургалтын идэвхтэй аргуудыг сурсан - Дохионы хэлний арга зүйд суралцсан. Бусад багш ажилтнуудад дохионы хэлний сургалтыг явуулах хэмжээнд суралцсан - Суралцахуйн бэрхшээлтэй хүүхдийг сургах арга зүйд сурсан - Хоцрогдолтой хүүхэдтэй ажиллах арга зүйтэй болсон - 108 аргатай ном их сонирхолтой, хичээлийн төлөвлөлтөд ашиглаж байгаа - “172 санаа” ном сургалтын хэрэглэгдэхүүн дээр барьж ажилладаг

<p>Тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголт, хандлага</p>	<ul style="list-style-type: none"> - Тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаар мэдлэг, ойлголт маш их өөрчлөгдсөн - Онолын ойлголт, мэдлэг нэмэгдсэн - Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ЕБС-д суралцуулах нь зөв гэдэг талаар ойлгож авсан - Тусгай хэрэгцээтэй хүүхдээ илүү сайн ойлгож, хүүхдээ хүндлэн харилцах болсон - Хүүхэдтэйгээ илүү ойр дотно харилцах талаар сурч мэдэж, ашиглаж байна - Хүүхдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хөгжүүлэх болсон - Тусгай хэрэгцээтэй хүүхдэд анги, хамт олноороо туслах болсон - Тусгай хэрэгцээтэй хүүхдийн бэрхшээлийг даван туулахад нь туслах болсон - Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх болсон - Энэрэнгүй зан чанартай болсон - Ялгаварлан гадуурхахгүй болсон
<p>Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг, эхтэй ажиллах үр чадвар</p>	<ul style="list-style-type: none"> - Эцэг эхчүүд тусгай хэрэгцээтэй хүүхдэдээ хэрхэн хандах, харилцах талаар мэдлэг, ойлголттой болсон - Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхтэй харилцах, хамтран ажиллах аргуудаас сурсан - Эцэг эхтэй хамтын ажиллагаа сайжирсан - Эцэг эхчүүдэд арга зүйн зөвлөмж өгч байна - Эцэг эхчүүдэд зориулсан сургалт явуулсан - Эцэг эхээс судалгаа авч, боловсруулж сурсан - Эцэг эхчүүдийн тусламж авах болсон - Эцэг эхтэй ойлголцож, ярилцах болсон - Эцэг эх, бусад ажилтнуудад тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаар ойлгуулах нөлөөллийн ажил хийж эхэлсэн

Зорилтот сургуулиудад тусгай хэрэгцээтэй хүүхдийн ГСТ-г боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд сургуулийн зүгээс хяналт, үнэлгээ хийн, Дэмжлэгийн баг улиралд нэг удаа ГСТ-гөөр ажиллаж байгаа багш нарын ажилд хяналт үнэлгээ хийн тусгай хэрэгцээтэй хүүхдэд гарч буй ахицыг үндэслэн багш нарт урамшуулал олгон явж байна. Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарын ажлын ачаалал их, багшлах боловсон хүчин хүрэлцээгүй (туслах багш байхгүй) байгааг ярилцлагад оролцсон багш нар дурдаж байсан юм.

- ГСТ-р ажиллаж байгаа нийт 11 багш байгаа. Яг тэр ГСТ-ний тохируулгыг эцэг, эхчүүдтэйгээ хамтраад боловсруулаад, хэрэгжилтийг нь Дэмжлэгийн багийнхан бас үнэлгээгээ хийгээд явж байгаа.
- Сургуулийн зүгээс Дэмжлэгийн багаараа орж ирж багш нарыг ямар ахиц гарав, яав гэж шалгадаг л болохоос яг тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшийн ачааллыг багасгах, туслах тал дээр дутмаг. Ангийн багш л тэрийгээ үүрээд явдаг. Эцэг эх бас тэр болгон оролцох боломж байхгүй, чиглүүлээд багшидаа даатгаад өгчихдөг.

Багш нартай хийсэн ФБЯ-аас. Улаанбаатар хот

3.3 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДИЙГ БАГА АНГИАС ДУНД АНГИД ДЭВШИН СУРАЛЦАХАД СУРГУУЛЬ, БАГШИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХ

Зорилтот сургуулиудад тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад сургууль, багшийн зүгээс хангаж буй бэлтгэл ажлыг бага ангийн багш нараар 7 үзүүлэлтээр үнэлүүлэхэд 6 үзүүлэлтийн бэлтгэлийг 80-аас дээш хувьтай үнэлсэн байна. 4-5 дугаар ангийн анги удирдсан багш нарын 92.4 хувь нь эцэг эхтэй хамтран ажилладаг, 89.8 хувь нь ГСТ боловсруулдаг, 87.1 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхдэд хичээлийн тохируулгат хөтөлбөр боловсруулдаг, 85.9 хувь нь сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэдэг бол 83.4 хувь нь дунд ангийн багшид нь мэдээлэл

өгч захидаг, 80.7 хувь нь сурах орчин нөхцөлийг сайжруулах ажлуудыг “сайн” хийгдэж байна гэж үнэлжээ.


6-9 дүгээр ангийн анги удирдсан багш нарын 92.8 хувь нь дунд ангийн бусад багш нарт тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаар мэдээлэл өгч, захидаг, 82.3 хувь нь эцэг эхчүүдтэй хамтран ажилладаг, 81.2 хувь нь ГСТ боловсруулах болон хичээлийн тохируулгат хөтөлбөр боловсруулах бэлтгэл ажлуудыг “сайн” хэрэгждэг гэж дүгнэжээ.

Хүснэгт 31. Бага ангиас дунд ангид дэвшин суралцах тусгай хэрэгцээтэй хүүхдэд сургууль, багшийн зүгээс хангаж буй бэлтгэл /бага, дунд ангийн багшаар/

№	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах бэлтгэл	Сайн		Дунд		Муу	
		4-5 дугаар АУБ	6-9 дүгээр АУБ	4-5 дугаар АУБ	6-9 дүгээр АУБ	4-5 дугаар АУБ	6-9 дүгээр АУБ
1	Эцэг эхтэй хамтран ажилладаг	92.4	82.3	7.6	15.6	0	2.1
2	Дунд ангийн АУБ-д нь сурагчдын талаар мэдээлэл өгдөг, захидаг	83.4	92.8	15.4	7.3	1.3	0
3	ГСТ боловсруулдаг	89.8	81.2	10.3	17.7	0	1.0
4	Тусгай хэрэгцээтэй хүүхдэд тохируулгат хөтөлбөр боловсруулдаг	87.1	81.2	11.5	16.7	1.3	2.1
5	Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэдэг	85.9	72.9	14.1	24.0	0	3.1
6	Сурах орчин нөхцөлийг нь сайжруулдаг / сургалтын орчны тохируулга хийдэг/	80.7	66.7	17.9	30.2	1.4	3.1
7	Ном, сурах бичгээр хангадаг	77.0	75.0	20.5	19.8	2.5	5.2

Бага ангиас дунд анги руу дэвшин суралцахад бэлтгэн тусгай хэрэгцээтэй хүүхдэд сургууль, багш, сургуулийн ажилтнуудын зүгээс хэн нь хамгийн их сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдгийг авч үзвэл судалгаанд оролцогч бага ангийн багш нарын 88.5 хувь нь ангийн багш, 69.2 хувь нь нийгмийн ажилтан, 57.7 хувь нь сургалтын менежер, 52.6 хувь нь ангийн хүүхдүүд, 50 хувь нь сэтгэл зүйч сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж байна.

Зураг 26. Тусгай хэрэгцээтэй хүүхдэд бага ангиас дунд анги руу дэвшин суралцахад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх байдал /олон сонголттой/




Багш нар сургуулийн орчинд тусгай хэрэгцээтэй хүүхдэд ээлтэй сэтгэл зүйн орчин, тэгш хамруулах соёлыг бүрдүүлэх чиглэлээр байнгын сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах шаардлагатайг ярилцлагуудад илэрхийлж байна. Сургуулийн Дэмжлэгийн баг, ангийн багш нар, СӨУЗ-ын сурагчид зэрэг хамтын оролцоотойгоор сурагчид, эцэг эхчүүд, багш ажилтнуудын тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг тасралтгүй идэвхжүүлж байх шаардлагатай байна.

... Шинээр 1-р ангид орж ирж байгаа хүүхдүүдэд бид нар сургалтаа явуулж л байх шаардлагатай байгаа. Тэгш хамруулах чиглэлээр соёл бүрдсэн ангид шилжиж ирж байгаа хүүхдүүдэд бид нар хандлагыг нь өөрчлөх сургалтуудыг явуулахгүй бол ямар ч ойлголтгүй байдаг. Тэгэхээр бас тасралтгүй л шинээр ирсэн хүүхдэд сургалт хийх шаардлагатай байна.

Багш нартай хийсэн ФБЯ-аас. Ховд аймаг

Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд анги руу дэвшин суралцахад ангийн багшийн зүгээс сэтгэл зүйн дэмжлэгийн хэрхэн үзүүлж байгааг авч үзвэл 1. Эцэг эхэд нь зөвлөгөө өгөх (79.2), дунд ангийн багш нарт нь сурагчдын талаар захих (72.7), дасан зохицохуйтай холбоотой ажлууд зохион байгуулах (66.2), тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ярилцах (61.0), сэтгэл зүйн зөвлөгөө өгөх (57.1) хэлбэрээр ажиллаж байна.

Зураг 27. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд анги руу дэвшин суралцахад багшийн зүгээс сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх байдал /олон сонголттой/




Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад сургууль, багшийн зүгээс үзүүлэх сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг төслийн хэрэгжилтийн хугацаагаар харууллаа. Төслийн эхний жилээс сонгогдсон сургуулиудад багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдийг дунд ангийн багш нарт захих, дасан зохицохуйтай холбоотой ажлуудыг зохион байгуулах, сургалт арга зүйн зөвлөгөө өгөх чадавх илүү байгаа бол төслийн хоёр дахь жилээс сонгогдсон сургуулиудын багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх, тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ярилцах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зэрэг сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чадавх илүү сайн байна.

Хүснэгт 32. Бага ангиас дунд ангид дэвшин суралцах тусгай хэрэгцээтэй хүүхдэд сургууль багшийн зүгээс сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа /төслийн хэрэгжилтийн хугацаагаар/

№	Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төсөл хэрэгжсэн хугацаа	
		1 дэх жилд сонгогдсон сургуулиуд	2 дахь жилд сонгогдсон сургуулиуд
1	Эцэг эхэд нь зөвлөгөө өгөх	76.2	82.2
2	Дунд ангийн багш нарт нь сурагчдын талаар захих	76.2	69.2
3	Дасан зохицохуйтай холбоотой ажлууд зохион байгуулах	69.0	63.4
4	Суралцах арга зүйн зөвлөгөө өгөх	61.9	36.9
5	Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ярилцах	59.1	62.9
6	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	54.2	60.0
7	Бусад	4.8	2.9

Төслийн хэрэгжилтийн хүрээнд тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах чиглэлээр бусад ЕБС-иудын багш нартай туршлага судлах, туршлага солилцох үйл ажиллагаанд 4-5 дугаар ангийн анги удирдсан багш нарын 67.9 хувь нь , 6-9 дүгээр ангийн багш нарын 55.2 хувь нь, анги удирдаагүй багш нарын 33.3 хувь нь хамрагдсан байна.

Зураг 28. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах чиглэлээр бусад туршлага солилцсон эсэх



Тэгш хамруулах боловсролын чиглэлээр туршлага судлах, туршлага солилцох үйл ажиллагаанд оролцсон багш нарын сурч мэдэж авсан мэдлэг, туршлагыг бүлэглэн авч үзвэл 1. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн ГСТ боловсруулах, хичээлийн тохируулга хийх туршлага 2. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх 3. Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга барил 4. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхтэй хэрхэн хамтран ажиллах талаар туршлага солилцсон байна.

Хүснэгт 33. Багш нарын тэгш хамруулах боловсролын чиглэлээр туршлага солилцох үйл ажиллагаанаас судалсан мэдлэг, арга зүй

	4-5 дугаар ангийн АУБ	6-9 дүгээр ангийн АУБ	Анги удирдаагүй багш
Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах ГСТ, хичээлийн тохируулга хийх, багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - ГСТ боловсруулах арга зүй - ГСТ эцэг эхэд танилцуулж, хамтарч хийх - Тусгай хэрэгцээтэй хүүхдийн ахиц амжилтыг тооцох - Ахмад багш нараас суралцсан - Тэгш хамруулах боловсролын хууль, эрх зүйн мэдлэг, туршлага - Төсөл хэрэгжээгүй сургууль дээр очиж сургалт явуулсан 	<ul style="list-style-type: none"> - ГСТ боловсруулах арга зүй - Хөтөлбөрийн тохируулга хийх - Багш нарын хичээлд суун арга зүйгээс нь суралцсан - Судалгаа авч боловсруулах арга зүйг судалсан - Тусгай хэрэгцээтэй хүүхдийг оношлох арга зүй - Дэмжлэгийн Багийн үйл ажиллагааг судалсан 	<ul style="list-style-type: none"> - ГСТ хэрхэн хийх арга зүй - Хөтөлбөрийн тохиргоо хийх арга зүй - Ховд руу сургалтад явахад тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах, хэрэглэгдэхүүний тохиргоо хийх талаар ойлгож, сурч авсан
Тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүй	<ul style="list-style-type: none"> - Сургалт, арга зүй зөвлөгөө авсан - Бариад үсэг хийж өгөх туршлага - Хэрэглэгдэхүүнээ зөв сонгон хэрэглэх - Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, хэрхэн сайжруулж бэлдэх - Тусгай дасгалын өрөөтэй байсан - Хүүхдийг зургаар хөгжүүлэх - Авьяаст тулгуурлаж хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн олон янз байдал - Тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн, тараах материал бэлтгэх - Сургалтын хэрэглэгдэхүүний хувилбар байх - Дохионы хэлний сургалт - Ялгаатай даалгаврын сан хийх - Бүтээлч ажил хийлгэж сургах 	<ul style="list-style-type: none"> - Тэгш хамруулах сургалтын талаарх ойлголт, мэдлэг - Сургалтын хэрэглэгдэхүүний уралдаан хэрхэн зарлах - Өөрийн туршлагаа түгээн дэлгэрүүлсэн
Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүй	<ul style="list-style-type: none"> - Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах сэтгэл зүйн бэлтгэлтэй болсон - Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хэрхэн нийгэмшүүлэх - Тусгай сургуулиудаас туршлага судалсан 	<ul style="list-style-type: none"> - Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэй зөв харилцах - Бидний энгийн, санаанд оромгүй үйлдэл тусгай хэрэгцээтэй хүүхдэд эмзэг тусдаг тухай 	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах - Хөгжлийн бэрхшээлийн ангилал, онцлог - Сонсголгүй хүүхэдтэй ажиллах аргачлал
Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхтэй хамтран ажиллах	<ul style="list-style-type: none"> - Сэтгэл зүй зөвлөгөө өгөх - Эерэг уур амьсгалыг бүрдүүлэх - Багш, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг судалсан 	<ul style="list-style-type: none"> - Багш, эцэг эхийн хамтын ажиллагааны туршлага судалсан - Сургалтад эцэг эхчүүдийг татан оруулах туршлага судалсан 	<ul style="list-style-type: none"> - Эцэг эхийн хандлага хэрхэн өөрчлөгдөж байгааг судалсан - Багш, сурагч, эцэг эхийн ажлын уялдаа холбоо судалсан

Төсөлд хамрагдаагүй сургуулиудад тэгш хамруулах боловсролын чиглэлээр багш нарыг чадавхжуулах сургалтыг биечлэн болон цахим хэлбэрээр зохион байгуулж байгаа сайн туршлагыг Ховд аймгийн сургуулиудын жишээн дээр авч үзье.

- Сая амралтын хугацаанд сургууль бүрээс 5 багш, захирал, удирдлага гээд 10 хүний бүрэлдэхүүнтэй баг бусад сургуулиудад туршлага түгээн дэлгэрүүлсэн. Тэгээд судалгаат хичээлүүдийг зохион байгуулаад манай багш нарын хичээл дээр хүмүүс ирж суусан.
- Манайх дээр бусад хөдөөгийн сургуулийн багш нар, тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ангийн багш нар ирээд тогтмол зөвлөгөөн авдаг. Түгээн дэлгэрүүлэлтийг бол хийж байгаа. Хөдөө сумаас бас үрилга их авч, маш их явж байгаа.
- Сүмд байдаг тусгай хэрэгцээтэй хүүхдүүд манай сургуульд явах боломжгүй, тэгээд өөрсдөө ирээд уулзаад сургалт гарын авлага, зөвлөмж аваад явж байгаа. Бас Дуут сум дээр очсон.
- Баян өлгий аймгийн Цагааннуур сумаас манай багш нарт сургалт зөвлөгөө өгөөч гээд нэг бүтэн өдрийн сургалт орсон. Багш нар маань хэрэглэж байгаа сургалтын хэрэглэгдэхүүнүүдээ дэлгээд бүгдийг нь заасан.
- Онлайнаар арга зүйчтэйгээ нийлээд тусгай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах чиглэлээр сургалтыг хөдөөгийн бүх сургуулиудыг хамруулж хийсэн. Сургуулийн зөвхөн бага ангийн багш нар, менежерүүдийг хамруулсан.
- Манай багш нар ГСТ хийгээд, үр дүнг нь үзээд, түүн дээрээ бараг судалгааны ажил хийх туршлагатай олон багш байгаа. Тэд нар маань түгээн дэлгэрүүлээд явдаг. Харааны бэрхшээлтэй нэг хүүхэд уншаад сурчихсан байх жишээтэй. Хүүхдүүд бэрхшээлээ даван туулаад, үр дүнд хүрээд явж байгаа нь бас амжилт гэж бодож байгаа.

Сургуулийн удирдлага, менежерүүдтэй хийсэн ФБЯ-аас. Ховд аймаг

Бүлгийн дүгнэлт

Төслийн шалгуур үзүүлэлт 2-т заасан “Суурь боловсролын түвшинд тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг хүлээж авах, дунд ангид суралцах орчинд дасан зохицох үйл явцыг нь дэмжих багшийн ойлголт, мэдлэг, ур чадвар, оролцоо, сургуулийн санал санаачилга сайжирсан байна” гэсэн зорилт бүрэн хангагдсан байна. Зорилтот сургуулиудын багш нарын тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн талаарх мэдлэг ойлголт, хандлага, тэднийг илрүүлэх, ГСТ-г хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх, тэдний эцэг эхтэй хамтран ажиллах мэдлэг, ур чадварт ахиц гарч сайжирсан байна. Багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр хязгаарлалгүйгээр туслалцаа дэмжлэг шаардлагатай, суралцахуйн бэрхшээлтэй, бусдаас ялгаатай хүүхдүүд зэргээр ойлгох болж тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголтын хүрээ нь тэлж өөрчлөгдсөн байна. Багш нарын хүүхдийн тусгай хэрэгцээний төрөл, онцлог, ялгаатай байдалд тохируулан багшлах арга зүйд ахиц гарсан байгаа ба тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах мэдлэг, ур чадвараа гурван багш тутмын хоёр нь сайн гэж үнэлж байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой гэж үзэх багш нарын эзлэх хувь нэмэгдсэн байна. Зорилтот сургуулийн багш нарын тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдалт сайн байгаа ба ялангуяа тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нар бүгд сургалтад хамрагдсан байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад сургууль, багшийн зүгээс хангаж буй бэлтгэл ажлыг бага ангийн багш нар сайн ханган ажиллаж хэвшсэн байна. Бага ангийн багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдийг 5 дугаар ангиа дүүргэхэд нь дунд ангийн багштай нь холбоо тогтоон хүүхдээ хүлээлгэж өгч, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, эцэг эхэд нь зөвлөгөө өгөх, дасан зохицохуйтай холбоотой ажлуудыг зохион байгуулж байна. Мөн тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах чиглэлээр бусад сургууль, багш нараас туршлага судлах үйл ажиллагаанд 4-5 дугаар ангийн анги удирдсан гурван багш тутмын хоёр нь, 6-9 дүгээр ангийн хоёр багш тутмын нэг нь, анги удирдаагүй багш нарын гурван багш тутмын нэг нь хамрагдан туршлага солилцсон байна.

БҮЛЭГ ДӨРӨВ. ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ ДАХЬ ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХЫН ӨӨРЧЛӨЛТ, АХИЦ

Шалгуур үзүүлэлт 3. Эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсрол, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг гэрийн орчинд дэмжих талаарх ойлголтоо нэмэгдүүлсэн байна.

Энэ бүлэгт судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн нийгэм, хүн ам зүйн мэдээлэл, тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголт, тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан эцэг эхчүүд, сургалтын үр дүн, тусгай хэрэгцээтэй хүүхдийн сургалт, хөгжил дэх эцэг эхчүүдийн оролцоо, дэмжлэг үзүүлэх чадавхын талаар авч үзнэ.

4.1 ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ, ХАНДЛАГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Судалгаанд зорилтот сургуулийн 89 эцэг, асран хамгаалагч хамрагдсанаас 4-5 дугаар ангийн 52 эцэг эх, 6-9 ангийн 37 эцэг эх оролцлоо. Нийт эцэг эхчүүдийн 42.7 хувь нь төслийн эхний жилд сонгогдсон сургуулийнх бол 57.3 хувь нь төслийн хоёр дахь жилд сонгогдсон сургуулийн төлөөлөл байна. Эцэг эхчүүдийн 80.8 хувь эмэгтэй, 19.2 хувь эрэгтэй байна. Боловсролын зэргийн хувьд 4-5 дугаар ангийн ангийн эцэг эхчүүдийн 46.2 хувь нь бүрэн дунд боловсролтой, 34.6 хувь нь дээд боловсролтой байгаа бол, 6-9 дүгээр ангийн эцэг эхчүүдийн 54 хувь нь дээд, 35.1 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд эцэг эхчүүдийн 41.5 хувь нь төрийн байгууллагад, 16.8 хувь нь хувиараа бизнес эрхлэх, 13.4 хувь нь хувийн компанид ажиллаж байгаа бол 11 хувь нь ажилгүй байна.

Хүснэгт 34. Судалгаанд оролцсон эцэг эх, асран хамгаалагчдын мэдээлэл, бага, дунд ангиар

№	Үзүүлэлт	Ангилал	4-5 дугаар анги /52/		6-9 дүгээр анги анги /37/	
1	Ажилладаг сургууль / төсөл хэрэгжсэн жилээр/	1-р жил	22	100.0	16	100.0
		79-р сургууль, БЗД	3	13.6	1	6.2
		127-р сургууль, БЗД	2	9.1	2	12.5
		37-р сургууль, ЧД	3	13.6	1	6.2
		49-р сургууль, ЧД	3	13.6	1	6.2
		65-р сургууль, СХД	2	9.1	4	25
		67-р сургууль, СХД	2	9.1	3	18.7
		2-р сургууль, Өвөрхангай	2	9.1	2	12.5
		7-р сургууль, Ховд	5	22.7	2	12.5
		2-р жил	30	100.0	21	100.0
		Амгалан цогцолбор сургууль, БЗД	4	13.3	3	14.3
		30-р сургууль, БЗД	4	13.3	3	14.3

		61-р сургууль, ЧД	3	10.0	1	4.7
		39-р сургууль, ЧД	4	13.3	2	9.5
		76-р сургууль, СХД	3	10.0	5	23.8
		9-р сургууль, СХД	4	13.3	5	23.8
		1-р сургууль, Өвөрхангай	4	13.3	1	4.7
		3-р сургууль, Ховд	4	13.3	1	4.7
2	Хүйс	Эмэгтэй	42	80.8	30	81.1
		Эрэгтэй	10	19.2	30	18.9
3	Нас	21-29	2	3.8	1	2.7
		30-39	29	55.8	17	46.0
		40-49	14	26.9	12	32.0
		50-59	7	13.5	7	19.0
4	Боловсролын зэрэг	Бүрэн бус дунд	4	7.7	1	2.7
		Бүрэн дунд	24	46.2	13	35.1
		Тусгай дунд	6	11.5	3	8.1
		Дээд	18	34.6	20	54.0
5	Хөдөлмөр эрхлэлт	Төрийн байгууллага	20	38.5	17	45.9
		Хувийн компани	5	9.6	7	18.9
		Хувиараа бизнес эрхлэгч	9	17.3	6	16.2
		Төрийн бус байгууллага	1	1.9	0	0.0
		Малчин	3	5.8	0	0.0
		Ажилгүй	7	13.5	3	8.1
		Тэтгэвэрт	3	5.8	4	10.8
		Бусад	4	7.7	0	0

Судалгаанд бага ангийн 52 эцэг эх, асран хамгаалагч оролцсон ба хүүхдийн нь суралцдаг анги, насыг авч үзвэл 8-13 насны 4-5 дугаар ангийн сурагчдын 44.2 хувь нь эмэгтэй, 55.8 хувь нь эрэгтэй сурагчид байна. Сургууль завсардсан 2 сурагч байна. Сурагчдын насны үзүүлэлт болон 2023-2024 оны хичээлийн жилд суралцаж буй ангийг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 35. Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн эцэг эхчүүдийн хүүхдийн нас, суралцдаг анги

№	Үзүүлэлт	Ангилал	Тоо	Хувь
1	2023-2024 оны хичээлийн жилд суралцаж байгаа анги	4-р анги	22	42.3
		5-р анги	30	57.7
2	Тусгай хэрэгцээт хүүхдийн нас	8 нас	3	5.8
		9 нас	14	26.9
		10 нас	31	59.6
		11 нас	3	5.8
		13 нас	1	1.9


Энэ судалгаанд 6-9 дүгээр ангийн сурагчийн 37 эцэг эх, асран хамгаалагч оролцсон байна. Сурагчдын 37.8 хувь нь эмэгтэй, 62.2 хувь нь эрэгтэй сурагчид байна. Сургууль завсардсан 1 сурагч байна. Сурагчдын насны үзүүлэлт, суралцаж буй ангийг доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 36. Судалгаанд оролцсон 6-9 дүгээр ангийн эцэг эхчүүдийн хүүхдийн нас, суралцдаг анги

№	Үзүүлэлт	Ангилал	Тоо	Хувь
1	2023-2024 оны хичээлийн жилд суралцаж байгаа анги	6-р анги	10	27.0
		7-р анги	9	24.3
		8-р анги	9	24.3
		9-р анги	9	24.3
2	Тусгай хэрэгцээт хүүхдийн нас	11 нас	5	13.5
		12 нас	9	24.3
		13 нас	13	35.1
		14 нас	7	18.9
		15 нас	3	8.1

Судалгаанд оролцсон 4-5 дугаар ангийн эцэг эхчүүдийн 46.2 хувь нь, 6-9 дүгээр ангийн эцэг эхчүүдийн 59.5 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй байна.

Зураг 29. Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн хүүхдийн тусгай хэрэгцээний мэдээлэл




Судалгаанд 4-5 дугаар ангийн 24 тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй эцэг эх, 6-9 дүгээр ангийн 22 тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй эцэг эх оролцсон ба хүүхдийн тусгай хэрэгцээний төрлийг авч үзвэл хөдөлгөөний бэрхшээл (7), харааны бэрхшээл (7), оюуны бэрхшээл (6), сонсголын бэрхшээл (4), аутизмын хүрээний эмгэг (4) бэрхшээл хамгийн их байна.

Хүснэгт 37. Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн хүүхдийн тусгай хэрэгцээний төрөл

№	Тусгай хэрэгцээний төрөл	4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэд		6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй хүүхэд	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Хөдөлгөөний бэрхшээлтэй	5	20.8	2	9.1
2	Харааны бэрхшээлтэй	4	16.7	3	13.6
3	Оюун ухааны бэрхшээлтэй	4	16.7	2	9.1
4	Аутизмын хүрээний эмгэгтэй	4	16.7	0	0.0
5	Сонсголын бэрхшээлтэй	2	8.3	2	9.1
6	Хэл ярианы бэрхшээлтэй	2	8.3	1	4.5
7	Хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй	0	0.0	3	13.6
8	Дауны хам шинж	0	0.0	3	13.6
9	Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг	0	0.0	1	4.5
10	Бусад	3	12.5	5	22.9
	Нийт	24	100.0	22	100.0


Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн тусгай хэрэгцээг хөгжлийн бэрхшээлийн зэргээр авч үзвэл бага ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 41.7 хувь нь дунд зэрэг, 33.3 хувь нь хөнгөн, 25 хувь нь хүнд болон хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Дунд ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн 45.5 хувь нь дунд зэргийн хөгжлийн бэрхшээлтэй, 40,9 хувь нь хүнд болон хавсарсан, 13.6 хувь нь хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

Зураг 30. Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн бэрхшээлийн зэрэг



“Суурь судалгаа I”, “Суурь судалгаа II”-ын үр дүнгүүдтэй харьцуулбал эцэг эхчүүдийн тэгш хамруулах боловсролын талаарх зөв хариултын хувь нэмэгдсэн байгаа ба “тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ердийн сургуульд бусад хүүхдүүдтэй хамт суралцах нь зөв” гэж бага ангийн эцэг эхчүүдийн 81.8 хувь нь, дунд ангийн эцэг эхчүүдийн 87.5 хувь нь хариулсан нь тэдний мэдлэг ойлголт сайжирсныг харуулж байна.

Зураг 31. Тэгш хамруулах боловсролын талаарх эцэг эхчүүдийн ойлголт



Тэгш хамруулах боловсролын талаарх тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд хамтдаа суралцахыг хэлнэ гэсэн зөв ойлголтыг баримталж байсан бага ангийн эцэг эхчүүд “Суурь судалгаа I”-т 65.2 хувь, “Суурь судалгаа II”-т 77.1 хувь байсан бол энэ удаагийн үнэлгээнд 81.8 хувь болж өссөн байна. Дунд ангийн эцэг эхчүүдийн ойлголт “Суурь судалгаа I”-т 70.0 хувь, “Суурь судалгаа II”-т 78.4 хувь байсан бол энэ удаагийн үнэлгээнд 87.5 хувь болж өссөн байна.

Хүснэгт 38. Тэгш хамруулах боловсролын талаарх эцэг эхийн ойлголт, суурь судалгаа, эцсийн үнэлгээний үр дүнгээр

№	Хариулт	Суурь судалгаа I		Суурь судалгаа II		Эцсийн үнэлгээ	
		Бага ангийн эцэг эх /46/	Дунд ангийн эцэг эх /30/	Бага ангийн эцэг эх /48/	Дунд ангийн эцэг эх /37/	Бага ангийн эцэг эх /52/	Дунд ангийн эцэг эх /37/
1	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээг тусгай сургуулиас авахыг хэлнэ	17.4	6.7	6.3	5.4	1.8	2.5
2	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуулийн тусгайлсан ангид сургахыг хэлнэ	15.2	16.7	14.6	10.8	9.1	7.5
3	Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ердийн сургуульд хамтдаа суралцахыг хэлнэ	65.2	70.0	77.1	78.4	81.8	87.5
4	Мэдэхгүй	2.2	6.7	2.1	5.4	3.6	2.5
5	Бусад: Тусгай хэрэгцээний түвшнээс нь хамаарна	0.0	0.0	0.0	0.0	3.6	0.0
	Нийт		100.0	100.0	100.0	100.0	100.0

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдээс тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой эсэхийг тусгай хэрэгцээний төрлүүдээр тодруулан асуухад бага, дунд ангийн эцэг эхчүүд сургууль завсардсан хүүхэд болон хөдөлгөөний бэрхшээл, хэл ярианы бэрхшээл, суралцахуйн бэрхшээл, анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг зэрэгтэй тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой гэж 80-90 хувь нь хариулж байна. Эцэг эхчүүдийн 3 хүн тутмын 2 нь харааны бэрхшээл, аутизмын хүрээний эмгэг, сонсголын бэрхшээлтэй зэрэг тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой, хоёр хүн тутмын нэг нь оюуны бэрхшээл, хавсарсан бэрхшээлтэй тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой гэж үзэж байна.

Хүснэгт 39. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой эсэх

№	Тусгай хэрэгцээний төрөл	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах боломжтой		Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах боломжгүй	
		4-5 дугаар ангийн эцэг эх	6-9 дүгээр ангийн эцэг эх	4-5 дугаар ангийн эцэг эх	4-5 дугаар ангийн эцэг эх
1	Сургууль завсардсан	90.4	86.5	9.6	13.5
2	Хөдөлгөөний бэрхшээл	86.6	81.1	13.5	18.9
3	Хэл ярианы бэрхшээл	84.6	81.1	15.4	18.9
4	Суралцахуйн бэрхшээлтэй (бичих, унших, тоо бодох)	82.7	81.1	17.3	18.9
5	Анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг	82.7	70.2	17.3	29.8
6	Харааны бэрхшээл	65.4	62.2	34.6	37.8
7	Аутизмын хүрээний эмгэг	65.4	59.5	34.6	40.5
8	Сонсголын бэрхшээл	61.6	56.8	38.4	43.2
9	Оюун ухааны бэрхшээл	57.7	54.0	42.3	46.0
10	Хавсарсан бэрхшээл	51.9	46.0	48.1	54.0

Судалгаанд оролцсон 6-9 дүгээр ангийн эцэг, эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн боловсролтой холбоотой мэдлэг, ойлголт сайжирсан нь дараах үр дүнгээс харагдаж байна. Үүнд:

- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байхад олон нийтийн ойлголт хэр чухал болохыг 89.2 хувь нь мэднэ.
- Хичээл, сургалт, сургуулийн үйл ажиллагаанд эцэг, эхчүүдийн оролцооны ач холбогдлыг 86.5 хувь мэднэ.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд суралцахын ач холбогдлыг 81.1 хувь нь мэднэ.
- Хүүхэд бүрийн онцлог, хөгжлийн ялгаатай хэрэгцээний талаар 75.7 хувь нь мэднэ гэж хариулжээ.

Зураг 32. Эцэг, эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн боловсролтой холбоотой мэдлэг ойлголт



Зорилтот сургуулиудын эцэг эхчүүдийн дунд зохион байгуулсан тэгш хамруулах боловсролын чиглэлээрх сургалтад 4-5 дугаар ангийн эцэг эхчүүдийн 42.3 хувь нь, 6-9 дүгээр ангийн сурагчдын 54.1 хувь хамрагдсан байна. Сургалтад хамрагдсан 4-5 дугаар ангийн эцэг эхчүүдийн 86.4 хувь нь, 6-9 дүгээр ангийн эцэг эхчүүдийн 75 хувь нь сургалтаас эзэмшсэн тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголтоо хүүхдүүдтэйгээ хуваалцсан байна.


Зураг 33. Тэгш хамруулах боловсролын талаар сургалтаас эзэмшсэн мэдлэгээ хүүхдүүдтэйгээ хуваалцсан эсэх



Сургалтад хамрагдсан эцэг эхчүүд сургалтын үр дүнг үнэлэхдээ сургалт хэрэгцээнд нийцсэн (100%), сургалтын үеэр санал солилцох боломжтой байсан (100%) гэдэгтэй “бүрэн санал нийлж байна” гэж үзсэн. Мөн эцэг эхчүүдийн туршлагаас суралцаж (90%), хүүхдээ хэрхэн дэмжих талаар

үр дүнтэй мэдээлэл авч (85%), хэрэгцээтэй материал, гарын авлагуудаас авсан (80%) гэж эцэг эхчүүд үр дүнг эергээр үнэлжээ. Сургалтад хамрагдсан эцэг эхчүүдээс тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсанаар тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх мэдлэг, ойлголтод нь өөрчлөлт гарсан эсэхийг тодруулахад бага ангийн эцэг эхчүүдийн 63.6 хувь нь мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан, 27.3 хувь нь ойлголт хандлага өмнөхөөсөө нэмэгдсэн гэж үзжээ. Дунд ангийн эцэг эхчүүдийн 80 хувь нь мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, 20 хувь нь мэдлэг, ойлголт өмнөхөөсөө нэмэгдэж тусгай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах онцлогийн талаарх ойлголт, мэдлэг нь сайжирсан байна.

Зураг 34. Сургалтад хамрагдсан эцэг эхчүүдийн мэдлэг, ойлголтод нь өөрчлөлт гарсан эсэх



Чанарын судалгааны үр дүнгээс харахад хүүхэдтэй нь хамт суралцдаг тусгай хэрэгцээтэй хүүхдэд бусад эцэг эхчүүдийн хандах хандлага, ойлголт өөрчлөгдсөн байгаа ба бүлгийн ярилцлагад оролцсон багш, сургуулийн удирдлага, Дэмжлэгийн багийн гишүүд, сурагчидтай хийсэн ярилцлагаас энэ нь харагдаж байна.

... Эцэг эхчүүд манай ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийг их ойлгодог. Ноднин их хүнд өвдөхөд нь 2, 3 удаа эргэлт зохион байгуулж байсан. Эцэг эхийн зөвлөлөөс хандив цуглуулаад эргэж байсан. Одоо ч гэсэн бие нь ямар байна гээд асуудаг. Гэр нь өөрийн гэсэн хашаагүй учраас тодорхой хаяггүй тул манай нэг ээж сургуультай ойрхон манай хашаанд бууж болно шүү гэж хэлж байсан.

Багш нартай хийсэн ФБЯ-аас. Улаанбаатар хот

Эцэг эхчүүд тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсанаар тэдний мэдлэг ойлголт, хандлагад ямар өөрчлөлт гарсныг авч үзвэл:

1. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголт, хандлагын их өөрчлөлт гарсан.
2. Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй харилцах харилцаан дээр хэрхэн харилцах арга барилаа мэддэггүй байсан бол мэдэж авч, өмнө нь төдийлөн харилцдаггүй байсан бол харилцаж ярилцах болж, дотно найрсаг хандах, тэднийг ойлгож, хүлээн зөвшөөрөх, илүү сайн хандах, бусдад хүүхдүүдээс ялгаатай биш адил хандах зэрэг харилцаа хандлагад өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 40. Сургалтад хамрагдсанаар эцэг эхчүүдийн мэдлэг ойлголт, хандлагад гарсан өөрчлөлт

Өөрчлөлт	4-5 дугаар ангийн эцэг эх	6-9 дүгээр ангийн эцэг эх
Тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголт, хандлага өөрчлөгдсөн	<ul style="list-style-type: none"> - Тусгай хэрэгцээтэй хүүхдийн тухай өмнө нь мэдсэн зүйлээ бататгасан. - Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ялгаварлан гадуурхагдахгүйгээр хаана ч энгийн хүүхдүүдтэй хамт сургах боломжтойг ойлгосон. - Тусгай хэрэгцээтэй хүүхдээ оношлуулахын ач холбогдлын талаар ойлголттой болсон. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх ойлголттой болсон. 	<ul style="list-style-type: none"> - Ойлголт, хандлага өөрчлөгдсөн. - Өмнө нь тусгай хэрэгцээтэй хүүхдийг тусгай сургуульд л сурах ёстой гэж бодож байсан бол одоо хамтдаа сурч болдог юм байна гэж ойлгосон. - Өмнө нь хүүхдэдээ их тусгай ханддаг сэтгэхүйтэй байсан бол их өөрчлөгдсөн. Одоо хүүхдээ бусад хүүхдийн адил хардаг. - Тусгай хэрэгцээтэй хүүхдэд эцэг эх, багшийн дэмжлэг оролцоо хэрхэн нөлөөлөх талаар ойлгосон. - Бүх хүүхэд ижил чадамжтайг ойлгосон.
Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй харилцах харилцаа өөрчлөгдсөн	<ul style="list-style-type: none"> - Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй харьцах байдал өөрчлөгдсөн. - ЕБС-д сургаснаар манай хүүхэд илүү сайжирсан. - Үг, үйлдэл дээрээ анхаарах хэрэгтэйг ойлгосон. - Хүүхдийн онцлогт тохируулан харилцах болсон. - Бид нар завгүй, хүүхдээ анхаардаггүй байсан бол одоо сонирхсон чиглэлээр нь хөгжүүлэх, гэртээ цагийг хамт өнгөрүүлэхэд нь анхаарах болсон. - Өөрийн хүүхдэдээ тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаар ойлгуулж хэлдэг болсон. 	<ul style="list-style-type: none"> - Хүүхэдтэйгээ харьцах тал дээр сайжирсан. - Анхаарал халамж тавих болсон. - Хүүхдэд маань их өөрчлөлт гарч сурлагад нь ахиц гарч байна. - Хүүхдэдээ хандах үүрэг, оролцоогоо сайжруулсан. - Хүүхдээ илүү ойлгож харилцах ёстойг ойлгосон. - Давтаж хэлж ойлгуулж сурсан. - Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй энгийн, хэвийн хүүхдүүдтэй харьцаж байгаа мэт харьцахыг мэдэж авсан. - Хүүхдийг ялгаварлахгүй, аль болох эрх тэгш харилцах ёстойг ойлгосон.

... Бид эцэг эхчүүдэд сургалт хийхдээ сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хоол зүйч гээд тухайн мэргэжлийн чиглэлийн хүмүүсийг урьж мэдээлэл өгүүлдэг. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхчүүд хоорондоо уулзаж, Дэмжлэгийн багаас тусгай хэрэгцээтэй хүүхэдтэйгээ ажиллах тал дээр зөвлөгөө авдаг. Би хувь хүний зүгээс харахад ээж, аавууд маань сайхан нээлттэй, хүүхэд маань ийм байна, ингээд сургаад өгөөч гээд ирдэг болсон. Тэрнээс өмнө тусгай хэрэгцээтэй хүүхдийн ээж, аавууд чинь ичдэг, эмээдэг, бас их нүүгдмал байсан. Энэ төслийн ачаар хүүхдүүд нь тэгш хамрагдаад, уншиж чадахгүй ч гэсэн нийгэмшээд, өөртөө үйлчлээд байх болсон.

Багш нартай хийсэн ФБЯ-аас, Ховд аймаг

4.2 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮҮХДИЙН СУРАЛЦАХ ҮЙЛ ЯВЦАД ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ОРОЛЦОО, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧАДАВХ

Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн тэгш хамруулах боловсролын чиглэлээр хүүхдийнхээ сургууль, ангиас зохион байгуулсан үйл ажиллагаануудад оролцсон байдлыг авч үзвэл бага ангийн эцэг эхчүүдийн 98.1 хувь нь хүүхдийнхээ ангийн багштай хамтран ажиллаж, 92.3 хувь нь хүүхдийнхээ ангийн үйл ажиллагаанд бусад эцэг эхчүүдийн хамт оролцсон байна. Мөн гурван эцэг эх тутмын хоёр нь сургалтын орчныг сайжруулах, бусад эцэг эхчүүдтэй туршлага солилцох, тэгш хамруулах боловсролыг олон нийтэд таниулах үйл ажиллагаанд оролцсон байна.

Судалгаанд оролцсон дунд ангийн эцэг эхчүүд бүгд (100%) хүүхдийнхээ ангийн багштай холбоотой хамтран ажиллаж, 96.4 хувь нь хүүхдийнхээ ангийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, 70.3 хувь нь сургалтын орчныг сайжруулах ажилд оролцож, 70.3 хувь нь бусад эцэг эхчүүдтэй туршлага солилцсон гэж өөрсдийн оролцоог үнэлжээ.

Хүснэгт 41. Тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургууль, ангиас зохион байгуулсан үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн оролцсон байдал

№	Үйл ажиллагаа	Тийм		Үгүй		Мэдэхгүй	
		4-5 дугаар анги	6-9 дүгээр анги	4-5 дугаар анги	6-9 дүгээр анги	4-5 дугаар анги	6-9 дүгээр анги
1	Хүүхдийнхээ ангийн багштай байнга харилцаа холбоотой ажилласан	98.1	100	1.9	0.0	0.0	0.0
2	Хүүхдийнхээ ангийн үйл ажиллагаанд бусад эцэг, эхчүүдийн хамтаар оролцсон	92.3	96.4	7.7	5.4	0.0	0.0
3	Сургалтын орчныг сайжруулах ажилд оролцсон	65.4	70.3	28.8	29.7	5.8	0.0
4	Багш болон бусад эцэг, эхчүүдтэй туршлагаа солилцох сургалт, үйл ажиллагаанд оролцсон	61.5	70.3	38.5	29.7	0.0	0.0
5	Тэгш хамруулах боловсролыг эцэг эх, олон нийтэд таниулах ажлуудад оролцсон	61.5	48.6	36.5	51.4	1.9	0.0
6	Тусгай хэрэгцээтэй хүүхдийг дэмжихэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцсон	53.8	56.8	44.2	40.5	1.9	2.7
7	Сургууль дээр эцэг, эхчүүдийн оролцоонд суурилсан ажлыг санаачилж хэрэгжүүлсэн	34.6	37.8	61.5	62.2	3.8	0.0


Судалгаанд оролцсон эцэг, эхчүүд хүүхдийнхээ сурч боловсроход нь дэмжлэг үзүүлэхдээ 1.Сурч хөгжихийг нь бүрэн дэмждэг 2.Эрүүл, таатай амьдрах орчин нөхцөлөөр хангадаг 3. Шаардлагатай ном, сурах бичгийг авч өгдөг 4. Сурахад шаардлагатай ширээ, сандлаар хангах 5. Хүүхэдтэйгээ чөлөөт цагаараа ярилцаж цагийг хамт өнгөрөөх 6. Хүүхдийнхээ даалгаврыг хийхэд нь тусалж оролцох зэрэг дэмжлэгүүдийг бага, дунд ангийн эцэг эхчүүд үзүүлж байна.

Хүснэгт 42. Эцэг эхийн зүгээс тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн сурч боловсроход бэлтгэл ханган дэмжлэг үзүүлэх байдал

№	Үйл ажиллагаа	4-5 дугаар анги		6-9 дүгээр анги	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1	Хүүхдээ сурч хөгжихийг нь бүрэн дэмждэг	100	0.0	100	0.0
2	Хүүхдээ эрүүл, таатай амьдрах орчин нөхцөлөөр хангадаг	100	0.0	100	0.0
3	Шаардлагатай ном, сурах бичгийг авч өгдөг	100	0.0	100	0.0
4	Сурч хөгжихөд дэмжлэг болох ширээ, сандлаар хангадаг	100	0.0	100	0.0
5	Чөлөөт цагаараа ярилцаж, цагийг хамт өнгөрүүлдэг	100	0.0	100	0.0
6	Хүүхдээ даалгавраа хийхэд нь тусалдаг	97.1	1.9	98.1	1.9
7	Сургуульд нь хүргэж өгдөг	69.2	7.7	56.8	13.5

Төсөл хэрэгжсэнээр тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эх, гэр бүл, асран хамгаалагчид руу чиглэсэн олон сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Энэ үйл ажиллагааны үр дүнд тусгай хэрэгцээтэй хүүхдийн сурч хөгжихөд эцэг, эхчүүдийн анхаарал, тэдний оролцоо дэмжлэг ямар түвшинд хэрхэн өөрчлөгдсөнийг бага, дунд ангийн багш нарын үнэлснээр авч үзье. 4-5 дугаар ангийн анги удирдсан багш нарын 33.3 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхчүүд маш их өөрчлөгдсөн, 47.7 хувь нь ер нь өөрчлөгдсөн гэж үзэж байна. Дунд ангийн анги удирдсан багш нарын 16.7 хувь нь тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхчүүд маш их өөрчлөгдсөн, 64.6 хувь нь ер нь өөрчлөгдсөн гэж дүгнэжээ. Эдгээр эерэг өөрчлөлтүүдийг нэгтгэн үзвэл бага ангийн эцэг эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх чадавх 80.7 хувь (маш их өөрчлөгдсөн, ер нь өөрчлөгдсөн), дунд ангийн эцэг эхчүүдийн дэмжлэг үзүүлэх чадавх 81.3 хувьтай сайжирч (маш их өөрчлөгдсөн, ер нь өөрчлөгдсөн) өөрчлөгдсөн байна.

Зураг 35. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн сурч, хөгжихөд эцэг, эхчүүд оролцоо, дэмжлэг өөрчлөгдсөн эсэх



Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сурч, хөгжихөд нь гэр бүл, эцэг эхчүүдийн зүгээс дэмжлэг үзүүлэх чадварт гарсан өөрчлөлтүүдийг авч үзвэл 1. Багш эцэг, эхчүүдийн хамтын ажиллагаа сайжирсан 2. Эцэг эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдэдээ тавих анхаарал нэмэгдсэн, 3. Эцэг, эхчүүдийн сэтгэл зүй, хандлага өөрчлөгдсөн, 4. Эцэг эхчүүдийн хүүхдээ хөгжүүлэх хүсэл эрмэлзэл нэмэгдсэн зэрэг тодорхой өөрчлөлтүүд гарсан байна. Эдгээр чиглэлүүдээр ямар бодит ахиц өөрчлөлтүүд гарч байгааг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 43. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сурч, хөгжихөд эцэг, эхчүүдийн дэмжлэг үзүүлэх чадварт гарсан өөрчлөлт, АУБ нарын дүгнэснээр

	4-5 дугаар ангийн эцэг эхчүүдэд гарсан өөрчлөлт	6-9 дүгээр ангийн эцэг эхчүүдэд гарсан өөрчлөлт
Багш, эцэг эхчүүдийн хамтын ажиллагаа сайжирсан.	<ul style="list-style-type: none"> - Багш, эцэг эхчүүд хамтарч, уялдаа холбоо сайжирсан - Багш нарыг ойлгож туслалцаа үзүүлэх болсон - ГСТ-г эцэг эхэд танилцуулж, хамтран ахиц амжилтыг тооцдог болсон - Сэтгэл зүй зөвлөгөө авдаг болсон - Сургалт, арга зүйн зөвлөгөө авдаг болсон 	<ul style="list-style-type: none"> - Эцэг эхчүүд ойлгодог болсон - Багш нартай хамтын ажиллагаа сайжирсан - Хичээлд суун гарч байгаа үр дүнгийн талаар ярилцдаг болсон - Олон багштай харьцах арга барилд дэвшил гарсан - Хүүхдүүдэд сургахад ахиц дэвшил гарсан
Эцэг эхчүүд тусгай хэрэгцээтэй хүүхдэдээ тавих анхаарал дэмжлэг нэмэгдсэн	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн хичээлд анхаардаг болсон - Шилжилт хөдөлгөөн дээр анхаардаг болсон - Хүүхэдтэйгээ ярилцдаг, их сонсдог болсон - Хүүхэдтэйгээ илүү тулж ажиллах болсон - Ахуйн хэрэглээнд нь анхаарах болсон - Ариун цэврийн тал дээр туслах болсон - Бие даалгах чадвар сайжирсан 	<ul style="list-style-type: none"> - Хүүхдэдээ тавих анхаарал, хараа хяналт сайжирсан - Хүүхдээ дэмжиж тусалдаг болсон - Хүүхэдтэй харилцах чадвар сайжирсан - Хүүхдээ оношлуулдаг болсон - Бие даалгах, өөрөөр нь хийлгэх болсон - Тусгай хэрэгцээтэй хүүхэд нийгэмших болсон
Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхчүүдийн сэтгэл зүй, хандлага өөрчлөгдсөн	<ul style="list-style-type: none"> - Эцэг эхчүүдийн сэтгэл зүйд их өөрчлөлт гарсан - Хүүхдээ цаашид сурах юм байна гэж урамшин их итгэлтэй болсон - Хүүхдээсээ ичихгүй, нуухгүй болсон - Хүүхдээ бусад хүүхэдтэй харьцуулахгүй болсон - Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ойлгож, эергээр хүлээж авдаг болсон - Өөрсдөө хамт суралцах болсон 	<ul style="list-style-type: none"> - Эцэг эхчүүдийн хандлага өөрчлөгдсөн - Багш, сургуулийн үйл ажиллагааг ойлгож хамтран ажиллах нь нэмэгдсэн - Олон нийтийн ажилд идэвхтэй оролцох болсон - Ангийн дадал хэвшлийг гэртээ хамтарч мөрдөх болсон

<p>Эцэг эхчүүдийн хүүхдээ хөгжүүлэх эрмэлзэл нэмэгдсэн</p>	<ul style="list-style-type: none"> - Хүүхдээ сонирхлынх нь дагуу сургалтуудад хамруулдаг болсон - Дунд ангиас нь тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургуулиас гаргаж авах нь багасаж, дунд анги руу нь оруулах болсон - Хүүхдээ хөгжүүлэх аргыг хайх болсон 	<ul style="list-style-type: none"> - Анги хамт олны дунд, ангийн хүүхдүүдтэйгээ дасан зохицох болсон - Өдөр бүр багш, найзуудаас нь зөвлөгөө авдаг - Анги хамт олон, найз нөхөдтэй нь нийгэмшүүлэх сонирхолтой болсон - Хүүхдээ сургуулийн үйл ажиллагаанд хамруулах сонирхолтой болсон.
--	--	--

- Тусгай хэрэгцээтэй хүүхэд жирийн хүүхдүүдтэй хамт байвал нийгэмших нь арай илүү байх. Өөрийгөө хөгжүүлэх, бусад хүүхдүүд чадаж байгаа юм чинь би бас чадна гэж бодох байх. Нэг их ялгараад байхгүйгээр харилцаад байдаг.
- Эхэндээ бол цэцэрлэгт яваагүй болохоор нийгэмшихгүй, манай хүүхэд зүгээр суугаад л байдаг байсан. Одоо бол бараг жирийн хүүхдүүдээсээ илүү босож гүйгээд, сахилгагүйтээд ангидаа чөлөөтэй байдаг. Ямар ч байсан нийгэмшиж байгаад нь би маш их баярлаж байгаа.
- Хуучин бол ялгаад байдаг байсан, одоо ингээд нийлүүлчихээр жирийн хүүхдүүд нь хүртэл энэ чинь бид нартай адилхан сурч боловсрох эрхтэй хүн юм байна гэдгийг мэдээд, бие биеэ арай өөр өнцгөөр хардаг болж, ерөөсөө бүгдийг нь л адилхан хүн гэж харах, тэр хүмүүс ч гэсэн сурах эрхтэй, нийгмээс гадуурхах ёсгүй гэдгийг ойлгох болсон.

Эцэг эхчүүдтэй хийсэн ФБЯ-аас. Өвөрхангай аймаг

Бүлгийн дүгнэлт

Төслийн шалгуур үзүүлэлт 3-т заасан “Эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсрол, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг гэрийн орчинд дэмжих талаарх ойлголтоо нэмэгдүүлсэн байна” гэсэн зорилтын үр дүн 80 хувь хангагдсан байна. Бага ангийн эцэг, эхчүүд (81.8 хувь) болон дунд ангийн эцэг, эхчүүдийн дийлэнх олонхын (87.5 хувь) тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголт сайжирсан байна. Дунд ангийн эцэг, эхчүүдийн дийлэнх нь тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой гэж үзэж байна. Тэгш хамруулах боловсролын чиглэлээрх сургалтад бага, дунд ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн хоёр хүн тутмын нэг нь хамрагдсан байна. Сургалтад хамрагдсан бага ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн дийлэнх олонх нь (86.4 хувь), 6-9 дүгээр ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн ихэнх нь (75 хувь) нь хүүхдүүдтэйгээ тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголтоо хуваалцсан байна. Эцэг, эхчүүдийн тэгш хамруулах боловсролын чиглэлээр хүүхдийнхээ сургууль, ангиас зохион байгуулсан үйл ажиллагаануудад оролцохдоо гурван эцэг эх тутмын хоёр нь сургалтын орчныг сайжруулах, бусад эцэг, эхчүүдтэй туршлага солилцох, тэгш хамруулах боловсролыг олон нийтэд таниулах үйл ажиллагаанд оролцсон байна. Сургуулиас зохион байгуулсан үйл ажиллагаанд эцэг эхчүүд идэвхтэй оролцож байгаа ч өөрсдийн зүгээс санаачилга өрнүүлэн оролцоонд суурилсан үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь бага байна. Анги удирдсан багш нар бага, дунд ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн зүгээс тусгай хэрэгцээтэй хүүхдийн сурч хөгжихөд дэмжлэг үзүүлэх чадавх сайжирч, өөрчлөгдсөн гэж үнэлж байна. Эцэг эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдэдээ дэмжлэг үзүүлэх чадавх сайжирч, багш нартай хамтран ажиллах нь нэмэгдэн, тусгай хэрэгцээтэй хүүхдэдээ тавих анхаарал, хараа хяналт сайжирч, хүүхдийнхээ сурч хөгжихөд итгэх итгэл нэмэгдэн, хүүхдээ хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй болсон байна. Мөн эцэг эхчүүд тусгай хэрэгцээтэй хүүхдүүдээ сургуулиас гаргах нь багасаж, дунд анги руу нь дэвшүүлэн сургах хандлага нэмэгдсэн байна. Эцэг, эхчүүдийн зарим хэсэг нь хүүхдийнхээ сурах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангахад илүүтэй анхаарч, харин хүүхдүүдтэйгээ ярилцах, даалгавар хийхэд нь туслах зэрэг харилцах, хамт байх тал дээр сул оролцоотой байна. Мөн зарим эцэг эхчүүд оюуны бэрхшээл, суралцахуйн болон зан үйлийн зарим бэрхшээлүүдийг оношлуулахаас татгалзах, хүлээн зөвшөөрөхгүй байх зэрэг тусгай хэрэгцээтэй хүүхдийг илрүүлэх, оношлох тал дээр идэвхгүй хандлагатай байна.

БҮЛЭГ ТАВ. ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТ

Шалгуур үзүүлэлт 4. Суурь боловсролын түвшинд тэгш хамруулах боловсролыг дэмжих бодлого, журмыг боловсронгуй болгох, тэгш хамруулах боловсролын тогтолцоог бүрдүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

5.1 ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ БОДЛОГО, ЖУРАМ

Монгол Улсын Үндсэн хуульд “Иргэн бүр сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно”; Боловсролын тухай хуульд “Монгол Улсын иргэн суурь боловсролыг заавал эзэмших үүрэгтэй”; мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд “Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт бүх шатны боловсролд сурч боловсрох эрхтэй...” гэж заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд суурь боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран суралцах эрхийг баталгаажуулсан хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн цөөнгүй журмууд батлагдан гарсан.

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан боловсролын ерөнхий хууль болон “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль”-д тэгш хамруулах боловсролын тухай 9 заалт бүхий бие даасан бүлэг, зүйл (6 дугаар зүйл) шинээр орсон нь цэцэрлэг, ЕБС-д хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан боловсрол эзэмших суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна. ЕБС нь хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан хүүхдэд боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээх бөгөөд суралцагчид хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх, ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчныг тохижуулах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, сургалт зохион байгуулах зэрэг тэгш хамруулах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх олон үйл ажиллагаа хууль эрх зүйн шинэ орчны хүрээнд бүрдсэн. Эдгээр нь төслийн хүрээнд хийгдсэн бодлого нөлөөллийн ажлууд, уулзалт, форумын хүрээнд хэлэлцүүлсэн саналууд, баримт бичгийн төслүүд дээр ажилласны үр дүн бөгөөд одоо мөрдөж буй хууль, журмыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмрээ оруулсан байна.

2019 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулан сургах журам” нь тусгай сургуулиас бусад хэв шинжийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах харилцааг зохицуулж байна. Хамран сургах тойргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд хамруулах, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, багшийн арга зүйг хөгжүүлэх, бүх шатны боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулан хэрэгжүүлнэ гэсэн байна.

Мөн 2020 онд БШУС-ын сайдын А/184 дугаар тушаалаар “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам”-ыг баталсан. Үүнээс гадна 2021 онд ХНХ-ын сайд, БШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан А/220, А/475, А/812 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал”-ыг баталж, хөгжлийн хоцрогдол болон бэрхшээлтэй

хүүхдүүдэд үзүүлэх дэмжлэгийн салбар дундын зохицуулалтыг тодорхойлжээ. Үүнээс гадна БШУ-ны сайдын 2022 оны 12 сарын 21 өдрийн А/553 тушаалаар “Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэл”-ийг баталсан ба энэ боловсролын үйлчилгээнээс орхигдоод байгаа бүлгийн суралцагчдад суралцах, хөгжихөд тулгарч буй саад, бэрхшээлийг арилгах замаар тэдний сурч боловсрох эрхийг хангахад чиглэсэн байна.

“Батлагдсан бодлогын баримт бичгүүдээс харвал эрх зүйн баримт бичгүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэгдсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь тусгай хэрэгцээт хүүхдийн нэг зорилтот бүлэг бөгөөд гарцаагүй дэмжлэг шаардлагатай хүүхэд юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс гадна боловсролын тусгай хэрэгцээт хүүхдийн нэгдсэн мэдээлэл, илрүүлэг, оношилгоо, дэмжлэг үзүүлэх тогтолцоо тодорхойгүй байсаар байна” гэсэн дүгнэлт нь одоо ч хэвээр байна.

Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ГСТ, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлэх бөгөөд шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн болон үнэлгээний байгууллага хамтран боловсруулахаар БШУ-ны сайдын 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/325 дугаар тушаалаар “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй суралцагчийг үнэлэхэд баримтлах чиглэл”-д заажээ. Энэ чиглэлийг батлуулахад ХИС голлон оролцсон байна. Энэ нь ГСТ-өөр хичээллэж буй ердийн сургуулийн сурагчийн үнэлгээг уян хатан болгох, явцын ахиц амжилтыг дэмжих, үр дүнгийн үнэлгээг явцын үнэлгээгээр тооцож байх зэрэг суурь судалгаанд оролцсон багш нарын хүсэлтүүдийг бодит ажил хэрэг болгосон ач холбогдолтой баримт бичиг болжээ.

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн Үндэсний статистикийн хороо болон БШУЯ тусгай хэрэгцээт хүүхдийг бүртгэх шинэчилсэн ангиллын системээ нэгтгэсэн байна. Тус систем дээр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа болон боловсролын гадна үлдсэн хүүхэд гэх мэтээр бүртгэх зэргээр маягт, заавраа шинэчилжээ. Мэдээллийн системийг шинэчлэхэд мөн ХИС-ийн энэхүү төсөл чухал хувь нэмэр оруулсан байна. Статистик мэдээллийг шинэчилснээр хүүхдийн тусгай хэрэгцээний хэлбэр, цуглуулах мэдээллийг өргөжүүлж, ГСТ-өөр хичээллэдэг хүүхдийн тоог гаргах боломжтой болжээ. Мөн Боловсролын удирдлагын мэдээллийн системд ердийн бага ангийн багшид ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдийг илрүүлэхэд туслах асуулга, сорил боловсруулж оруулж өгснөөр тусгай хэрэгцээт хүүхдэд тохируулан ГСТ, хөтөлбөр, арга зүйгээ боловсруулахад дутагдаж буй мэдээллийг цуглуулахад дэмжлэг болсон байна.

Дээрхээс харахад боловсролын салбарт хамаарах эрх зүйн баримт бичгүүдэд тусгай хэрэгцээтэй хүүхдийн асуудал бодитой тусгагджээ. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эрт илрүүлэг, оношилгоо, дэмжлэг үзүүлэх тогтолцооны чиглэлээр ХНХЯ, ЭМЯ идэвхтэй ажиллаж байна. Тусгай хэрэгцээт хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгүүдийг нэгтгэсэн 2 тайлан гарсан. (БШУЯ, Жайка “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл” 2022, БШУЯ, Азийн Хөгжлийн Банк (АХБ) “Тэгш хамран сургах боловсрол” бодлогын хураангуй, 2023)

Тэгш хамруулах боловсролын чиглэлээр батлагдсан дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх эхлэл тавигдсан байна. Яам, хэрэгжүүлэгч агентлагийн хувьд тэгш хамруулах боловсролын баримт бичгүүдэд дотоодын хяналт, мониторингийн түвшинд үнэлгээ хийж байна. Олон улсын болон иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс гаргасан санал хүсэлтэд үндэслэн БШУЯ хяналт, үнэлгээ хийхээр төлөвлөсөн байна. АХБ-ны төслийн хүрээнд мөн энэ чиглэлд үнэлгээ хийгдсэн байна. 2018-2023 онд БШУ-ны сайдын тушаалаар зөвхөн боловсролын байгууллагуудад хэрэгжүүлэх 14 журам, чиглэл батлагджээ. Цаашид эдгээр журмууд дээр хяналт, мониторинг хийх тал дээр БШУЯ идэвхтэй ажиллах шаардлагатай байна.

Шалгуур үзүүлэлтийн түвшинд авч үзвэл суурь боловсролын түвшинд тэгш хамруулах боловсролыг дэмжих бодлого, журмыг боловсронгуй болгох, тэгш хамруулах боловсролыг төрийн бодлогод тусгах чиглэлээр ХИС хангалттай сайн ажиллажээ.

5.2 ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО БҮРДСЭН БАЙДАЛ

Зорилтот сургуулиудад тусгай хэрэгцээт хүүхдийг тэгш хамруулах сургалтын тогтолцоо ямар түвшинд бүрдсэнийг бага, дунд ангийн багш нарын хариултаас авч үзвэл (1) тусгай хэрэгцээт хүүхдийг сургах сургуулийн бодлого төлөвлөгөө, (2) тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах сургуулийн багш, ажилтнуудын харилцааны чадвар, (3) тусгай хэрэгцээт хүүхдийг хүлээн авах сургуулийн сонирхол хангалттай гэж тус бүрд нь 93 хувиас дээш хувь үнэлж байна. Мөн (4) тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багш нарыг дэмжих тогтолцоо, (5) тусгай хэрэгцээт хүүхдийн талаарх сурагчид болон эцэг эхчүүдийн ойлголт хангалттай гэж 84 хувиас дээш хувиар дүгнэсэн байна.

Хүснэгт 44. Тусгай хэрэгцээт хүүхдийг тэгш хамруулан сургах сургалтын тогтолцоо бүрдсэн байдлын үнэлгээ

№	ТХХ-ийг сургах үйл ажиллагаа	4-5 дугаар ангийн багш /78/		6-9 дүгээр ангийн багш /96/		Анги удирдаагүй багш /36/	
		Хангалттай	Хангалтгүй	Хангалттай	Хангалтгүй	Хангалттай	Хангалтгүй
1	ТХХ-ийг сургах сургуулийн бодлого, төлөвлөгөө	96.2	3.9	95.8	4.2	94.4	5.6
2	ТХХ-тэй ажиллах багш, ажилтнуудын харилцаа, хандлага	94.9	5.1	96.9	3.1	88.8	11.1
3	ТХХ-ийг сургуульд хүлээн авах удирдлага, ажилтнуудын сонирхол, хандлага	93.6	6.4	98.0	2.0	94.4	5.6
4	ТХХ-тэй ажиллаж буй багш нарыг дэмжих тогтолцоо	87.1	12.9	89.6	10.4	77.7	22.2
5	ТХХ-ийн талаарх сурагчдын болон эцэг эхийн ойлголт	87.2	12.8	84.4	15.6	69.5	30.5
6	ТХХ-ийг сургах сургалтын материал, тохирох хэрэглэгдэхүүн	79.5	20.5	71.9	28.1	72.2	27.8
7	ТХХ-ийн талаар олон нийтийн ойлголт	77.0	23.0	55.2	44.8	41.7	58.3
8	ТХХ-дэд ээлтэй сургуулийн дэд бүтэц	69.2	21.8	76.0	24.0	77.8	22.2

Тусгай хэрэгцээт хүүхдийг сургах сургуулийн бодлого, багш нарын харилцаа, хандлага, сургуульд сургах сонирхол, багш нарыг дэмжих тогтолцоо, сурагч, эцэг эхийн ойлголт зэргийг суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад багш нар сайжирсан гэж үнэлж байна. Багш нарын 70-аас дээш хувь дээрх тэгш хамруулан сургах сургалтын тогтолцооны үзүүлэлтүүдийг хангалттай гэж хариулсан юм. Харин тусгай хэрэгцээт хүүхдийн талаарх олон нийтийн ойлголтыг хангалтгүй байна гэж дунд ангийн багш нарын 44.8 хувь нь, анги удирдаагүй багш нарын 58.3 хувь нь үзэж байна.

... 2023 онд Боловсролын багц хуульд тэгш хамруулах боловсролын талаар бүхэл бүтэн том бүлэг орууллаа. Энэ хууль дотор тусгай сургууль болон тусгай гэсэн үг байхгүй болсон. Тийм болохоор сургуулийн удирдлагууд, багш нар бүгдээрээ тусгай хэрэгцээт хүүхдүүдийг авч сургах ёстой гэдэг хандлага маш сайжирсан. Одоо ганцхан тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажиллах арга зүйгээ олохгүй байгаа, бодлого боловсруулагч, сургуулийн удирдлагууд тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт зөрүүтэй байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

Эксперттэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас, БШУЯ-ны төлөөлөл

Төсөл хэрэгжсэнээр зорилтот сургуулиудад тусгай хэрэгцээт хүүхдийг боловсролд тэгш хамруулах үйл ажиллагаанд гарсан үр дүнг багш нар хэрхэн дүгнэж байгааг авч үзвэл 1. Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багш нарын мэдлэг, ур чадвар, хандлага өөрчлөгдсөн. 2. Тусгай хэрэгцээт хүүхдийн суралцах боломж нөхцөл нэмэгдсэн 3. Сургалтын орчин сайжирсан 4. Багш, эцэг эхийн хамтын ажиллагаа сайжирсан гэж үзжээ.

Хүснэгт 45. Төсөл хэрэгжсэнээр зорилтот сургуулиудад тусгай хэрэгцээт хүүхдийг сургах үйл ажиллагаанд гарсан үр дүн

Үр дүнгийн чиглэл	Багш нарын дүгнэлт
Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багшийн мэдлэг, ур чадвар, хандлага өөрчлөгдсөн	<ul style="list-style-type: none"> - ГСТ боловсруулах, хэрэгжүүлэх чадвартай болсон - Багш нар хөтөлбөртөө тохиргоо хийх арга зүйг сурч, хөтөлбөр, төлөвлөлт, бэлтгэл сайжирсан - Багш нарын тусгай хэрэгцээт хүүхдийн талаар ойлголт, мэдлэг, ур чадвар, хандлага сайжирсан - Тусгай хэрэгцээт хүүхдэд заах арга зүй, арга барил сайжирч өөрчлөгдсөн - Сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан - Тусгай хэрэгцээт хүүхдийг оношилж сурсан - Судалгаанд суурилж хичээл орох болсон - Багш нарыг сургалтуудад маш сайн хамруулсан - Байгууллагын хэмжээнд болон багш нарт тэгш хамруулах соёл тогтсон - Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах багш нарын тоо болон идэвх нэмэгдсэн - Тулгарч байгаа асуудлыг зөв өнцгөөс хардаг болсон - Дэмжлэгийн баг байгуулагдан үр дүнтэй ажилладаг болсон - Багш нар сурагчдаа ойлгон хүндэлж, харилцаа холбоо ойртсон
Тусгай хэрэгцээт хүүхэд суралцах боломж, нөхцөл нэмэгдсэн	<ul style="list-style-type: none"> - ГСТ-өөр ажилласнаар тусгай хэрэгцээт хүүхдэд ахиц, өөрчлөлт гарсан - Тусгай хэрэгцээт хүүхдүүд бусад хүүхдүүдтэй хамт суралцах боломжийг нээн өгсөн - Тусгай хэрэгцээт хүүхдийн хэрэгцээнд нийцсэн сургалт орох болсон - Тусгай хэрэгцээт хүүхдүүд энгийн ангид олноор суралцах болсон - Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулж чадсан - Тусгай хэрэгцээт хүүхдүүд суралцахад хялбар болсон - Тусгай хэрэгцээт хүүхдүүд нээлттэй, өөртөө итгэлтэй болсон - Хүүхдүүд тусгай хэрэгцээт хүүхдүүдэд тусалж, найзалж, хүлээн зөвшөөрч эхэлсэн - Тусгай хэрэгцээт хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй, хүндэтгэх болсон - Хүүхдүүдийн хандлага өөрчлөгдөж, ижил тэгш харилцдаг болсон - СӨУЗ-ийн хүүхдүүд бусад хүүхдүүдэд сургалт орсон
Сургалтын орчин сайжирсан	<ul style="list-style-type: none"> - Сургалтын орчинд тохиргоо сайн хийгдсэн тул тусгай хэрэгцээт хүүхдийг сургах орчин сайн бүрдсэн - Тусгай танхимд хичээллэснээр сурагчийн мэдлэг, чадварт ахиц гарсан - Тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан анги танхимыг бий болгож тохижуулсан - Тусгай хэрэгцээт хүүхдийн дасгал хөдөлгөөн хийх амрах өрөөтэй болсон - Хүүхэд хөгжлийн төв байгуулагдсан - Ангид зориулалтын сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах болсон - Сургалтын өрөөтэй болсон - Тусгай 00-той болсон - Тусгай хэрэгцээт хүүхэд сурдаг ангиудыг нэг давхарт хичээллэдэг болгосон
Багш, эцэг эхийн хамтын ажиллагаа сайжирсан	<ul style="list-style-type: none"> - Эцэг эх, багш нарын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сайжирсан - Эцэг эхийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн - Багш, хүүхэд, эцэг эхчүүд нэгдэж чадсан - Эцэг эхийн хандлага өөрчлөгдсөн - Эцэг эхчүүдийн оролцоо, идэвх нэмэгдсэн - Эцэг эхчүүд сургуультай ойр болсон

Зорилтот сургуулийн барилга, байгууламж, сургалтын орчинд тусгай хэрэгцээт хүүхдийн хэрэгцээнд нийцсэн тохируулга хэр хийгдсэнийг багш нарын хариултаар дүгнэж үзвэл налуу зам,


шатны бариул, угаалтуур зэрэг нь сайн хийгдсэн байгаа бол 00 суултуур, ханын бариул хангалтгүй байдаг байна.

Хүснэгт 46. Зорилтот сургуулиудын сургалтын орчны тохируулга хийгдсэн байдал, багш нарын үнэлгээгээр

№	Хүртээмжтэй байдал	Сайн			Дунд			Муу		
		4-5 дугаар АУБ	6-9 дүгээр АУБ	АУ-гүй багш	4-5 дугаар АУБ	6-9 дүгээр АУБ	АУ-гүй багш	4-5 дугаар АУБ	6-9 дүгээр АУБ	АУ-гүй багш
1	Налуу зам	67.9	63.5	52.8	21.8	30.2	30.6	10.3	6.3	16.7
2	Шатны бариул	65.4	65.6	55.6	25.6	25.0	27.8	9.0	9.4	16.7
3	Угаалтуур	57.7	53.1	47.2	28.3	30.2	44.4	14.1	16.7	8.3
4	Үүдний бариул	56.4	63.5	55.6	35.9	30.2	27.8	7.7	6.3	16.7
5	00 тасалгаа	55.1	62.5	58.3	28.2	21.9	30.6	16.7	15.6	11.1
6	00 суултуур	52.6	57.3	52.8	28.2	29.2	33.3	19.2	13.5	13.9
7	Ханын бариул	43.6	46.9	36.1	26.9	26.0	36.1	29.5	27.1	27.8

Төслийн хүрээнд зорилтот сургуулиудад байгуулагдсан Хүүхэд хөгжлийн төвийг тусгай хэрэгцээт хүүхдийг сургах, хөгжүүлэх чиглэлээр хэрхэн ашиглаж байгааг авч үзвэл тусгай хэрэгцээт хүүхэдтэй 4-5 дугаар анги удирдсан багш нарын 90.2 хувь нь, тусгай хэрэгцээт хүүхэдтэй 6-9 дүгээр анги удирдсан багш нарын 81.8 хувь нь үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Зураг 36. Хүүхэд хөгжлийн төвд сургалтын үйл ажиллагаа явуулдаг эсэх, тусгай хэрэгцээт хүүхэдтэй бага, дунд анги удирдсан багшаар



Хүснэгт 47. Хүүхэд хөгжлийн төвөөр үйлчлүүлдэг давтамж, бага, дунд ангийн тусгай хэрэгцээт хүүхдийн хариултаар

№	Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагаа	Байнга		Заримдаа		Үгүй		Мэдэхгүй	
		4-5 дугаар ангийн ТХХ /30/	6-9 дүгээр ангийн ТХХ /39/	4-5 дугаар ангийн ТХХ /30/	6-9 дүгээр ангийн ТХХ /39/	4-5 дугаар ангийн ТХХ /30/	6-9 дүгээр ангийн ТХХ /39/	4-5 дугаар ангийн ТХХ /30/	6-9 дүгээр ангийн ТХХ /39/
1	Ганцаарчилсан хичээл орох	33.3	28.2	20.0	25.6	40.0	41.0	6.7	5.1
2	Багш, сэтгэл зүйчтэй ярилцах, зөвлөгөө авах	20.0	20.5	26.7	38.5	50.0	35.9	3.3	5.1
3	Тоглонгоо хөгжих хөтөлбөрт хамрагдах	20.0	12.8	16.7	25.6	63.3	56.4	0.0	5.1

4	Хичээлийн хоцрогдол нөхөх	16.7	20.5	20.0	23.1	60.0	53.8	3.3	2.6
5	Давтлага авах	16.7	12.8	30.0	28.2	50.0	56.4	3.3	2.6
6	Чөлөөт цагаа өнгөрөөх	10.0	15.4	33.3	25.6	53.3	53.8	3.3	5.1
7	Дугуйланд хичээллэх	10.0	5.1	13.3	23.1	70.0	69.2	6.7	2.6
8	СӨУЗ-ийн ажилд оролцох	0.0	2.6	3.3	2.6	90.0	82.0	6.7	12.8

Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажилладаг зорилтот сургуулийн багш нарын үнэлгээгээр тусгай хэрэгцээт хүүхэдтэй ГСТ-өөр хичээллэх, хичээлийн хоцрогдол нөхөх, давтлага өгөх, хөгжүүлэх сургалт хийх, багшийн хөгжлийг дэмжих, эцэг эхтэй хамтран ажиллахад Хүүхэд хөгжлийн төв томоохон хувь нэмэр оруулсан гэж үзэж байна.

Хүүхэд хөгжлийн төвөөр үйлчлүүлснээр тусгай хэрэгцээт хүүхдүүдэд гарсан өөрчлөлт, үр дүнгийн талаар тусгай хэрэгцээт хүүхэдтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс авч үзвэл Хүүхэд хөгжлийн төвд ганцаарчилсан хичээл орох, хичээлээ давтах, хичээлийн хоцрогдол нөхөх, сэтгэл зүйч, багш нараасаа зөвлөгөө авах, чөлөөт цагаа өнгөрөөх тохиромжит орчин нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзсэн.

Хүснэгт 48. Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааны чиглэл, үр дүн

Чиглэл	Тусгай хэрэгцээт хүүхдийн үнэлгээ	Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажилладаг багш нарын үнэлгээ	
		4-5 дугаар ангийн багш	6-9 дүгээр ангийн багш
Тусгай хэрэгцээт хүүхдүүд ганцаарчлан хичээллэх, хичээлээ давтах	<ul style="list-style-type: none"> - Хичээлдээ сайжирч байгаа - Хичээлээ илүү ойлгодог болсон - Ганцаарчилж сурах боломжтой - Хичээл нь гоё байдаг - Хичээлээ давтдаг - Хичээлээ нөхдөг - Хоцрогдол нөхдөг - Бичих чадвар өөрчлөгдсөн 	<ul style="list-style-type: none"> - ГСТ-өөр хичээл ордог - Ганцаарчилж ажилладаг - Сурлагын хоцрогдолтой сурагчидтайгаа 7 хоногт 3 удаа хичээллэдэг - Сургалтын материал, хэрэглэгдэхүүн ашигладаг - Ойлгохгүй байгаа хичээлийг нь ойлгуулдаг 	<ul style="list-style-type: none"> - Ганцаарчилсан сургалт ордог - ГСТ-өөр хичээллэдэг - Сонгон суралцах хичээл ордог - Pearson хөтөлбөр ордог - Даалгавар, давтлага хийдэг - Хоцрогдолтой хүүхэдтэй ажилладаг - Ном, материал авч ашигладаг - Эрүүл мэндийн хичээл ордог
Сэтгэл зүйн дэмжлэг авах, хүүхэд хөгжүүлэх, нийгэмшүүлэх	<ul style="list-style-type: none"> - Сэтгэл зүйчтэй ярилцах гоё байдаг - Сэтгэлийн дэм авдаг. Чи чадна гэдэг - Сэтгэлийн тэнхээтэй болсон - Нам гүм, тухтай, чимээгүй - Гоё, сэтгэл ханамжтай байдаг болсон - Өөрийнхөөрөө байх боломжтой байдаг - Тайван хичээллэдэг 	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийг нийгэмшүүлэх - Орчиндоо дасгах ажил хийгддэг - Хүүхдүүд нээлттэй чөлөөтэй байдаг - Хүүхэдтэйгээ ярилцдаг - Зөвлөгөө өгнө 	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн ажилтантай ярилцуулдаг - Хүүхдүүдтэйгээ хамт чөлөөт цагийг өнгөрөөдөг - Хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэх сургалт, тоглоом ордог - Хэлний дасгалууд хийлгэдэг - Бие даалт хийлгэдэг
Чөлөөт цагаа өнгөрөөх, өөрийгөө хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Ном уншин ойлгосноо ярьж өгдөг - Номууд нь таалагдсан - Тоглох дуртай, тоглох нь таалагддаг - Олон шинэ найзуудтай болсон - Дуу дуулах нь таалагддаг 	<ul style="list-style-type: none"> - Тоглонгоо хөгжих хөтөлбөр хэрэгжүүлдэг - Тоглоомоор хөгжүүлэх, зураг зуруулах үйл ажиллагаа явуулдаг - Хөгжөөнт тоглоомоор дамжуулан хөгжүүлдэг - Сурагчдыг хөгжүүлэх үйл ажиллагаа хийдэг 	<ul style="list-style-type: none"> - 1, 3, 5 дахь өдрүүдэд тусгай хэрэгцээт хүүхдээ бусад хүүхдүүдтэй тоглоом тоглуулж хөгжүүлдэг - Дугуйлан хичээллүүлдэг - Гар урлалын дугуйлан ордог - Нээлттэй хичээл зааж туршлага судалдаг

5.3 ДЭМЖЛЭГИЙН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам”-ын 3.5-д “Хүүхдийг сургуульд тэгш хамран сургах, сургуулийн орчинд дасан зохицох, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшихэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэг бүхий “Дэмжлэгийн баг”-ийг сургуулийн захирлын тушаалаар байгуулж ажиллуулна” гэж заасан. Цаашилбал хууль эрх зүйн бусад баримт бичгүүдэд сургууль, цэцэрлэгийн дэмжлэгийн баг нь сургалтын байгууллага дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувийн онцлогт тохирсон хөтөлбөр хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах, тохирох хэрэглэгдэхүүн бэлтгэх, кейс хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр тэдний суралцах үйл ажиллагааг дэмжсэн олон талт арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг заасан байдаг.

Зорилтот сургуулиудад тусгай хэрэгцээт хүүхдийг боловсролд тэгш хамруулах зорилгоор байгуулагдсан дэмжлэгийн баг нь ажлын төлөвлөгөө гарган дараах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, чиглүүлэг хийж байна. Үүнд:

- Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжих, сурахад шаардлагатай сургалтын хөтөлбөр (ГСТ боловсруулах, хичээлийн агуулгыг тодорхойлох), хүүхдийн хэрэгцээнд суурилсан ялгаатай хичээл, агуулгыг сонгох
- Сурах бичиг, гарын авлага, хэрэглэгдэхүүнийг бэлтгэх
- Багш, эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн сурагчдад сургалт зохион байгуулах, багшийн арга зүйг тасралтгүй хөгжүүлэх
- Эцэг эх, асран хамгаалагчийн эерэг хандлага, нөлөөллийг дэмжих
- Тусгай хэрэгцээт хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх, хүндрэл бэрхшээлгүй сурч, хөгжих нөхцөл, орчны тохируулга хийх зэрэгт анхааран ажилласан байна.

Судалгаанд оролцсон багш нарын 88 хувь нь дэмжлэгийн багийн үйл ажиллагааг сайн, үр дүнтэй ажиллаж байна гэж дүгнэсэн байна. Дэмжлэгийн багийн зохион байгуулсан сургалтууд мэдээлэл сайтай, хүртээмжтэй зохион байгуулагдаж чадаж байгаа гэж багш нар үзэж байна. Харин 8.6 хувь нь дунд зэрэг, боломжийн гэж үнэлсэн бол 2.8 хувь муу буюу тааруу ажиллаж байна гэж үнэлжээ.

Зураг 37. Дэмжлэгийн багийн үйл ажиллагааны үнэлгээ, багш нар



... Дэмжлэгийн баг манай сургуульд 7 хүний бүрэлдэхүүнтэй байдаг. Улиралд нэг удаа ГСТ-өөр ажиллаж байгаа багш нарынхаа ажилд үнэлгээ хийдэг. Цаанаас өгдөг тодорхой хэмжээний урамшууллыг нь хяналт үнэлгээ хийсний үндсэн дээр өгдөг. Мөн тусгай хэрэгцээт хүүхдэд ахиц гарсан уу гэдгийг харахаас гадна ГСТ-ний зорилго биелж эсэхийг харгалзаж багш нарыгаа урамшуулаад явж байгаа.

Сургуулийн удирдлага, менежерүүдтэй хийсэн ФБЯ-аас, Ховд аймаг

... Сургуулийн багш нар туршлага солилцоод тэгш хамран сургах боловсролын талаар ойлголттой болж байна. Аутизм, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүй, сэтгэл зүйн бэлтгэл, чадвартай болж байгаа. Одоо бидэнд удирдлагын дэмжлэг хэрэгтэй байна. Удирдлага гэдэг чинь өөрөө маш том дэмжлэгийн баг байх ёстой. Загнадаг, шаарддаг биш зөвлөдөг, тусалдаг, дэмждэг удирдлагуудтай болмоор байна. Тэгж байж тэгш хамруулах боловсрол жинхэнэ утгаараа хэрэгжинэ.

Шалгуур үзүүлэлтийн түвшинд авч үзвэл суурь боловсролын түвшинд тэгш хамруулах боловсролын тогтолцоо бүрдсэн бөгөөд энэ чиглэлээр зохион байгуулсан нөлөөллийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэж байна. Жишээлбэл бүх хэлбэрийн сургалтуудад нөлөөллийн үйл ажиллагааг хэрхэн хийх талаар заахаас гадна төслийн хүрээнд бэлтгэсэн видео контентыг сурагчдад үзүүлж бусдыг хэрхэн хүндэлж ойлгох, ялгаварлан гадуурхахгүй байх талаар хэлэлцүүлэг өрнүүлжээ. Мөн бодлогын нөлөөллийн үйл ажиллагааг сошиал медиа кампанит аян, цуврал сургалт, уулзалт, хэлэлцүүлгийн хэлбэрээр зохион байгуулсан байна.

Сургууль, багш нарын зүгээс тэгш хамруулах боловсролын эрх зүйн баримт бичгийг уншиж судлах, бодлого боловсруулагчдын зүгээс хэрэгжүүлэх арга замыг хэлэлцүүлэх үйл ажиллагаа хангалттай хэмжээнд хийгдсэн байна. БШУЯ-ны мэдээллээр 2023 онд ЕБС-ийн 3304 тэгш хамруулах боловсролын мэргэжилтэн, багш, ажилчдын төлөөллийг тусгай хэрэгцээт суралцагчтай ажиллах чадавхжуулах сургалтад хамруулсан байна.

Тэгш хамруулах боловсролын чиглэлээр олон улсын байгууллага (ОУБ)-уудын Монгол улсад хэрэгжүүлж байгаа 7 төсөл, хөтөлбөр байна.⁸ Эдгээр төслүүдээс “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь - 2” төсөл нь суурь боловсролын түвшинд тэгш хамруулах боловсролын тогтолцоог бий болгох хүрээнд хууль эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, олон төрлийн бодлогын нөлөөллийн үйл ажиллагааг цогц байдлаар хэрэгжүүлсэн нь гол ялгарах онцлог болжээ. Мөн тэгш хамруулах боловсролыг хэрэгжүүлсэн туршлага, сургамжийг баримтжуулсан байдал суурь судалгаа хийгдсэн үетэй харьцуулахад нэмэгдсэн байна. Жишээлбэл төслийн хүрээнд 2023 онд БЕГ-ын Тэгш хамруулах боловсролын хэлтэстэй хамтран гаргасан “Боловсролын тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй ажиллаж буй сайн туршлага” эмхэтгэл, 2023 онд БЕГ-аас гаргасан “Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургаж буй сайн туршлага” илтгэлийн хураангуй, 2020 онд “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвслээс гаргасан “Тэгш хамруулан сургах боловсрол, хүүхэд хамгааллын сайн туршлага” судалгааны тайланг дурдаж болно.

8 ЖАЙКА “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” II шат, АХБ “Тэгш хамруулах боловсролын дэмжих” төсөл, Норвегийн тусламжийн байгууллага “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил” төсөл, НҮБ-ийн Хүүхдийн Сан “Тэгш хамруулсан олон нийтийн оролцоот сургууль” хөтөлбөр, GPE “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төсөл, МУБИС “Тэгш хамруулах багшийн боловсрол” төсөл

ДҮГНЭЛТ

Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд, ЕБС-ийн сурагчдын хувьд:

Сурагчдын харилцаа, тусгай хэрэгцээтэй найздаа хандах хандлага

- Тусгай хэрэгцээтэй найздаа ангийнхан нь тусалж, дэмжлэг үзүүлэх чадавхын хувьд бага ангийн хүүхдүүд дунд ангийнхнаас илүү байна. Тусгай хэрэгцээтэй найздаа ангийн сурагчид нь хичээлийг нь зааж өгөх, тусламж хэрэгтэй үед нь туслах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, хэрэгцээтэй зүйлсээ хуваалцах тусламж, дэмжлэгийг хамгийн их үзүүлж байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургууль, хичээлдээ явахад тулгарах бэрхшээл нь хүүхдүүдийн сөрөг хандлага, сургуульд ирж, очих зам муу, гэр хол, бие даан явж чадахгүй байх, хичээлийн хоцрогдол зэрэг байна. Тусгай хэрэгцээтэй найзад нь хамгийн их хэрэгтэй тусламж дэмжлэгийн тухайд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ойр дотно харилцах, ярилцах, хичээл, сурлагад нь тусалж дэмжих, эрүүл мэндэд нь анхаарах, ялгаварлан гадуурхахгүй байх үндсэн дэмжлэгүүд гэж ангийн сурагчид нь үзэж байна.
- Анги, сургууль дээр болсон зүйлийнхээ талаар дөрвөн хүүхэд тутмын нэг нь байнга гэр бүлийнхэнтэйгээ ярилцаж байгаа бол гурван хүүхэд тутмын нэг нь заримдаа, тал хувь нь хаяа болон ярилцдаггүй нь гэр бүлийнхний зүгээс хүүхдүүдтэйгээ ойр дотно ярилцах нь бага байгааг харуулж байна.
- 4-5 дугаар сурагчдад ангийн багш болон гэр бүлийнхэн нь тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж дэмжих талаар захиж тайлбарлах нь маш сайн байна. 6-9 дүгээр ангийн сурагчдын дийлэнх олонход нь багш, гэр бүл ойр дотнынхон нь тусгай хэрэгцээтэй хүүхдэд тусалж, дэмжих талаар тайлбарлаж захидаг байна.
- Дунд ангийн хоёр сурагч тутмын нэг нь тэгш хамруулах боловсролын талаарх сургалтад хамрагдсан ба тэдний гурван сурагч тутмын нэгт тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлогийн талаар ойлголт, мэдлэг нь мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, үлдсэн хэсэгт нь мэдлэг, ойлголт нь өмнөхөөсөө нэмэгдэж сайжирсан байна.

Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг ойлгох дэмжих байдал

- Тусгай хэрэгцээтэй гурван хүүхэд тутмын хоёр нь бага ангиас дунд ангид дэвшин суралцахтай холбоотой сургууль, багш, эцэг эхээс дэмжлэг үзүүлж бэлтгэл хангаж байна. Тэд анги дэвшин суралцахад бэлтгэн ном уншиж, хичээлээ сайн хийж, сэтгэл зүйгээ бэлдэж, нэмэлт давтлага авах бэлтгэлүүдийг хийж байна.
- Анги удирдсан багш нар бүх хүүхэдтэй адил тэгш хандаж чаддаг гэж сурагчид тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй харилцах багш нарын харилцааг дүгнэж байна.
- 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд бүгдэд нь аав ээж, ах эгч, гэр бүлийнхэн нь байнга тусалж дэмжиж байгаа бол хоёр хүүхэд тутмын нэгт нь ангийн хүүхдүүд нь байнга тусалж дэмжиж байна. 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээтэй гурван хүүхэд тутмын нэгт нь гэр бүл, ангийн хүүхдүүдийн тусламж, дэмжлэгийг авч байгаа нь анги ахих тутам тэдний бие даах чадвар нэмэгдэж, гэр бүлийнхний анхаарал, оролцоо буурч байгааг харуулж байна.
- 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээтэй гурван хүүхэд тутмын нэг нь ангийнхаа бүх хүүхэдтэй ойр дотно харилцаж, тал хувь нь ангийнхаа заримтай л ойр харилцаж байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд сургуулийн орчинд тусламж хүсэхдээ хамгийн түрүүнд ангийн

багшдаа ханддаг бол дараа нь гэр бүл найз, ангийн хүүхдүүддээ хандаж байна. Тусламж хүсэхдээ сургалтын менежер, сургуулийн ажилтнууд /номын санч, эмч, жижүүр/, нийгмийн ажилтнуудад хандахаасаа илүү гэр бүл, найз, ангийн хүүхдүүддээ түрүүлж хандах хандлагатай байна.

- Бага ангиас дунд ангид дэвшин суралцахад тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд хичээлийн тоо нэмэгдэх, даалгаврын ачаалал ихсэх, олон багштай харилцах, хичээлээ ойлгохгүй байх нь бэрхшээл үүсгэдэг байна.

ЕБС, багш нарын тэгш хамруулах боловсролын чиглэлээрх үйл ажиллагаа:

- Анги удирдсан багш нар болон анги удирдаагүй багш нарын тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн талаарх мэдлэг ойлголт сайжирсан байна.
- Багш нар тусгай хэрэгцээтэй хүүхдийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээр хязгаарлахгүйгээр туслалцаа дэмжлэг шаардлагатай, суралцахуйн бэрхшээлтэй, бусдаас ялгаатай хүүхэд зэргээр ойлгох болж тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголтын хүрээ өөрчлөгдсөн байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой гэж үзсэн багш нарын эзлэх хувь нэмэгдсэн байгаа ба тусгай хэрэгцээний 9 төрлөөс 7 төрлийн тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой гэж багш нарын 70-аас дээш хувь нь үзсэн байна. Энэ нь багш нарын дунд тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, ялгаатай байдлын талаарх мэдлэг ойлголт сайжирч, тэднийг сургах мэдлэг, ур чадварт нь ахиц гарч, хүлээн авах боломжтойг харуулж байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой гэж багш нар үзэж байгаа ч сургуульд бэлтгэх, өөртөө үйлчлэх, нийгэмшүүлэх чиглэлээр СӨБ-д тэгш хамруулах шаардлагатай гэж үзэж байна.
- Багш нар тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах мэдлэг, ур чадвараа гэж үнэлж байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх мэдлэг ойлголт, ажиллах ур чадвараа муу болон мэдэхгүй гэж дүгнэсэн багш нарын эзлэх хувь тун бага байна.
- Багш нарын тэгш хамруулах боловсрол болон тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголт, тэднийг илрүүлэх, ГСТ-г хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ур чадварт ахиц гарч сайжирсан байна.
- Зорилтот сургуулийн багш нарын тэгш хамруулах боловсролын чиглэлээрх сургалтад хамрагдалт сайн байгаа ба ялангуяа тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг багш нар бүгд сургалтад хамрагдсан байна.
- Төслийн сургалтуудаас сурч эзэмшсэн мэдлэг, чадвараа тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн сургалтын үйл ажиллагаанд хамгийн үр дүнтэйгээр ашиглаж байгаа нь 1. ГСТ-г боловсруулах, хэрэгжүүлэх арга зүй 2. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн сургалтын арга зүй 3. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаарх ойлголт, хандлага 4. Тусгай хэрэгцээтэй хүүхдийн эцэг эхтэй ажиллах ур чадварын талаарх мэдлэг ойлголт байна.
- ГСТ-ний хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийн Дэмжлэгийн багаас улиралд нэг удаа багш нарын ажлыг дүгнэн тусгай хэрэгцээтэй хүүхдэд гарч буй ахицыг үндэслэн багш нарт урамшуулал олгож байна. Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарын ажлын ачаалал их байгаа хэвээр байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад сургууль, багшийн зүгээс хангаж буй бэлтгэл ажлыг бага ангийн багш нар сайн ханган ажиллаж байна. (7 үзүүлэлтээ 6 үзүүлэлтийн бэлтгэлийг 80-аас дээш хувьтай байна.)
- Бага ангийн багш нь тусгай хэрэгцээтэй хүүхдийг 5 дугаар анги төгсөхөд дунд ангийн багштай холбоо тогтоож, хүүхдээ хүлээлгэж өгөх бэлтгэл ажлыг сайн хийж байна.

- Тусгай хэрэгцээтэй хүүхдэд бага ангиас дунд ангид дэвшин суралцахад бэлтгэн сургууль, багшийн зүгээс сэтгэл зүйн дэмжлэгийг ангийн багш нь хамгийн их үзүүлж байгаа ба нийгмийн ажилтан, сургалтын менежер, сэтгэл зүйч нар дараагийн сэтгэл зүйн дэмжлэгийг үзүүлж байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдэд анги дэвшин суралцахад ангийн багшийн зүгээс сэтгэл зүйн дэмжлэгийг үзүүлэхдээ эцэг эхэд нь зөвлөгөө өгөх, дунд ангийн багш нарт нь захих, дасан зохицохуйтай холбоотой ажлууд зохион байгуулах, тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ярилцах зэрэг дэмжлэгийг 4-5 дугаар ангийн гурван хүүхэд тутмын нэгт үзүүлж байна.
- Төслийн хүрээнд тусгай хэрэгцээтэй хүүхдийг сургах чиглэлээр бусад ЕБС-иудын багш нартай туршлага судлах, туршлага солилцох үйл ажиллагаанд 4-5 дугаар ангийн анги удирдсан 3 багш тутмын хоёр нь, 6-9 дүгээр ангийн хоёр багш тутмын нэг нь, анги удирдаагүй багш нарын гурван багш тутмын нэг нь хамрагдсан байна.

Тусгай хэрэгцээтэй хүүхдийн анги дэвших, суралцах үйл явцад үзүүлж буй эцэг эхийн оролцоо, тусламж дэмжлэг үзүүлэх чадавх:

- Эцэг эхчүүдийн тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголт сайжирсан байгаа ба бага ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн дийлэнх олонх нь (81.8 хувь), мөн дунд ангийн эцэг, эхчүүд ч мөн адил (87.5 хувь) зөв ойлголттой байна. Тусгай хэрэгцээтэй хүүхдийг ердийн сургуульд сургах боломжтой гэж дунд ангийн эцэг, эхчүүдийн дийлэнх олонх нь үзэж байна.
- Эцэг, эхчүүдийн дунд зохион байгуулсан тэгш хамруулах боловсролын чиглэлээрх сургалтад бага дунд ангийн эцэг, эхчүүдийн хоёр хүн тутмын нэг нь хамрагдсан байна. Сургалтад хамрагдсан 4-5 дугаар ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн 86.4 хувь нь тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголтоо хүүхдүүдтэйгээ хуваалцсан бол, 6-9 дүгээр ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн 75 хувь нь хүүхдүүдтэйгээ хуваалцсан байна.
- Эцэг, эхчүүдийн тэгш хамруулах боловсролын чиглэлээр хүүхдийнхээ сургууль, ангиас зохион байгуулсан үйл ажиллагаануудад оролцсон байдлыг авч үзвэл бага, дунд ангийн хүүхэдтэй эцэг, эхчүүд бүгд хүүхдийнхээ ангийн багштай байнга харилцаатай хамтран ажиллаж, хүүхдийнхээ ангийн үйл ажиллагаанд бусад эцэг, эхчүүдийн хамт оролцож байна. Мөн гурван эцэг эх тутмын хоёр нь сургалтын орчныг сайжруулах, бусад эцэг, эхчүүдтэй туршлага солилцох, тэгш хамруулах боловсролыг олон нийтэд таниулах үйл ажиллагаанд оролцсон байна. Эндээс үзвэл сургуулиас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцож байгаа ч эцэг, эхчүүдийн зүгээс өөрсдийн оролцоонд суурилан санаачилга өрнүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаа бага байна.
- Эцэг, эхчүүд хүүхдийнхээ сурч боловсроход нь дэмжлэг үзүүлэхдээ хүүхдийнхээ сурах орчин, нөхцөлийг хангахад илүү анхаарч харилцан ярилцах, хамт байх, даалгавраа хийхэд нь туслах зэрэг хүүхэдтэйгээ харилцах, хамт байх тал дээр сул оролцоотой байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийн сурч хөгжихөд эцэг, эхчүүдийн дэмжлэг үзүүлэх чадавх маш их өөрчлөгдсөн болон ер нь өөрчлөгдсөн гэж үзсэн хувь нийт эцэг, эхчүүдийн 85 хувийг эзэлж байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сурч, хөгжихөд нь эцэг, эхчүүдийн дэмжлэг үзүүлэх чадавхад гарсан гол өөрчлөлтүүд нь (a) багш эцэг, эхчүүдийн хамтын ажиллагаа сайжирсан (b) эцэг, эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдэдээ тавих анхаарал нэмэгдсэн, (c) эцэг, эхчүүдийн сэтгэл зүй, хүүхдээ сурч хөгжихөд нь итгэх итгэл нэмэгдсэн (d) эцэг, эхчүүдийн хүүхдээ хөгжүүлэх хүсэл эрмэлзэл нэмэгдсэн зэрэг байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг эцэг эх нь дунд ангиас сургуулиас гаргах нь багасаж, дунд анги руу нь оруулах хандлага нэмэгдсэн байна.
- Анги удирдсан багш нарын үзсэнээр бага, дунд ангийн эцэг, эхчүүдийн тусгай хэрэгцээтэй хүүхдэдээ сурч, хөгжихөд дэмжлэг үзүүлэх чадавх сайжирч, өөрчлөгдсөн байна.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг илрүүлэх, оношлох тал дээр зарим эцэг, эхчүүдийн хандлага

бэрхшээлтэй байгаа ба хөнгөн хэлбэрийн, оюуны, суралцахуйн болон зан үйлийн зарим бэрхшээлүүдийг эцэг, эхчүүд оношлуулахаас татгалзах, хүлээн зөвшөөрөхгүй байх, цаг алдан хайхрамжгүй хандах, эрүүл мэндийн үзлэгт хамруулахгүй байх зэрэг хандлагууд элбэг байна.

Бодлого хэрэгжилтийн түвшинд:

- Төсөл нь сургуульд түшиглэсэн тэгш хамруулах боловсролын цогц загвар бий болгох, орон нутгийн болон үндэсний түвшинд тэгш хамруулах боловсролын бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан байна.
- Боловсролын салбарт хамаарах эрх зүйн баримт бичгүүдэд тусгай хэрэгцээт хүүхдийн асуудал тусгагдсан байна.
- Сургууль, багш нарын зүгээс эрх зүйн баримт бичгийг уншиж судлах, бодлого боловсруулагчдын зүгээс хэрэгжүүлэх арга замыг хэлэлцүүлэх үйл ажиллагаа өмнө нь дутагдалтай байсан бол өнгөрсөн 2 жилийн хугацаанд хангалттай түвшинд хийгдсэн байна.
- Батлагдан гарсан дүрэм, журам цөөнгүй, хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх заалт оруулсан байгаа тул тэгш хамруулах боловсролын чиглэлээр батлагдсан дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийгдэх эхлэл тавигдсан байна.
- Тэгш хамруулах боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн туршлага, сургамжийг баримтжуулсан тайлан, мэдээ 2021-2023 онд нэмэгдсэн байсан ба төслийн зүгээс болон тэгш хамруулах боловсролын чиглэлээр бусад ОУБ-уудын Монгол улсад хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд мөн адил баримтжуулалт хийгджээ.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

ЕБС-ийн сурагчдын хувьд:

- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд тулгарч буй бэрхшээлүүдээ багш, эцэг эхдээ нээлттэй илэрхийлэн ярилцах, өөрийгөө илэрхийлж сурахад нь эцэг эх, багш нар туслах ажлыг зохион байгуулах.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийн сургуульдаа явах зам муу, гэр хол, бие даан явахад хэцүү байгаа нийтлэг бэрхшээлийг сургууль, эцэг, эхчүүдийн хамтын ажиллагааны дүнд шийдвэрлэх.
- Тусгай хэрэгцээтэй сурагчдын хичээлийн хоцрогдлыг арилгах, хичээл нөхөх, давтах зэрэг сургалтын үйл ажиллагаанд туслах, зөвлөгөө өгөхөд ангийн сурагчдыг татан оролцуулах.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн эрүүл мэнд, эмчилгээ, сэргээн засал, хэл яриа, хөдөлгөөний засал, оношилгоо хийлгэх зэрэгт сургуулийн зүгээс эцэг, эх гэр бүлтэй нь тулж ажиллах.
- Ангид зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд тусгай хэрэгцээтэй хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх.
- СӨУЗ-ын үйл ажиллагаанд тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн оролцоог хангах үйл ажиллагааг тусгах, санаачилга өрнүүлэх, үйл ажиллагааг нь дэмжих.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн сонирхол, ур чадварыг нь нээн хөгжүүлэх дугуйлан ажиллуулах.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн онцлог, ялгаатай байдлын талаар сурагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд цахим орчин дахь тэгш байдал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хүний оршихуйн олон янз байдлын тухай, тусгай хэрэгцээтэй хүмүүсийн амжилттай кейс, түүхүүдийн тухай албан ёсны эрх бүхий подкаст, баримтат нэвтрүүлэг, TEDx-ийн илтгэлүүдийг сонгон сонгох, мэтгэлцээн, ярилцлага өрнүүлэх, илтгэл тавих, эссэ бичих зэрэг хэлбэрээр дунд боловсролын түвшинд тохирсон ажлыг зохион байгуулах.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийн бага ангиас дунд анги руу дэвшин суралцахад хичээлийн тоо нэмэгдэх, даалгаврын ачаалал ихсэх, олон багштай харилцах, хичээлээ ойлгохгүй байх бэрхшээлүүдийг даван туулахад нь тусалж дэмжих.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг дээрэлхэх, ялгаварлан гадуурхах аливаа хэлбэрийг таслан зогсооход анхаарах, сургуулийн нийт сурагчдын дунд үе тэнгийнхний дээрэлхэлтийн эсрэг сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах.

Ерөнхий боловсролын сургууль, багш нарын түвшинд

- Багш нарын шилжилт хөдөлгөөнтэй уялдуулан шинээр шилжин ирсэн багш нарын тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх.
- Тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээтэй хүүхдийн талаар сургалтад багшийн удирдсан ангийн хүүхдийн онцлогийг таньж илрүүлэх, түүнд тохирсон хөтөлбөр арга зүй хэрэгжүүлэх ажлыг хослуулан зохион байгуулах.
- Тэгш хамруулах боловсролын тохирох хэрэглэгдэхүүнийг сургуулийн удирдлага судалгаа мэдээлэлд үндэслэн нэмэгдүүлэх.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг сурахад дэмжлэг болох сургалтын нэмэлт хэрэгсэл, тоног

төхөөрөмж, дэд бүтцийг сайжруулахад орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах.

- Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй гэр бүл хүүхдийн нийгэмших, бие даах чадварыг хөгжүүлэхэд сургуулийн Дэмжлэгийн багтай нягт хамтран ажиллах зохион байгуулалтыг сургуулиас зохион байгуулах.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг дунд ангид дэвшин суралцахад гарч болох суралцахуйн бэрхшээл, эрсдэлийг илрүүлэх, судалгаанд үндэслэн бодитой үр дүнтэй үйл ажиллагаа зохион байгуулж ахиц өөрчлөлтийг тооцдог байх.
- Тусгай хэрэгцээтэй хүүхэд дунд ангид ороход үе тэнгийнхэн, найз нөхдөөсөө хөндийрөх, анги хамт олны дэмжлэг, туслалцааг авах дургүй болох зэрэг шилжилтийн нас болон нийгэмшлийн үйл явцад нь хэрхэн анхаарах ойлголт, мэдлэгийг анги удирдсан багш нарт өгөх.
- ГСТ-г хэрэгжүүлсэн бага ангийн багш нарын туршлага, сургамжаа хуваалцах, хэлэлцүүлэх үйл ажиллагаа өрнүүлэх, идэвхжүүлэх.
- Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт ажлын ачаалал их байгаа нь цаашдын сургалтын чанарыг тогтвортой хадгалахад нөлөөлөх тул сургууль, бага боловсролын бодлого, менежментийн түвшинд зохицуулалт хийх.
- Зорилтот сургуулиуд багш нарт бий болсон үйл ажиллагааны туршлагыг баримтжуулах, түгээн дэлгэрүүлэх, сургууль хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.
- Тусгай сургууль болон ердийн сургуулийн хамтын ажиллагааг зохион байгуулалттай тогтмол өрнүүлэх.

Эцэг эх, олон нийтийн түвшинд

- Тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдалтын талаар судалгааг хийн сургалтад хамрагдаагүй эцэг, эхчүүдэд тэгш хамруулах боловсролын талаарх мэдлэг, ойлголтыг өгөх, таниулах.
- Сургууль, багшийн зүгээс эцэг, эхчүүдэд хүүхдээ сэтгэл зүйн хувьд ойлгон дэмжихэд чиглэсэн сургалт зөвлөгөө зохион байгуулах.
- Хүүхдүүдтэйгээ чөлөөт цагаараа ярилцаж, цагийг хамт өнгөрүүлэх, даалгавар хийхэд нь туслах чиглэлээр эцэг эхийн оролцоо дэмжлэгийг нэмэгдүүлэхэд анхаарах.
- Сургуулиуд эцэг эх, хүүхдийн хамтын оролцоотой үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх
- Тусгай хэрэгцээтэй хүүхэд бага ангиас дунд ангид дэвшин суралцахад эцэг, эхчүүд дэмжлэг үзүүлэх талаар хэлэлцүүлэг, ярилцлагыг сургуулиас зохион байгуулах.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдийг нийгэмшүүлэх, бие даах чадварыг хөгжүүлэхэд нь гэр бүлийн зүгээс дэмжих, эцэг эхчүүдийн өөрсдийн санаачилга, оролцоонд суурилсан үйл ажиллагааг сургууль, багш нартай хамтран зохион байгуулах.
- Эцэг, эхчүүд тусгай хэрэгцээтэй хүүхдээ сурч хөгжих орчин нөхцөлөөр хангахаас гадна хүүхдийнхээ сонирхол, авьяасыг илрүүлэх, хөгжүүлэхэд нь дэмжих, багштай нь хамтран ажиллах.
- Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдтэйгээ чөлөөт цагаараа ярилцах, цагийг хамт өнгөрүүлэх нь хүүхдийн нь хөгжил, нийгэмшилд ямар ач холбогдолтой болохыг ойлгуулах, гэр бүлийн анхаарал дэмжлэгийг нэмэгдүүлэх.
- Тэгш хамруулах боловсролын чиглэлээр сургууль, ангиас зохион байгуулсан үйл ажиллагаанд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх.

- Сургуулийн орчин дахь тусгай хэрэгцээтэй хүүхдийн аюулгүй байдал, тэдэнд тулгарч байгаа бэрхшээлүүдийг илрүүлэх, шийдвэрлэхэд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх.

Бодлого хэрэгжилтийн түвшинд

- Тусгай хэрэгцээт хүүхдийн бүртгэлийг бодлогын түвшинд цогц болгоход анхаарал хандуулах: Бүртгэл мэдээллийн систем дээрээ ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа хүүхэд гэдэг агуулгаас гадна боловсролын гадна орхигдсон хүүхэд гэж оруулсан байгаа нь сайн боловч цаашид ЭМЯ, ХНХЯ-тай хамтран цогц болгох.
- Батлагдан гарсан эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ, мониторинг хийх, хэрэгжүүлэх явцад гарсан хүндрэл бэрхшээлийг үндэсний түвшинд хэлэлцүүлэн зарим зохицуулалтыг сайжруулах.
- Мөрдөгдөж буй бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн хоорондын уялдаа холбоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, үр дүнд хүргэх. Үүнд тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн статистик мэдээллийг боловсронгуй болгох, тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлж буй хувийн байгууллагуудад нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар санхүүжилт олгох асуудлыг салбар дунд нь орхигдуулалгүйгээр шийдвэрлэх.
- Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт олгох урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, урамшууллыг нэмэгдүүлэх, туслах багш ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх.
- 2019 оноос хойш боловсруулсан бодлогын баримт бичгүүд ОУБ-ууд, ялангуяа ХИС-ийн үүрэг оролцоо өндөр байсныг чанарын судалгааны оролцогчид дурдаж байсан ба цаашид тусгай хэрэгцээт хүүхдийг боловсролд тэгш хамран сургах чиглэлээр ОУБ-уудтай нягт хамтран ажиллах, оролцоог хангах.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журам”-д Дэмжлэгийн багийн үүрэг, оролцооны талаар дэлгэрэнгүй тусгах, сургуулийн удирдлагыг Дэмжлэгийн багийн голлох үүрэгтэй оролцогч тал болгох, захирал, эрхлэгчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тэгш хамруулах боловсрол, дэмжлэгийн багийн үйл ажиллагааг тусгах.

ХАВСРАЛТ

Хүснэгт 49. 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээт боловсрол шаардлагагүй сурагчдын түүвэр

1-р жил	Тоо	Хувь	2-р жил	Тоо	Хувь
79-р сургууль, БЗД	1	2.3	Амгалан цогцолбор сургууль, БЗД	3	7
127-р сургууль, БЗД	2	4.7	30-р сургууль, БЗД	4	9
37-р сургууль, ЧД	3	7	61-р сургууль, ЧД	4	9.3
49-р сургууль, ЧД	3	7	39-р сургууль, ЧД	3	7
65-р сургууль, СХД	2	4.7	76-р сургууль, СХД	4	9.3
67-р сургууль, СХД	2	4.7	9-р сургууль, СХД	3	7
2-р сургууль, Өвөрхангай	3	7	1-р сургууль, Өвөрхангай	2	4.7
7-р сургууль, Ховд	1	2.3	3-р сургууль, Ховд	3	7
Нийт	17	40		26	60

Хүснэгт 50. 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээт боловсрол шаардлагагүй сурагчдын түүвэр

1-р жил	Тоо	Хувь	2-р жил	Тоо	Хувь
79-р сургууль, БЗД	4	9.1	Амгалан цогцолбор сургууль, БЗД	3	6.8
127-р сургууль, БЗД	2	4.5	30-р сургууль, БЗД	3	6.8
37-р сургууль, ЧД	2	4.5	61-р сургууль, ЧД	4	9.1
49-р сургууль, ЧД	1	2.3	39-р сургууль, ЧД	2	4.5
65-р сургууль, СХД	2	4.5	76-р сургууль, СХД	3	6.8
67-р сургууль, СХД	2	4.5	9-р сургууль, СХД	3	6.8
2-р сургууль, Өвөрхангай	4	9.1	1-р сургууль, Өвөрхангай	2	4.5
7-р сургууль, Ховд	3	6.8	3-р сургууль, Ховд	4	9.1
Нийт	20	45		24	55

Хүснэгт 51. 4-5 дугаар ангийн тусгай хэрэгцээт хүүхдийн түүвэр

1-р жил	Тоо	Хувь	2-р жил	Тоо	Хувь
79-р сургууль, БЗД	1	3.3	Амгалан цогцолбор сургууль, БЗД	3	10.0
127-р сургууль, БЗД	2	6.7	30-р сургууль, БЗД	4	13.3
37-р сургууль, ЧД	2	6.7	61-р сургууль, ЧД	2	6.7
49-р сургууль, ЧД	2	6.7	39-р сургууль, ЧД	2	6.7
65-р сургууль, СХД	1	3.3	76-р сургууль, СХД	0	0.0
67-р сургууль, СХД	3	10.0	9-р сургууль, СХД	2	6.7
2-р сургууль, Өвөрхангай	1	3.3	1-р сургууль, Өвөрхангай	1	3.3
7-р сургууль, Ховд	1	3.3	3-р сургууль, Ховд	3	10.0
Нийт	13	43		17	57

Хүснэгт 52. 6-9 дүгээр ангийн тусгай хэрэгцээт хүүхдийн түүвэр

1-р жил	Тоо	Хувь	2-р жил	Тоо	Хувь
79-р сургууль, БЗД	2	5.1	Амгалан цогцолбор сургууль, БЗД	3	7.7
127-р сургууль, БЗД	2	5.1	30-р сургууль, БЗД	3	7.7
37-р сургууль, ЧД	1	2.6	61-р сургууль, ЧД	2	5.1
49-р сургууль, ЧД	1	2.6	39-р сургууль, ЧД	2	5.1
65-р сургууль, СХД	5	12.8	76-р сургууль, СХД	5	12.8
67-р сургууль, СХД	4	10.3	9-р сургууль, СХД	4	10.3
2-р сургууль, Өвөрхангай	0	0.0	1-р сургууль, Өвөрхангай	1	2.6
7-р сургууль, Ховд	2	5.1	3-р сургууль, Ховд	2	5.1
Нийт	17	44		22	56

Хүснэгт 53. Багш нарын түүвэр

1-р жил	Тоо	Хувь	2-р жил	Тоо	Хувь
79-р сургууль, БЗД	13	6.1	Амгалан цогцолбор сургууль, БЗД	17	8.0
127-р сургууль, БЗД	15	7.0	30-р сургууль, БЗД	16	7.5
37-р сургууль, ЧД	11	5.2	61-р сургууль, ЧД	13	6.1
49-р сургууль, ЧД	12	5.6	39-р сургууль, ЧД	12	5.6
65-р сургууль, СХД	14	6.6	76-р сургууль, СХД	16	7.5
67-р сургууль, СХД	14	6.6	9-р сургууль, СХД	17	8.0
2-р сургууль, Өвөрхангай	12	5.6	1-р сургууль, Өвөрхангай	7	3.3
7-р сургууль, Ховд	10	4.7	3-р сургууль, Ховд	14	6.6
Нийт	101	47		112	53



Save the Children

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn

📘 Save the Children in Mongolia

🐦 Save the Children MN

📷 [Savethechildren.mongolia](https://www.instagram.com/Savethechildren.mongolia)